

**ХҮНИЙ ЭРХИЙН ЭЭЛЖИТ ТҮГЭЭМЭЛ  
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**


**МОНГОЛ УЛСЫН ДУНД ХУГАЦААНЫ  
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

Хүний эрхийн ТББ-уудын Форумын тайлан

2018 оны 5-р сар

## Нэг. ЕРӨНХИЙ ТОЙМ

Монгол Улс хүний эрхийн төлөв байдлаа НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит түгээмэл хэлэлцүүлэг механизмаар 2 дох удаа хэлэлцүүлж нийт 164 зөвлөмж авснаас 150 зөвлөмжийг хэрэгжүүлэхээр үүрэг амлалт аваад байна. Хүлээн авсан зөвлөмжийн хэрэгжилтийн тухай мэдээллийг дараах графикаас үзнэ үү.



## Хоёр. ТАНИЛЦУУЛГА

Монгол Улс НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит түгээмэл хэлэлцүүлэгт 2 дахь удаа орж, 2015 оны 5-р сарын 5-ны өдөр НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Нэгдсэн чуулганы үеэр 150 зөвлөмжийг хэрэгжүүлэхээр үүрэг амлалт авсан билээ. Үлдсэн 14 зөвлөмж нь УИХ-ын хууль тогтоох эрх мэдэлд хамаарах тул хэрэгжүүлэх боломжгүй хэмээн татгалзсан юм. Эхний хэлэлцүүлгийн дараа зөвлөмжийн орчуулга дээр төр, төрийн бус байгууллага зөрүүтэй байр суурьтай байсан нь хэрэгжилтийн шатанд хүндрэл учруулсан тул, хоёр дахь хэлэлцүүлгийн дараа зөвлөмжийн орчуулгыг нэгтгэх тухай зөвлөлдсөний дагуу Гадаад харилцааны яам орчуулгыг хийж, иргэний нийгмийн байгууллагатай зөвшилцсөний дүнд эцэслэсэн.

Үүний дараа зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулах шатанд мөн иргэний нийгэмтэй зөвшилцсөн нь өмнөх алдаагаа залруулах сайн туршлага болсон юм. Төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газар 2016 оны 4-р сарын 11-ний өдөр 204 дугаар тогтоолоор баталсан. Онцлог нь зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Орон тооны бус зөвлөлийг Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ахлуулж, бүх яамны Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулан байгуулсан явдал юм. Тус төлөвлөгөөний дагуу зөвлөмжийн хэрэгжилтийн дүнд хугацааны тайланг 2018 оны 1 дүгээр сард НҮБ-д илгээхээр үүрэг болгохын зэрэгцээ зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн 1-р сард багтаан Орон тооны бус зөвлөлд танилцуулж, тайланг тухайн жилийн 2-р сард багтаан Засгийн газарт танилцуулахаар заасан нь зөвлөмжийг хэрэгжүүлэхэд түлхэц болох зохицуулалт болсон. Зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хамаарал бүхий бүх яам, агентлагийг төлөвлөгөөнд тусгасан.

Засгийн газар хэрэгжүүлэхээр үүрэг амлалт аваагүй 14 зөвлөмжтэй холбоотой ажил хийгдээгүй тул энэ тайланд холбогдох мэдээллийг тусгаагүй болно.

### **Гурав. АРГА ЗҮЙ**

Зөвлөмжийн хэрэгжилтийн дүнд хугацааны тайлан бэлтгэх хүрээнд Монголын Хүний эрхийн ТББ-уудын Форум (ХЭФ) нь иргэний улс төрийн эрх, эдийн засаг, нийгэм соёлын эрх, хүүхэд, эмэгтэйчүүд, бусад бүлгийн эрх гэсэн 5 бүлэгт хуваагдан ажилласан.

Зөвлөмж авсан даруйд ННФ нь UPR-Info олон улсын ТББ-тай хамтран 2015 оны 5-р сард “UPR зөвлөмжийн хэрэгжилтийн стратеги, төлөвлөгөө” боловсруулах семинарыг зохион байгуулж, энэ үеэр хэрэгжилтээс хүлээж буй үр дүн, хэрэгжүүлэх чиглэлээр ажиллах стратеги төлөвлөгөөгөө хэлэлцсэн. UPR зөвлөмжийн дүнд хугацааны хэрэгжилтийн тайлан бэлтгэх ажлыг 2017 оны 10-р сараас эхлүүлсэн бөгөөд Ажлын хэсгүүд мэдээлэл хүссэн албан бичгийг холбогдох бүх яам, агентлагт хүргүүлсэн юм. Ирүүлсэн мэдээлэлд тулгуурлан төрийн байгууллагатай зөвлөлдөх уулзалтыг 2018 оны 2-р сарын 2-нд зохион байгуулсан бөгөөд энэ уулзалтыг ХЗДХЯ, ГХЯ, ХЭҮК-той хамтран зохион байгууллаа. Мөн зөвлөмжийн хүрээнд 21 аймагт хэлэлцүүлэг өрнүүлэхийг зорьсон бөгөөд энэ ажлыг ХЭҮК-ын орон нутгийн ажилтанд удирдамж өгч хийлгэсэн бөгөөд нийт 19 аймгийн төр, төрийн бус байгууллага, иргэний төлөөлөл 322 хүн хэлэлцүүлэгт хамрагдсан. Хэлэлцүүлгээр хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, гэр бүлийн хүчирхийлэл, эрүүл мэндээ хамгаалуулах эрх буюу орон нутагт тулгамдаж буй асуудлыг авч хэлэлцсэн юм.

ХЭФ нь UPR-Info олон улсын ТББ-тай хамтран цуврал хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд энэ хүрээнд баруун, зүүн, төв, говийн бүсийн 4 аймагт бүсийн хэлэлцүүлэг, үндэсний хэмжээний 2 хэлэлцүүлэг зохион байгууллаа. Үүний дүнд зөвлөмжийн хэрэгжилтийн асуудлаар үндэсний хэмжээний мэдээллийг цуглуулах таатай боломж бүрдсэн. Бүсийн хэлэлцүүлэгт ХЗДХЯ, ГХЯ, ХЭҮК-ын холбогдох албан тушаалтан оролцож, өөрсдийн зүгээс зөвлөмжийн хэрэгжилтийн явцын тухай мэдээлэл танилцуулсан нь ач холбогдолтой байлаа. Бүсүүдэд зохион байгуулсан хэлэлцүүлэгт орон нутгийн төр, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөл нийт 130 орчим хүн оролцсон юм. UPR механизмын тухай орон нутгийн иргэдийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэхэд хэлэлцүүлгүүд ач холбогдолтой байлаа. Дээр дурдсан хэлэлцүүлгийн дүнд UPR зөвлөмжийн дүнд хугацааны тайлангийн төслийг эцэслэн боловсруулж, Үндэсний дүгнэлт уулзалтыг төр, төрийн бус байгууллага, элчин сайдын яамдын төлөөлөл 100 орчим хүний дүнд зохион байгуулсан нь тайланд холбогдох талуудын санал, шүүмжийг авахад ач холбогдолтой боллоо.

Зөвлөмжийн хэрэгжилтийн байдлыг “хэрэгжсэн”, “хэрэгжих шатанд”, “хэрэгжээгүй” гэсэн гурван үзүүлэлтээр дүгнэлээ. Зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэхдээ UPR-Info ОУБ-тай хамтран 2015 оны 5-р сард зохион байгуулсан семинараас гаргасан “UPR зөвлөмжийг хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт, стратеги”-д тулгуурласан болно.

<sup>1</sup> НҮБ-ын гишүүн улсаас өгсөн зөвлөмжийг бүрэн агуулгаар нь хэрэгжүүлсэн гэж үзсэн тохиолдолд “хэрэгжсэн”, зарим хэсгийг хэрэгжүүлсэн, үр дүн нь хараахан тодорхой биш тохиолдлыг “хэрэгжих шатанд”, зөвлөмжийн үндсэн агуулгыг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой алхам хийгээгүй гэж үзсэн тохиолдолд “хэрэгжээгүй” гэсэн дүгнэлт хийсэн. Тухайлбал, тодорхой хүний эрхийн асуудлаар хууль батлах тухай зөвлөмжийн хэрэгжилттэй холбогдуулан “хэрэгжих шатанд”, “хэрэгжсэн” гэсэн үзүүлэлтийн аль алиныг тавих тохиолдол гарсан билээ. Үүнийг тайлбарлавал, тодорхой нэг асуудлыг гэмт хэрэгт тооцох тухай зөвлөмжийн тухайд “Эрүүгийн хууль”-д тухайн асуудлыг гэмт хэрэгт тооцсон бол зөвлөмжийг “хэрэгжсэн” хэмээн дүгнэсэн бол эрхийн нөхцөлийг дээрдүүлэх эрх зүйн орчин батлах зөвлөмжийн тухайд хууль баталсан ч

зөрчигдсөн тохиолдолд эрхийг сэргээх, буруутай этгээдэд хариуцлага тооцох процедурыг хуульд тусгаагүй бол “хэрэгжих шатанд” гэсэн дүгнэлт хийсэн. Мөн түүнчлэн төрөөс зохих алхмыг авч хэрэгжүүлсэн хэдий ч тухайн асуудал тулгамдсан хэвээр байгаа бол “хэрэгжих шатанд” хэмээн үзсэн. Зөвлөмжийн хэрэгжилтэд үнэлгээ өгсөн дүнтэй холбогдуулан нэмэлт тодруулга шаардлагатай бол зөвлөмж тус бүр дээр ажилласан Ажлын хэсгүүдтэй холбогдож тодруулга авах боломжтой.<sup>2</sup>

## **Дөрөв. UPR ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДЛЫГ ӨНГИЙН КОДООР ИЛЭРХИЙЛСЭН НЬ**

### **4.1. UPR Зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх өнгийн код**

Хэрэгжсэн зөвлөмж
Хэрэгжих шатанд буй зөвлөмж
Хэрэгжээгүй зөвлөмж

### **4.2. Хэрэгжилтийн статистик**

Хэрэгжсэн зөвлөмж - 22
Хэрэгжих шатанд буй зөвлөмж - 99
Хэрэгжээгүй зөвлөмж - 29

### **4.3. Монгол Улсын хүлээж авсан зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээ өнгийн кодоор**

108.2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколоор хүлээсэн үүргээ биелүүлэхэд чиглэсэн шаардлагатай бүх арга хэмжээг авах /Намиби/
108.3. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколд нийцүүлэн үндэсний хууль тогтоомжоос цаазаар авах ялыг аль болох хугацаанд халах /Португал/
108.7. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколд нийцүүлэн зохих чадамж, нөөц бололцоотой үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагыг байгуулах /Чех/
108.8. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн Мэдээлэл хүргүүлж, хэлэлцүүлэх журмын тухай нэмэлт протоколыг соёрхон батлах /Монтенегро/
108.17. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд үндэсний хууль тогтоомжоо бүрэн нийцүүлэх, Олон улсын эрүүгийн шүүхийн Эрх ямба, дархан эрхийн тухай хэлэлцээрийг соёрхон батлах /Эстони/
108.18. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмийн зохицуулалтыг үндэсний хууль тогтоомждоо тусгах /Португал/
108.19. Яс үндэс, шашин, бэлгийн чиг баримжаа, эсхүл хүйсийн баримжаа, илэрхийлэл, хэл, улс төрийн үзэл бодол, оюуны эсхүл биеийн хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлан гадуурхагдах бүх хэлбэрээс зайлсхийх зорилгоор ялгаварлан гадуурхахын эсрэг цогц хууль тогтоомжийг батлах /Чили/
108.20. Ялгаварлан гадуурхахтай тэмцэх цогц хууль тогтоомжийг батлах, ийнхүү батлах хууль тогтоомж, эсхүл одоо байгаа хуулиар тогтоосон тэгш байдлыг бодит амьдралд баталгаажуулах алхмыг авч хэрэгжүүлэх /Ирланд/
108.21. ЛГБТ хүмүүс зэрэг нийгмийн цөөнх бүлгүүдийн нийт гишүүний эрхийг хамгаалах ялгаварлан гадуурхахын эсрэг иж бүрэн хууль тогтоомжийг батлах /Англи/
108.22. Эрүүгийн шинэ хуулиа батлах явцаа хурдасгах /Турк/
108.23. Хүн бүрийн эрх тэгш болон аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин, хүний эрхийн соёлыг баталгаажуулахын тулд Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулах, бусад шаардлагатай эрх зүйн орчноо сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй нааштай ажлаа хурдасгаж, батлагдсан хуулиа үр дүнтэй хэрэгжүүлэх /Норвеги/

108.24. Хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настай хүмүүс, эмэгтэйчүүд зэрэг хүн амын эмзэг бүлгийн эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих ажлаа үргэлжлүүлэх /ОХУ/
108.25. Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийг өөрчлөн Парисын зарчимд нийцүүлэн өөрчилж, комиссын чадавхыг сайжруулах /Сиерра Леон/
108.26. Боловсролын салбарт, ялангуяа хууль сахиулах алба хаагчдад хүний эрхийн сургалт хийх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх /Морокко/
108.27. Шүүгч, магистратуудын байнгын болон заавал хамрагдах сургалтын хөтөлбөрт хүний эрхийн болон олон улсын гэрээг хэрэглэх сургалтыг оруулах /Мексик/
108.28. Хүний эрхийн үндэсний комиссын хараат бус байдлыг Парисын зарчимд нийцүүлэн түүний бүрэн эрхийг бэхжүүлэх /Чили/
108.29. Хүний эрхийн үндэсний комиссын хараат бус байдлыг баталгаажуулахын тулд илүүтэй дэмжлэг үзүүлэх /Австрали/
108.30. Хүний эрхийн чиглэлээрх үндэсний байгууллагууд болон тогтолцоогоо бэхжүүлэх ажлаа үргэлжлүүлэх /Непал/
108.31. Парисын зарчмын дагуу бүрэн эрхээ чөлөөтэй, хараат бусаар хэрэгжүүлдэг болгох зорилгоор Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын чадавхыг өргөжүүлэн бэхжүүлэх шаардлагатай арга хэмжээг авах /Намиби/
108.32. Парисын зарчимд нийцүүлэх зорилгоор Хүний эрхийн үндэсний комиссын үйл ажиллагааг сайжруулах, ялгаварлан гадуурхалтын эсрэг үр нөлөөтэй тэмцэх эрх зүйн орчныг нь бэхжүүлэх /Нигер/
108.33. Монгол Улсад хүний эрхийг үр нөлөөтэй эдлүүлэх зорилгоор хүний эрхийн байгууллагуудыг бэхжүүлэх хүчин чармайлтаа цаашид үргэлжлүүлэх /Пакистан/
108.34. Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн зэрэг хамгийн эмзэг бүлгийн иргэдийн эрхийг хамгаалах үндэсний хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэх үүрэг амлалтаа биелүүлэх /Румын/
108.35. Засгийн газрын чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагуудыг оролцуулан бүх түвшинд хүний эрхийн боловсрол олгох, сургах хүчин чармайлтаа үргэлжлүүлэх /Пакистан/
108.36. Ээлжит нэгдсэн хэлэлцүүлгийн зөвлөмжийг оролцуулан олон улсын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах тогтолцоог бий болгох боломжийг судлан үзэх /Парагвай/
108.37. Хүний эрхийн салбар дахь олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр ажиллах /Туркменистан/
108.38. 2003 онд хүргүүлэх байсан ч одоог хүртэл хүргүүлээгүй байгаа анхдугаар илтгэлээ НҮБ-ын Эрүү шүүлтийн эсрэг хороонд хүргүүлж, хороотой үр нөлөөтэй хэлэлцүүлэг эхлүүлэх бололцоог олгох /Дани/
108.39. Хүний эрхийн зөвлөлийн Тусгай процедур болон гэрээний байгууллагууд зэрэг олон улсын хүний эрхийн хяналтын механизмуудтай ажиллах цаашдын хамтын ажиллагааг судлан үзэх /Туркменистан/
108.40. Хүний эрхийн салбар дахь техникийн туслалцааны болон чадавхыг сайжруулах олон улсын хөтөлбөрүүдэд идэвхтэй оролцох /Туркменистан/
108.41. Аливаа шалтгаанаар ялгаварлан гадуурхахтай тэмцэх шинэ хууль тогтоомжийг батлах /Уругвай/
108.42. Ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийн эсрэг, түүний дотор хохирогчдын эрхийг хамгаалсан цогц хууль батлах /Чех/
108.43. Хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлээрх арга хэмжээнүүдээ үргэлжлүүлэн хэрэгжүүлэх /Япон/
108.44. Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн үүрэг, хариуцлагын талаарх нийгмийн хэвшмэл ойлголтыг өөрчлөх, ялгаварлан гадуурхах уламжлалт зан үйлийг халах арга хэмжээнийхээ үр нөлөөг сайжруулах хүчин чармайлтаа нэмэгдүүлэх/Словени/
108.45. Эмэгтэйчүүдэд тэгш байдал, хамгаалалтыг олгож буй хууль тогтоомж, үр нөлөөтэй хэрэгжилтийг баталгаажуулах арга хэмжээгээ гүнзгийрүүлэх /Аргентин/
108.46. Эмэгтэйчүүдийн эрхийн хамгаалалтыг сайжруулах чиглэлээрх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх /БНАСУ/

108.47. Төрийн албан дахь эмэгтэйчүүдийн оролцоо, жендэрийн тэгш байдлыг хангах ажлаа үргэлжлүүлэх /Лаос/
108.48. Нийгэм, эдийн засгийн амьдрал дахь эмэгтэйчүүдийн идэвхтэй, бүрэн оролцоог цаашид дэмжих бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх /Сингапур/
108.49. Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдлын асуудлаарх Аюулгүйн зөвлөлийн 1325 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөө батлах асуудлыг судлан үзэх /Португал/
108.50. Арьс үндэс, яс үндсээр ялгаварлан гадуурхахыг өдөөн хатгасан үзэн ядах үг хэлэх үйлдэлтэй болон үүнээс улбаатай хүчирхийлэлтэй тэмцэх /Хятад/
108.51. Гэр хороололд амьдарч буй хүмүүсийн эсрэг шууд болон шууд бусаар ялгаварлан гадуурхах явдалтай тэмцэх үр нөлөөтэй арга хэмжээг авах /Швед/
108.52. Гадаадын иргэдийг аливаа хэлбэрийн халдлагаас хамгаалах, гэмт этгээдэд хариуцлага хүлээлгэх хүчин чармайлтаа ахиулах /БНСУ/
108.53. Бэлгийн чиг баримжаа, эсхүл хүйсийн баримжаа, илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтыг оролцуулан ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэртэй тэмцэх /Франц/
108.54. ЛГБТИ хүмүүсийн хүний эрхийн үр нөлөө бүхий хамгаалалт тогтоосон хууль тогтоомжийг боловсруулж батлахаас гадна Нэн ядуурал ба хүний эрхийн асуудлаарх Тусгай илтгэгчийн илтгэлд дурдсан ЛГБТ хүмүүсийн эсрэг үйлдсэн гэх халдлагуудыг хараат бус байдлаар мөрдөн шалгах арга хэмжээ авах /Гондурас/
108.55. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтыг оролцуулан ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэрийг хориглох /Словени/
108.56. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн байдал болон эрүүл мэндийн байдалд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтыг оролцуулан ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэрийг хориглох /Зүүн Тимор/
108.57. Өөрийн үндэсний хууль тогтоомждоо тусган оруулах замаар ЛГБТИ хүмүүс эрхээ эдлэх тэгш байдлыг хөхиүлэн дэмжих /Уругвай/
108.58. Үзэн ядах, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхах гэмт хэргүүдийг эрүүгийн хууль тогтоомждоо оруулах зорилгоор тухайн хууль тогтоомжийг өөрчлөх /Испани/
108.59. ЛГБТ хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, ийм явдлыг үл тэвчих хандлагыг дэмжих зорилгоор олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх сурталчилгааны ажлыг зохион байгуулах /Бразил/
108.60. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлтэй тэмцэх хүчин чармайлтаа сайжруулж, энэ чиглэлээрх датаг цуглуулах, мэдээлэл, статистикийг гаргах ажлыг зохион байгуулалттайгаар хийж гүйцэтгэх /Нидерланд/
108.61. Өмнөх удаа зөвлөмж болгож байсанчлан ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэрийг, тэр дундаа ХДХВ/ДОХ-той гэсэн үндэслэлээр ялгаварлан гадуурхахыг эрс хориглох, урьдчилан сэргийлэх, шийтгэх, болон устгах зорилготой хууль тогтоомжийг батлах зэргээр үр нөлөөтэй, шуурхай арга хэмжээ авах /Мексик/
108.62. Монгол Улс соёрхон баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын Цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт II протоколд нийцүүлэн цаазаар авах ялыг халж хуульчлан баталгаажуулах /Франц/
108.63. Цаазаар авах ялыг бүрэн халсан хууль тогтоомж батлах /Австрали/
108.64. Цаазаар авах ялыг бүрэн халах зорилгоор Эрүүгийн хуулиа өөрчлөх /Итали/
108.65. Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд цаазаар авах ялыг эцэслэн халах /Англи/
108.66. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколыг соёрхон баталснаар хүлээсэн олон улсын үүргээ биелүүлэх үүднээс цаазаар авах ялыг халах хүрээнд эрүүгийн хууль тогтоомжоо шинэчлэх /Швед/
108.67. Цаазаар авах ялыг хуулиар халах зорилгоор шинэ Эрүүгийн хуулийг оролцуулан шаардлагатай хууль тогтоомжийг батлах /Словак/
108.68. Бүх төрлийн гэмт хэрэгт цаазаар авах ялыг de jure байдлаар оногдуулахгүй болгож халах /Монтенегро/

108.69. Цаазаар авах ялыг халж, цаазаар авахуулсан хүмүүсийн гэр бүлийг нүүцээс хассан холбогдох мэдээллээр хангах /Литва/
108.70. Цаазаар авах ялын гүйцэтгэлийг улсын нүүц мэдээллээс хасах /Португал/
108.71. Хууль сахиулах албан хаагчид болон бусад төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр, мөн шүүгч, хуульч нарын байнгын сургалтын хөтөлбөрт эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх олон улсын зохицуулалтыг тусгах /Мексик/
108.72. Эрүүдэн шүүсэн байж болзошгүй бүх хэргийг мөрдөн шалгах, хорих байрны болон шоронгийн барилга байгууламжийн нөхцөлийг сайжруулах, эрүүдэн шүүгдсэний улмаас хохирсон хохирогчдод эдлэх эрх зүйн хамгаалалтыг бэхжүүлэх /Чех/
108.73. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх цагдаагийн албан хаагчдын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлэх, мөн энэ хэрэгт ял шийтгэлгүй үлдэх явдалтай тэмцэх үүднээс мөрдөн шалгах үр нөлөө бүхий тогтолцоог бий болгох /Франц/
108.74. Эрүүдэн шүүх үйлдлийг гэмт хэрэг хэмээн тодорхойлсон өөрчлөлтийг Эрүүгийн хуульд оруулах асуудлыг судлан үзэх /Унгар/
108.75. Соёрхон батлаад удаагүй байгаа Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколд заасан шаардлагын дагуу эрүүдэн шүүсэн болон зүй бусаар харьцсан байж болзошгүй хэргийг мөрдөн шалгах бие даасан тогтолцоог байгуулах /Австри/
108.76. Эрүүдэн шүүх болон зүй бусаар харьцсан төрийн албан хаагчийн үйлдлийг үл тэвчих, эрүүдэн шүүсэн бүх этгээдийг мөрдөн шалгах нөхцөлийг бүрдүүлэх /Зүүн Тимор/
108.77. Цагдаагийн албан хаагч эрүүдэн шүүсэн болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг нь доромжлон харьцсан байж болзошгүй үйлдлийг мөрдөн шалгах бие даасан тогтолцоог бий болгож, төрийн албан хаагч ийм төрлийн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх /Швейцари/
108.78. Эрүүдэн шүүсэн болон зүй бусаар харьцсан байж болзошгүй талаарх бүх гомдол, мэдээллийг бие даасан агентлаг бүрэн гүйцэд мөрдөн шалгадаг байх, тухайн үйлдлийг үйлдсэн этгээд хариуцлага хүлээдэг байх, түүнчлэн мөрдөн шалгалтыг зохих эрх мэдэлтэй, хараат бус болон сэжиглэгдэж буй этгээд, тэдгээрийн ажилладаг байгууллагад хамааралгүй бие даасан этгээд хийх нөхцөлийг бүрдүүлэх /Швед/
108.79. Төрийн албан хаагч эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэм бүрүүтэй этгээдэд хариуцлага хүлээлгэх үүднээс үйлдсэн байж болзошгүй бүх хэргийг нэн даруй, бүрэн гүйцэд шалгах нөхцөлийг хангах арга хэмжээг эрчимжүүлэх /Итали/
108.80. Эрүүдэн шүүх, зүй бусаар харьцахыг устгах арга хэмжээг үргэлжлүүлэх, түүний дотор хууль сахиулах албан тушаалтнуудыг сургах, боловсрол олгох /Коста Рика/
108.82. Хоригдож буй хүмүүстэй харьцах нөхцөлийг сайжруулахад чиглэсэн зохих алхмыг авч хэрэгжүүлэх /Япон/
108.83. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хууль тогтоомж батлах /Зүүн Тимор/
108.84. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээрх идэвхтэй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх /Беларус/
108.85. Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох хүчин чармайлтаа улам идэвхжүүлэх /Филиппин/
108.86. Гэр бүлийн болон жендэрт суурилсан хүчирхийлэл, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг халах чиглэлээр илүү хүчин чармайлт гаргах, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэх замаар нийгмийн бүх салбарт эмэгтэйчүүдийн төлөөллийг илүүтэй баталгаажуулах /БНСУ/

108.87. Гэрлэлтийн хүчин, бэлгийн дарамтыг эрүүгийн хэрэгт тооцох, хохирогчийн шүүхэд хандах, түслалцаа болон хамгаалалт авах эрхийг баталгаажуулах, ийм төрлийн хэргийг зохих ёсоор мөрдөн шалгах, гэмт этгээдэд ял шийтгэлийг хуулийн дагуу заавал хүлээлгэх замаар жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хүчин чармайлтаа бэхжүүлэх /Словени/
108.88. Гэр бүлийн хүчирхийлэлттэй тэмцэх тухай хуулийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх ажлыг дэмжих эмэгтэйчүүдийн эсрэг бүх төрлийн хүчирхийлэлттэй тэмцэхэд чиглэсэн үндэсний стратеги баталж, үр нөлөөтэй хэрэгжүүлэх /Турк/
108.89. Гэр бүлийн хүчирхийллийг даван туулагсдын хамгаалалтыг улам сайжруулах, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, түүний шалтгаан, үр дагаврын асуудлаар Тусгай илтгэгчийг Монгол Улсад урих /АНУ/
108.90. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээрх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх /Латви/
108.91. Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, мөрдөн шалгах тогтолцоог бэхжүүлэх, энэ төрлийн хэргээр ажилладаг хууль сахиулагчдыг сургах /Молдав/
108.92. Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг одоогийн хуулиа үр нөлөөтэй хэрэгжүүлэх, алслагдсан газруудад хамгаалалтын байр барих зэргээр хохирогчдыг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээгээ бэхжүүлэх /Швейцари/
108.93. Гэр бүлийн хүчирхийллийг эрүүгийн хэрэгт тооцох, хохирогчдын хамгаалалтыг сайжруулах, гэмт этгээдэд ял шийтгэл оногдуулах зорилгоор Парламентаар хэлэлцэж буй гэр бүлийн хүчирхийллийн хуулийн төслийг батлах /Австрали/
108.94. Гэр бүлийн хүчирхийллийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдлэг ойлголтыг түгээх замаар гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх /Испани/
108.95. Холбогдох байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, нотлох баримтын шаардлагыг эргэж харах болон тусгаарласан шийдвэрийн хэрэгжилтийг баталгаажуулах замаар гэр бүлийн хүчирхийллийн эсрэг эрх зүйн хамгаалалтыг авахад учирч буй саад тотгорыг арилгах /Австри/
108.96. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үр нөлөө бүхий хамгаалалт авах, эрхээ сэргээлгэх боломжийг сайжруулах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэм буруутныг яллах чадавхыг бэхжүүлэх, гэрлэлтийн хүчинг эрүүгийн хэрэгт тооцох /Чех/
108.97. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, тэдний эсрэг хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд чиглэсэн одоогийн хууль тогтоомжийн үр нөлөөтэй хэрэгжилтийг баталгаажуулах /Итали/
108.98. Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалалт хайж буй эмэгтэйчүүд, хүүхдүүдэд зориулсан хамгаалах байрыг илүү олноор байгуулахад анхаарах /Малайз/
108.99. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хууль тогтоомжоо улам бэхжүүлэх /ОХУ/
108.100. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэх маш тодорхой эрх зүйн орчныг бүрдүүлэх, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод зориулсан нийгмийн хамгааллын тогтолцоог бий болгох /Серби/
108.101. Гэр бүлийн хүчирхийллийг эрүүгийн хэрэгт тооцох өөрчлөлтийг эрүүгийн хууль тогтоомждоо оруулах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэмт этгээдэд эрх бүхий байгууллагууд хариуцлага хүлээлгэн яллах нөхцөлийг хангах, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үзүүлж буй бүх төрлийн үйлчилгээнд хангалттай санхүүжилт олгох /Словак/
108.102. Гэр бүлийн хүчирхийллийг эрүүгийн хэрэгт тооцох өөрчлөлтийг эрүүгийн хууль тогтоомждоо оруулах /Испани/
108.103. Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, гэр бүлийн хүчирхийллийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх сурталчилгааны ажлын цар хүрээг өсгөх, хохирогчдод үзүүлэх үйлчилгээ, хамгаалалтыг өргөжүүлэх /Канад/
108.104. Гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн дарамтыг эрүүгийн хэрэгт тооцохыг анхаарах, гэмт этгээд хуулийн дагуу хариуцлага хүлээдэг болох нөхцөлийг хангах /Унгар/
108.105. Гэр бүлийн хүрээнд учирдаг бүх төрлийн хүчирхийлэл, заналхийлэл, бэлгийн дарамт, мөлжлөг зэргийг оролцуулан гэр бүлийн хүчирхийллийг эрүүгийн хэрэгт тооцох хууль тогтоомж батлах, гэмт этгээдийг яллан шийтгэдэг, хохирогчид, тэр дундаа орон нутагт буй хохирогчид халамж авдаг болох нөхцөлийг хангах /Парагвай/
108.106. Эрүү шүүлтийн эсрэг хорооноос өгсөн зөвлөмжид нийцүүлэн хүүхдийн бие махбодын шийтгэлийг эрс хориглох /Чили/



108.107. Гэр бүл дэх шийтгэлийг оролцуулан хүүхдийн бие махбодын бүх шийтгэлийг эрс хориглох /Швед/
108.108. Хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийг мөлжлөгт автах, ялангуяа хөдөлмөрийн хортой нөхцөлд ажиллуулахаас хамгаалах үр нөлөө бүхий арга хэмжээг авах /Герман/
108.109. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах 2012-2016 оны үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах, хөтөлбөр хэрэгжсэний дараахь тогтолцоог судлан үзэх /Итали/
108.110. Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх ажлаа өргөжүүлэх, хүүхэд хөдөлмөрийн хортой, аюултай нөхцөлд, түүний дотор бичил уурхайд хөдөлмөр эрхлэхгүй байх нөхцлийг хангах
108.111. Хүүхдийг хөдөлмөр эрхлүүлсэн ажил олгогчдод хариуцлага хүлээлгэх зэргээр хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх ажлаа үргэлжлүүлэх, гэр бүлд болон сургуульд хүүхдэд хүлээлгэх хүчирхийллийн бус сахилга батын шинэ хэлбэрүүдийг нэвтрүүлэх /Литва/
108.112. Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх стратегиудыг судлан тодорхойлох /Норвеги/
108.113. Хүүхдийн хөдөлмөрийг мөлжиж буй ажил олгогчдын үйлдлийг эрүүгийн хэрэгт тооцох, тэдэнд хариуцлага хүлээлгэх зэргээр хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх /Польш/
108.114. Хүүхдүүд бүх төрлийн хүчирхийлэл, мөлжлөгөөс, ялангуяа хөдөлмөрийн хортой нөхцөл дэх хүүхдийн хөдөлмөрийн хэлбэрээс хамгаалагдсан байх нөхцөлийг баталгаажуулах хүчин чармайлтаа үргэлжлүүлэх /БНСУ/
108.115. Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хүчин чармайлтаа үргэлжлүүлэх /Морокко/
108.116. Хууль сахиулах байгууллагын хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, гэмт этгээдийг яллах чадавхыг бэхжүүлэх, хохирогчдод үзүүлэх үйлчилгээг өргөжүүлэх замаар Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах /Канад/
108.117. Хүн худалдаалахтай тэмцэх тухай 2012 оны хуулийг хэрэгжүүлж, гэмт этгээдийг мөрдөн шалгах, яллах ажиллагааны үр нөлөөтэй байдлыг хангах, хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх үүднээс хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагыг бэхжүүлэх /Бразил/
108.118. Хүн худалдаалахын эсрэг маш хатуу хууль батлах замаар хүүхдийг худалдаалах бүх хэлбэрийг эрүүгийн хэрэгт тооцох /Сиерра Леон/
108.119. Хүн худалдаалах бүх хэрэгт шаардлагатай мөрдөн шалгах, яллах ажиллагаа явуулах замаар хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдийг худалдаалахтай тэмцэх арга хэмжээгээ өргөжүүлэх /Малайз/
108.120. Хүн худалдаалахтай тэмцэхэд шаардлагатай боловсон хүчний болон материаллаг бүх нөөцийг хуваарилан олгох /Гондурас/
108.121. Хүн худалдаалах хэргийн хохирогч, гэрч эрх зүйн туслалцаа, хамгаалалт, нөхөн сэргээх үйлчилгээ авах боломжоор баталгаатай хангагдах нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай төсвийн, захиргааны болон эрх зүйн арга хэмжээнүүдийг авах services /Мексик/
108.122. Хүн худалдаалахын эсрэг хөтөлбөрт шаардлагатай боловсон хүчний болон бусад нөөцийг хангалттай байдлаар үргэлжлүүлэн олгох /Филиппин/
108.123. Эрх зүйн шинэ орчин буюу Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд заасны дагуу хүн худалдаалах үйлдэлд ял оногдуулах, хууль сахиулах албан хаагчдын үйлдсэн хэргийг оролцуулан хүн худалдаалах хэрэг үйлдсэн байж болзошгүй бүх үйлдлийг мөрдөн шалгах, хохирогчдод нөхөн төлбөр олгох, нөхөн сэргээх зохицуулалтыг хэрэгжүүлэх зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй бүх талд зориулсан сургалт зохион байгуулах /Мексик/
108.124. Шүүх эрх мэдлийн тогтолцоог Монгол Улсын олон улсын үүрэг амлалтад нийцүүлэн шинэчлэх ажлаа үргэлжлүүлэх /ОХУ/
108.125. Бүх аймагт байгуулагдсан Хууль зүйн туслалцааны төвүүдийг шаардлагатай санхүүжилт, шалгуур хангасан боловсон хүчнээр хангах замаар эрх зүйн туслалцаа авах боломжийг нэмэгдүүлэх /Литва/
108.126. Ял шийтгэлгүй үлдэх явдалтай тэмцэх, эрүүдэн шүүгдсэний улмаас хохирсон хохирогчид хангалттай хэмжээний нөхөн олговор болон нөхөн сэргээх үйлчилгээ авах нөхцөлийг хангах үүднээс эрүүдэн шүүсэн болон зүй бусаар харьцсан байж болзошгүй хэрэгт бие даасан, үр нөлөө бүхий мөрдөн шалгах ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх /Герман/
108.127. Бүх гэмт этгээдэд ял оногдуулах, хохирогчид цаг алдалгүй эрхээ сэргээлгэх, хамгаалалт авах нөхцөлийг бүрдүүлэх /Литва/
108.128. Насанд хүрээгүй хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх цогц тогтолцоог олон улсын стандартад нийцүүлэн бий болгох /Сиерра Леон/

108.129. Иргэддээ тогтвортой хөгжил, тэгш байдлыг бүрдүүлэх үүднээс авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх арга хэмжээгээ үргэлжлүүлэн авах /Сингапур/
108.130. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тогтолцоон дахь авлигын бүх хэргийг мөрдөн шалгах /Литва/
108.131. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй холбогдох үндэсний хууль тогтоомжийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад нийцүүлэх, Харилцаа, холбооны зохицуулах хорооны хараат бус байдлыг хангах /Швейцарь/
108.132. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй холбогдох хууль тогтоомж, захиргааны шийдвэрийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактаар хүлээсэн Монгол Улсын үүрэгт бүрэн дүүрэн нийцүүлэх, нэр төр гутаахыг эрүүгийн гэмт хэрэгт тооцохгүй байх асуудлыг судлан үзэх /АНУ/
108.133. Интернет орчинг оролцуулан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулах /Франц/
108.134. Интернетийн зохицуулалтын бүх хүрээнд хүний халдашгүй байх эрх болон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг оролцуулан хүний эрхэд бүрэн хүндэтгэлтэй хандах, тэдгээр эрхийг аливаа байдлаар хязгаарлахдаа “хуульд нийцсэн байх”, “зайлшгүй байх” болон “proportionality” байх зарчмыг баримтлах /Герман/
108.135. Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд болон иргэний нийгмийн зүтгэлтнүүд шийтгүүлнэ гэх аливаа айдасгүйгээр өөрсдийн үйл ажиллагаагаа чөлөөтэй эрхлэх бололцоог олон улсын стандартын дагуу хангах /Эстони/
108.136. Нэр төр гутаах үйлдлийг эрүүгийн гэмт хэрэгт тооцохгүй байх, төрийн болон орон нутгийн эрх бүхий байгууллагын үйл ажиллагааг сурвалжилсан, эсхүл шүүмжилсний улмаас мөрдөн хавчигдах, эсхүл дарамт шахалтанд орохгүй байхаас хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх /Чех/
108.137. Нэр төр гутаах үйлдлийг эрүүгийн гэмт хэргээс хасах, олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэн иргэний журмаар шийдвэрлэх /Ирланд/
108.138. Эрүүгийн хуулийн гүтгэлэг, доромжлолтой холбоотой зүйл заалтыг шүүмжлэлийг таслан зогсоох зорилгоор ашиглахгүй байх, сэтгүүлчдийн мэдээллийн эх сурвалж болон “шүгэлдэгч”-ийг хамгаалах /Австри/
108.139. Эмэгтэйчүүдийн оролцоог улс төрийн шийдвэр гаргах түвшинд бэхжүүлэх зорилго бүхий үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх /Серби/
108.140. Эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах ажиллагаанд оролцуулах, өндөр түвшний албан тушаал эрхлүүлэх чиглэлээрх хүчин чармайлтаа бэхжүүлэх, боловсролын болон хөдөлмөрийн салбарт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулах нөхцөлийг хангах /Норвеги/
108.141. Шийдвэр гаргах түвшний албан тушаал эрхлэх эмэгтэйчүүдийн төлөөллийг өсгөн нэмэгдүүлэх чиглэлээрх хүчин чармайлтаа эрчимжүүлэх /Рванда/
108.142. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог баталгаажуулахад чиглэсэн квотын шаардлага зэрэг түр тусгай хэмжээг авах /Коста Рика/
108.143. Нийт хүн ам, ялангуяа нийгмийн эмзэг бүлгийн амьдралын чанарыг сайжруулах амжилттай нийгмийн хөтөлбөрүүдээ цаашид улам бэхжүүлэх /Венесуэл/
108.144. Хотын төвүүдэд нийгмийн хамгийн эмзэг бүлгийн хүмүүс, түүний дотор орон нутгаас шилжин ирсэн хүмүүс нийтийн суурь үйлчилгээ авах боломжтой байх нөхцлийг хангах замаар хотын төвүүдэд тогтвортой хөгжлийг бий болгоход чиглэсэн шаардлагатай арга хэмжээнүүдийг авах /Испани/
108.145. Эрүүл мэндийн суурь үйлчилгээг үндэсний болон бүсийн хэмжээнд үзүүлэх тогтолцоог бэхжүүлэх, үйлчилгээний хамрах хүрээ болон хүртээмжийг өсгөн нэмэгдүүлэх, эрүүл мэндийн тогтолцоонд буй хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэхэд анхаарал хандуулах /Бутан/
108.146. Эмэгтэйчүүд, хүүхдүүдийн эрхийг хөхиүлэн дэмжих хүчин чармайлтаа үргэлжлүүлэх, одоог хүртэл өндөр түвшинд байгаа эхийн эндэгдлийг бууруулах чиглэлээр ажиллах /Непал/
108.147. Эхийн эндэгдлийг бууруулах чиглэлээрх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх /БНАСУ/
108.148. Эхийн эндэгдлийн хувь хэмжээг, ялангуяа орон нутагт улам бууруулахад чиглэсэн практик алхмаа үргэлжлүүлэх /Сингапур/
108.149. Орон нутаг болон хот суурин газар дахь хүүхдийн эндэгдлийн хувь хэмжээний зөрүүг бууруулах чиглэлээр хүчин чармайлт гарган ажиллах /Гондурас/
108.150. “Нэг Монгол” нээлттэй боловсролын үндэсний хөтөлбөрөө сайжруулан ажиллах /Латви/
108.151. Хүүхэд бүр сурч боловсрох эрхээ эдлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн хүчин чармайлтаа үргэлжлүүлэх /Румын/

108.152. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангаж, хамгаалах, ялангуяа тэдний оролцоог хангах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, сурч боловсрох эрхийн хэрэгжилтийг өргөжүүлэх Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай хуулийн төслийг эцэслэн батлах хүчин чармайлтаа хоёр дахин нэмэгдүүлэх /Индонез/
108.153. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлээрх нааштай хүчин чармайлтаа үргэлжлүүлэх /Аргентин/
108.154. Бүх төрлийн ялгаварлан гадуурхалт, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настай хүмүүсийн эрхийг хамгаалах тодорхой хууль батлах /Түрк/
108.155. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл хөгжлийг баталгаажуулсан хамран сургалтанд ач холбогдол өгсөн, боловсролын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх /БНХАУ/
108.156. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тухай олон нийтийн ойлголтыг сайжруулах замаар тэдний боловсрол эзэмших тэгш боломжийг хангах /Түрк/
108.157. Боловсролын тогтолцоогоо улам бэхжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсрол эзэмших тэгш боломжийг хангах /Лаос/
108.158. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидын эрх, түүний дотор нөхөн үржихүй, хүчирхийллээс ангид байх, хөдөлмөрлөх, боловсрол эзэмших болон шийдвэр гаргах түвшинд оролцох эрхүүдэд онцгой анхаарал хандуулах /Тайланд/
108.160. Орогнол хүсэгчид буцаахгүй байх зарчмын дагуух эрх болон бусад эрхээ эдлэх бололцоог нь хангах чиглэлээр Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Дээд комиссарын газартай хамтран ажиллах /Уругвай/
108.161. Миниматагийн конвенцийг соёрхон батлах асуудлыг судлан үзэж, бичил үурхай эрхлэгчдийн олборлох эрхийг хангах, тэдгээрийн үйл ажиллагааг аль болох хурдан хугацаанд албажуулах зорилгоор Ашигт малтмалын тухай хуулийн бичил үурхайн талаарх 4 дүгээр зүйлийн 4.1.23 дахь заалтыг шинэчлэх /Унгар/
108.162. НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн Удирдах зарчмуудыг хэрэгжүүлэх үүднээс нүүдэлчин малчдын нөхцөл байдал, эрхээ сэргээлгэх боломжийг сайжруулахад онцгой ач холбогдол өгсөн Үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөг боловсруулах /Нидерланд/
108.163. Олборлох үйлдвэрлэлийн салбарт аюулгүй байдлыг тогтоохдоо хүний эрхийг хангах зорилгоор Аюулгүй байдал, хүний эрхийн санаачилгын талаарх Сайн дурын зарчимд нэгдэх /АНУ/
108.164. Гар аргаар ашигт малтмал олборлож буй иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, байгаль орчныг хамгаалах зорилгоор тус салбар дахь мөнгөн усны хэрэглээг зохицуулсан үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх /Швейцари/

## **Тав. ХҮЛЭЭН АВСАН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТУХАЙ**

### **108.2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколоор хүлээсэн үүргээ биелүүлэхэд чиглэсэн шаардлагатай бүх арга хэмжээг авах /Намиби/**

Хэрэгжсэн. 2015 оны 12-р сард цаазаар авах ялыг халсан шинэ Эрүүгийн хууль баталж, 2017 оны 7-р сарын 1-нээс хэрэгжиж эхэлснээр цаазаар авах ялыг бүрэн халсан дэлхийн 105 дахь улс болсон. Гэвч 2017 оны 10-р сарын 16-нд Монгол Улсын Ерөнхийлөгч цаазаар авах ялыг сэргээх тухай санаачилга гаргаж, энэ саналаа Хууль зүй, дотоод хэргийн сайдад 2017 оны 11-р сарын 17-нд хүргүүлсэн. ХЗДХЯ нь Улсын Дээд шүүх, Улсын ерөнхий прокурор, Гадаад харилцааны яам, Хүний эрхийн үндэсний комисс, Хуульчдын холбоо, МУИС-ийн эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн Ажлын хэсэг байгуулж, саналыг судалж үзээд "Монгол Улс ИУТЭОУП-ын 2-р нэмэлт Протоколоос гарах, цуцлах, хүчингүй болгох, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээсээ татгалзах хууль зүйн боломжгүй" гэсэн дүгнэлт гаргасан. Ерөнхийлөгч 2018 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн УИХ-ын Хаврын Чуулганы нээлтийн үеэр хэлсэн үгэндээ".....ХЗДХЯ-ны зүгээс албан ёсоор хариу ирүүлээгүй, ямар нэг санаачилга гаргаагүй, ...хууль санаачлах эрхийнхээ дагуу хуулийн төсөл санаачилж, Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын [www.president.mn](http://www.president.mn) цахим хуудсаар иргэдийн саналыг сарын турш албан ёсоор авч, УИХ-ын энэ хаврын чуулганд өргөн барьж хэлэлцүүлнэ." хэмээн өгүүлсэн нь болгоомжлол төрүүлж байна.

### **108.3. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколд нийцүүлэн үндэсний хууль тогтоомжоос цаазаар авах ялыг аль болох хугацаанд халах /Португал/**

Хэрэгжсэн. 108.2-ыг үзнэ үү.

### **108.7. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколд нийцүүлэн зохих чадамж, нөөц бололцоотой үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагыг байгуулах /Чех/**

Хэрэгжээгүй. 2014 онд ЭШЭК-ийн Нэмэлт протоколыг соёрхон баталсан ч өнөөг хүртэл зохих чадамж, нөөцтэй үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага байгуулаагүй. Энэ байгууллагын чиг үүргийг ХЭҮК-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгаж, 2018 онд УИХ-д өргөн барихаар төлөвлөж байна гэсэн мэдээлэл өгсөн. ХЭҮК-ын МУ-ын хүний эрхийн төлөв байдлын талаар 16 дах илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан УИХ-аас 2018.01.31-ний өдрийн 2 дугаар тогтоолоороо "Эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийн талаар" 1-рт, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг нэн даруй бий болгож төсөв, орон тоог шийдвэрлэх, 2-рт, эрүү шүүлт тулгах, гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах байгууллагыг байгуулах, бүтэц, орон тоог шийдвэрлэх үүргийг Засгийн газарт даалгаж, биелэлтийг 2018 оны 4-р улиралд багтаан УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд тайлагнахыг үүрэг болгосон. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/66 дугаар тушаалаар ХЭҮК-ын тухай хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсэг байгуулсан байна. Иргэний нийгмийн байгууллагуудаас ТББ-ын төлөөллийг оруулсан Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага байгуулах санал, зөвлөмж хүргүүлсэн ч энэ санал тусгагдаагүй байна.

### **108.8. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн Мэдээлэл хүргүүлж, хэлэлцүүлэх журмын тухай нэмэлт протоколыг соёрхон батлах /Монтенегро, Португал, Тайланд/**

Хэрэгжсэн. Уг протоколыг УИХ 2015 оны 4-р сард соёрхон баталсан.

**108.17. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд үндэсний хууль тогтоомжоо бүрэн нийцүүлэх, Олон улсын эрүүгийн шүүхийн Эрх ямба, дархан эрхийн тухай хэлэлцээрийг соёрхон батлах /Эстони/**

Хэрэгжих шатанд. Түрэмгийлэх асуудлаар Ромын дүрэмд орсон Кампалагийн нэмэлт өөрчлөлтөд нэгдэх асуудлыг УИХ-ын 2018 оны хаврын чуулганд, Олон улсын эрүүгийн шүүхийн Эрх ямба, дархан эрхийн тухай хэлэлцээрийг соёрхон батлах асуудлыг мөн энэ оны намрын чуулганд өргөн барихаар тус тус ажиллаж байна.<sup>3</sup>

**108.18. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмийн зохицуулалтыг үндэсний хууль тогтоомждоо тусгах /Португал/**

Хэрэгжсэн. Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 29 дүгээр бүлэг буюу Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг гэсэн бүлэгт түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх, төрлөөр устгах зэрэг Ромын дүрэмд хамаарах зохицуулалтыг тусгасан.<sup>4</sup>

**108.19. Яс үндэс, шашин, бэлгийн чиг баримжаа, эсхүл хүйсийн баримжаа, илэрхийлэл, хэл, улс төрийн үзэл бодол, оюуны эсхүл биеийн хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлан гадуурхахдаг бүх хэлбэрээс зайлсхийх зорилгоор ялгаварлан гадуурхахын эсрэг цогц хууль тогтоомжийг батлах /Чили/**

Хэрэгжээгүй. Ялгаварлан гадуурхахтай тэмцэх цогц хуультай болох талаар Засгийн газраас ямар ч санаачилга гараагүй ба “ялгаварлан гадуурхах” гэмт хэргийг шинэ Эрүүгийн хуульд тусгасан нь дэвшилттэй алхам болсон. Гэвч энэ гэмт хэргийн тухай хуульчид, хууль сахиулагчдад сургалт хийх, хуулийг сурталчлах санаачилга дутагдалтай байна. Аливаа хууль тогтоомжийн үл ялгаварлан гадуурхах зарчмыг хэрэгжүүлэх, тэгш байдлыг бодит амьдралд баталгаажуулах тодорхой алхам хэрэгжүүлээгүй. Нийгэмд хүнийг яс үндэс, үзэл бодол, нас хүйс, хэл, аялга, үгсаатны бүлэг, нийгмийн байдал, хүйсээр хэт их ялгаварлаж байгаа нь хүүхэд, өсвөр насныхны төлөвшилд сөргөөр нөлөөлж байна. ХЭҮК, Сайн хөрш ОУБ-ын хамтран явуулсан "Хүүхдийн эрх, хамгаалал" судалгааны 2016 оны тайланд арван хүүхэд тутмын 6 нь ямар нэг хэлбэрийн ялгаварлан гадуурхалтад өртөж байна гэжээ.

Хамгаалагдсан буюу үл ялгаварлах үндэслэлд бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл Монгол Улсын Үндсэн хуульд одоогийн байдлаар тусаагүй ч олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр “хүйс” хэмээх үг нь дотроо бэлгийн чиг баримжааг багтаана гэж үздэг. Гэсэн хэдий ч хүртээмжтэй ба тодорхой байх үүднээс "бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэл"-ийг багтаах ёстой гэсэн зөвлөмжийг Хүний эрхийн зөвлөлөөс 2010, 2015 онд тус тус зөвлөсөн. Гэвч одоо хэлэлцэж буй Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд энэ асуудлыг хэлэлцэхгүй өнгөрөх магадлал өндөр байна.

**108.20. Ялгаварлан гадуурхахтай тэмцэх цогц хууль тогтоомжийг батлах, ийнхүү батлах хууль тогтоомж, эсхүл одоо байгаа хуулиар тогтоосон тэгш байдлыг бодит амьдралд баталгаажуулах алхмыг авч хэрэгжүүлэх /Ирланд/**

Хэрэгжээгүй. Холбогдох мэдээллийг 108.19-өөс үзнэ үү.

**108.21. ЛГБТ хүмүүс зэрэг нийгмийн цөөнх бүлгүүдийн нийт гишүүний эрхийг хамгаалах ялгаварлан гадуурхахын эсрэг иж бүрэн хууль тогтоомжийг батлах /Англи/**

Хэрэгжих шатанд. Эрүүгийн хуулиар “ялгаварлан гадуурхах” үйлдлийг гэмт хэрэгт тооцсон нь энэ төрлийн үйлдэл, эс үйлдэхүй үйлдэхийг хориглосон хууль зүйн үндэслэл юм.<sup>5</sup>

**108.22. Эрүүгийн шинэ хуулиа батлах явцаа хурдасгах /Турк/**

Хэрэгжсэн. УИХ-аас 2015 оны 12-р сарын 3-нд Эрүүгийн хууль баталж, 2017 оны 5-р сарын 11-нд нэмэлт өөрчлөлт оруулж, 2017 оны 7-р сарын 1-ээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.

**108.23. Хүн бүрийн эрх тэгш болон аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин, хүний эрхийн соёлыг баталгаажуулахын тулд Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулах, бусад шаардлагатай эрх зүйн орчноо сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй нааштай ажлаа хурдасгаж, батлагдсан хуулиа үр дүнтэй хэрэгжүүлэх /Норвеги/**

Хэрэгжих шатанд. УИХ-аас 2015 оны 12-р сарын 3-нд Эрүүгийн хууль баталж, 2017 оны 5-р сарын 11-нд нэмэлт өөрчлөлт оруулж, 2017 оны 7-р сарын 1-ээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Гэвч 2017 оны нэмэлт өөрчлөлтөөр зарим үхралт хийсэн. Тухайлбал, бэлгийн дарамтыг гэмт хэрэгт тооцсоныг хүчингүй болгосон. Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудыг тус тус 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр баталмагц, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдүүлсэн. “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” УДШ, УЕП, ХЗДХС-ын хамтарсан 28/А-49/А-141 тушаалаар 180 сургагч багш бэлтгэж, нийслэл, орон нутагт нийт 20 бүсэд 8,191 албан хаагчийг хамруулсан 5 өдрийн сургалтыг 2017 оны 6-р сарын 11-24-нд зохион байгуулсан байна.<sup>6</sup> Гэсэн хэдий ч энэ нь хуульч, хууль сахиулагчдыг шинэ эрх зүйн орчинд ажиллах бэлтгэлийг хангахад хангалттай биш бөгөөд эдгээр хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой тулгамдсан асуудлууд үүнийг батална.<sup>7</sup>

**108.24. Хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настай хүмүүс, эмэгтэйчүүд зэрэг хүн амын эмзэг бүлгийн эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих ажлаа үргэлжлүүлэх /ОХУ/**

Хэрэгжих шатанд. УИХ-аас 2016 оны 2 дугаар сард Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, 2017 оны 1-р сард Ахмад настны тухай хуулийг тус тус баталж, эрх зүйн орчинг хүний эрхэд нийцсэн байдлаар эрс шинэчилсэн. Гэсэн хэдий ч хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Шинэ эрх зүйн орчны хүрээнд хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангаж байсан агентлагийн чиг үүргийг өргөжүүлэн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн агентлаг байгуулж, аймаг, нийслэл, дүүрэгт салбаруудтай болж, үйл ажиллагааны төсвийг 2018 оноос эрс нэмэгдүүлсэн. Хүүхэд хамгааллын хүрээнд яаралтай тусламжийн 24 цагийн дуудлага хүлээн авах, орон нутагт эрсдэлт нөхцөлд байгаа болон хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх хамтарсан баг, гэмт хэргийн гэрч, хохирогч, сэжигтэн хүүхдэд шаардлагатай үйлчилгээ, хамгаалалт үзүүлэх “Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо”, хүүхдийн эрхийн зөрчлийг шийдвэрлэх үүрэгтэй, “жижиг хэргийн мөрдөгч” буюу хүүхдийн эрхийн үлсын байцаагчийг ажиллуулж эхэлсэн, цагдаагийн байгууллага хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бүтэцтэй болсон зэрэг нь чухал алхам юм. Гэвч хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр иргэд, иргэний нийгэм, олон нийтийн санаачилгыг дэмжих, хамтран ажиллах, харилцан ойлголцох шаардлага орон нутагт түлхүү тавигдаж байна. Хүүхдийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийг анхан шатанд хэрэгжүүлэхэд албан тушаалтан, хуулийн этгээдийн мэдлэг, үүргээ биелүүлэх санал, санаачилга дутмаг байна. Нөгөө талаас хүүхдийг насанд хүрсэн асран хамгаалагчгүйгээр бие даан амьдрах, дүүгээ асрах, гэрээ харах, сургуульд суралцах үүрэг хүлээлгэх хандлага орон нутагт нэмэгдэж байна.<sup>8</sup> Үүнээс шалтгаалж хүүхдийн эрхийн олон зөрчил гарч байна. Үүнтэй зэрэгцэн үндэстний цөөнх буюу казах, цаатан хүүхдүүд, шашин сүм хийдэд шавилан сууж байгаа хүүхдүүдийн сурч боловсрох эрх зөрчигдөж байгааг ХЭҮК-ын судалгааны дүн харуулж байна.

УИХ-аас жирэмсний 5 сартайгаас төрөх хүртэл, 3 хүртэл насны хүүхдээ асарч байгаа эхэд сар бүр, ихэр хүүхдэд нэг удаа, өрх толгойлсон эх, эцэгт улиралд тэтгэмж олгохоор хуульчилж,

улсын төсөвт жилд 96,8 тэрбум (40,5 сая ам.доллар) төгрөг суулгасан. Гэвч тэтгэмжийн хэмжээ туйлын бага тул энэ нь бодит дэмжлэг болохгүй байна. Тухайлбал, хүүхдээ 3 нас хүртэл асарч байгаа эхэд сард 20 орчим ам.доллар олгож байна. Нөгөө талаас ийм бодлого нь эмэгтэйчүүдийн ажил, орлоготой байх боломжийг хязгаарласан, эрхийг нь дордуулсан зохицуулалт юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан асран хамгаалагч авсан бол өөр халамж, нийгмийн үйлчилгээ авахгүй гэсэн журам нь тэдний эрхийг зөрчих үндсэн шалтгаан болж байна. Эдгээр хүмүүсийг асран хамгаалж буй хүмүүсийн сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхлэх эрх мөн зөрчигдөж байдаг. Статистикаас харахад хүүхэд асарсан, өвчтэй хүн асарсан шалтгаантай ажилгүйчүүдийн эдийн засгийн идэвхгүй хүн амд эзлэх тоо байнга өссөн дүнтэй. Энэ нь нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн бодлого хүний эрхэд суурилагүй болохыг батлан харуулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг дээрдүүлэх хууль эрх зүйн орчныг сайжруулах ажил хийгдэж байгаа ч эрхэд суурилсан хандлагаар цогцоор нь авч үзэхгүй байна. Үүний улмаас хууль зөрчсөн хувь хүн, хуулийн этгээдэд оногдуулах хариуцлагыг орхигдуулсан нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тунхаглалын шинжтэй хууль болоход хүрээд байна. Мөн хуулийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай урьдчилсан арга хэмжээ, тухайлбал хуулийг сурталчлах ажил хангалтгүйгээс тухайн хуулийн талаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, төрийн албан хаагчид мэдэхгүйн зэрэгцээ хуулийг буруу тайлбарлан хэрэглэж хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг зөрчиж байна. Түүнчлэн хуулийн хэрэгжилтийг хангах тодорхой журмуудыг батлах ёстой ч өнөөг хүртэл ихэнх нь хүлээгдсээр. Төрийн албан хаагчдын халаа сэлгээ их байгаагаас төрийн залгамж чанар алдагдаж хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах төрийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байна.

#### **108.25. Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийг өөрчлөн Парисын зарчимд нийцүүлэн өөрчилж, комиссын чадавхыг сайжруулах /Сиерра Леон/**

Хэрэгжих шатанд. УИХ-аас ХЭҮК-ын төсвийг нэмэгдүүлж, хуульд өөрчлөлт оруулах Ажлын хэсгийг ХЗДХЯ-ны дэргэд байгуулсан нь сайшаалтай. Гэвч хараат бүс байдлыг бэхжүүлэх чиглэлээр хийх алхам нь одоог хүртэл тодорхойгүй байна. Тиймээс хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай, санхүүгийн болон хүний нөөцийн чадавхтай байх, санхүүжилтийг гүйцэтгэх засаглалаас хараат бусаар батлах нөхцөлийг хуульд тусгах шаардлагатай. Мөн ХЭҮК-ын гишүүнд тавих шаардлагад өндөр ёс зүйтэй, хүний эрхээр мэргэшсэн байх тухай нэмж тусгах, нэр дэвшүүлэх, томилох үе шатад иргэний нийгмийн оролцоог хангах, ил тод, нээлттэй байх зохицуулалтыг тусгавал зохино.

#### **108.26. Боловсролын салбарт, ялангуяа хууль сахиулах алба хаагчдад хүний эрхийн сургалт хийх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх /Морокко/**

Хэрэгжих шатанд. Хууль сахиулагчдын дотоодын сургалтын хөтөлбөрт хүний эрхийн сэдвийг тусгах чиглэлээр анхаарч ажиллаж байгаа ч, сургалтын чанар, үр нөлөөг үнэлэх замаар хөтөлбөрийг сайжруулах шаардлага тулгамдаж байна. Харин боловсролын салбарт хүний эрхийн чиглэлийн сургалт тун хангалтгүй хэвээр байна.

#### **108.27. Шүүгч, магистратуудын байнгын болон заавал хамрагдах сургалтын хөтөлбөрт хүний эрхийн болон олон улсын гэрээг хэрэглэх сургалтыг оруулах /Мексик/**

Хэрэгжих шатанд. МХХ-ны сургалтын хөтөлбөрт хүний эрхийн хичээл туссан байгаа ч сургалтын чанар, үр өгөөжийг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай хэвээр байна. Харин олон улсын гэрээг хэрэглэх талаар чанартай, хүртээмжтэй, хүрэлцээтэй сургалтын хөтөлбөр байхгүй.

**108.28. Хүний эрхийн үндэсний комиссын хараат бус байдлыг Парисын зарчимд нийцүүлэн түүний бүрэн эрхийг бэхжүүлэх /Чили/**

Хэрэгжих шатанд. 108.25-ыг үзнэ үү.

**108.29. Хүний эрхийн үндэсний комиссын хараат бус байдлыг баталгаажуулахын тулд илүүтэй дэмжлэг үзүүлэх /Австрали/**

Хэрэгжих шатанд. 108.25-ыг үзнэ үү.

**108.30. Хүний эрхийн чиглэлээрх үндэсний байгууллагууд болон тогтолцоогоо бэхжүүлэх ажлаа үргэлжлүүлэх /Непал/**

Хэрэгжих шатанд. ХЭҮК-ын тухай мэдээллийг 108.25-аас үзнэ үү. Хүний эрхийг хамгаалагчийн тухай хуулийн төслийг боловсруулсан ч батлах чиглэлээр ахиц гараагүй. УИХ-ын Хүний эрхийн дэд хороог бэхжүүлэх, чиг үүргийг өргөжүүлэх, Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, Зохицуулах зөвлөлийг бэхжүүлэх чиглэлээр тодорхой алхам хийгдсэнгүй. Мөн ТББ-ын ажиллах эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр хэрэгцээ шаардлагыг тандан судалж, хуулийн төслийн эхний хувилбар болон үзэл баримтлалын төслийг боловсруулж, хэлэлцүүлэг зохион байгуулж, санал аваад байна.<sup>9</sup>

**108.31. Парисын зарчмын дагуу бүрэн эрхээ чөлөөтэй, хараат бусаар хэрэгжүүлдэг болгох зорилгоор Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын чадавхыг өргөжүүлэн бэхжүүлэх шаардлагатай арга хэмжээг авах /Намиби/**

Хэрэгжих шатанд. 108.25-ыг үзнэ үү.

**108.32. Парисын зарчимд нийцүүлэх зорилгоор Хүний эрхийн үндэсний комиссын үйл ажиллагааг сайжруулах, ялгаварлан гадуурхалтын эсрэг үр нөлөөтэй тэмцэх эрх зүйн орчныг нь бэхжүүлэх /Нигер/**

Хэрэгжих шатанд. 108.25-ыг үзнэ үү.

**108.33. Монгол Улсад хүний эрхийг үр нөлөөтэй эдлүүлэх зорилгоор хүний эрхийн байгууллагуудыг бэхжүүлэх хүчин чармайлтаа цаашид үргэлжлүүлэх /Пакистан/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.25, 108.30-аас үзнэ үү.

**108.34. Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн зэрэг хамгийн эмзэг бүлгийн иргэдийн эрхийг хамгаалах үндэсний хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэх үүрэг амлалтаа биелүүлэх /Румын/**

Хэрэгжих шатанд. 108.24-ийг үзнэ үү.

**108.35. Засгийн газрын чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагуудыг оролцуулан бүх түвшинд хүний эрхийн боловсрол олгох, сургах хүчин чармайлтаа үргэлжлүүлэх /Пакистан/**

Хэрэгжих шатанд. Засгийн газрын хэрэгжүүлэгч байгууллагуудын түвшинд хүний эрхийн талаарх ойлголт мэдлэгтэй болох, түгээн дэлгэрүүлэх, бүх түвшинд хүний эрхийг хүндлэн сахих ажлыг нэгтгэн зохион байгуулах шаардлагатай байна. Ялангуяа сургалтын хөтөлбөрийг дэмжсэн төсөв батлах, яам, агентлагуудын удирдлагуудад чиглэл, үүрэг өгөх, биелэлтэд хяналт тавих ажил орхигдож байна. Төрийн албаны залгамж халааг алдагдуулахгүйгээр, шинээр томилогдсон төрийн албан хаагчдад хүний эрхийн сургалтыг тухайн байгууллага хариуцаж тогтмол тасралтгүй хийх ёстой гэж төрийн бус байгууллагуудаас санал оруулж байна. Төрийн



албанд ахиж дэвшихэд анхаарах гол шалгуур нь хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйг үйл ажиллагаандаа баримталж буй эсэх байхаар зохицуулалт хийх шаардлагатай. Харин Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор “Бүх нийтийн эрх зүйн боловсрол олгох үндэсний хөтөлбөр”-ийг баталж, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх тогтолцоо, төсвийг шийдсэн нь энэ чиглэлээр тун чухал алхам юм.

**108.36. Ээлжит нэгдсэн хэлэлцүүлгийн зөвлөмжийг оролцуулан олон улсын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах тогтолцоог бий болгох боломжийг судлан үзэх /Парагвай/**

Хэрэгжих шатанд. ЗГ-ын 2016 оны 204 дүгээр тогтоолоор Ээлжит нэгдсэн хэлэлцүүлгийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Орон тооны бус зөвлөлийг төр, төрийн бус байгууллагын төлөөлөлтэй байгуулж, даргаар нь Хууль зүй, дотоод хэргийн сайдыг томилсон. Тус Орон тооны бус зөвлөлийг 2016 онд байгуулж, анхны хурлаа 2017 оны 1-р сард зохион байгуулсан. Тус зөвлөл нь 2 удаа хуралдаад байна.

Гэрээний хороодод тайлан бэлтгэх журам, хариуцан боловсруулах байгууллагын хуваарийг Засгийн газрын 2009 оны 362 дугаар тогтоолоор баталж, улмаар 2017 онд 193 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан нь сүүлийн жилүүдэд гэрээний хороодод тайланг хугацаа хожимдолгүй хүргэх чиглэлээр гарч буй ахицтай салшгүй холбоотой юм.<sup>10</sup>

**108.37. Хүний эрхийн салбар дахь олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр ажиллах /Туркменистан/**

Хэрэгжих шатанд. НҮБ-ын ХЭЗ-д гишүүнээр сонгогдож, тэргүүлэх чиглэлийн хүрээнд ХЭЗ-ийн тогтоол, шийдвэрт хамтран оролцож байгааг онцлон тэмдэглэхийн зэрэгцээ Монгол Улс цаазаар авах ялыг халахад чиглэсэн олон улсын хамтын нийгэмлэгийн хүчин чармайлтыг дэмжиж, цаазын ялын эсрэг Олон улсын Хороог Дэмжих бүлгийн гишүүнээр идэвхтэй ажиллаж байгаагаас гадна Европын Холбоо, Аргентины талтай хамтран “Цаазаар авах болон эрүүдэн шүүхэд ашигладаг бүтээгдэхүүний худалдааг хориглох Дэлхий нийтийн холбоо” санаачилгыг эхлүүлсэн нь чухал алхам юм.<sup>11</sup>

**108.38. 2003 онд хүргүүлэх байсан ч одоог хүртэл хүргүүлээгүй байгаа анхдугаар илтгэлээ НҮБ-ын Эрүү шүүлтийн эсрэг хороонд хүргүүлж, хороотой үр нөлөөтэй хэлэлцүүлэг эхлүүлэх бололцоог олгох /Дани/**

Хэрэгжсэн. НҮБ-ын Эрүү шүүлтийн эсрэг хороонд анхдугаар илтгэлээ 2009.09.23-ны өдөр илгээсэн.

**108.39. Хүний эрхийн зөвлөлийн Тусгай процедур болон гэрээний байгууллагууд зэрэг олон улсын хүний эрхийн хяналтын механизмуудтай ажиллах цаашдын хамтын ажиллагааг судлан үзэх /Туркменистан/**

Хэрэгжих шатанд. Монгол Улс 2004 онд Хүний эрхийн зөвлөлийн бүтцэд багтдаг байгууллагын төлөөллийг Монгол Улсад тааламжтай үедээ айлчлах нээлттэй урилга хүргүүлсэн нь тун чухал алхам юм.<sup>12</sup> Сүүлийн жилүүдэд НҮБ-ын гэрээний хороодод тайлагнах үүргээ хэрэгжүүлэхэд ахиц гарч байгааг тэмдэглэх нь зүйтэй. 2017, 2018 онд НҮБ-ын ХЭЗ-ийн 2 тусгай илтгэгч, НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг Дэд хорооны төлөөллийг хүлээн авсан нь чухал ач холбогдолтой болсон. Гэвч НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн тусгай процедур, гэрээний хороодоос өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх асуудалд ажил хэрэгч ханддаггүй. Ихэнх зөвлөмж монгол хэл рүү хөрвүүлэгдэж, олон нийтэд ойлгомжтой байдлаар хүрч болох суваг, хэлээр түгээгддэггүй.

Ялангуяа, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн тусгай процедураас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хайнга хандаж байгаад цаашид анхаарах шаардлагатай.

**108.40. Хүний эрхийн салбар дахь техникийн туслалцааны болон чадавхыг сайжруулах олон улсын хөтөлбөрүүдэд идэвхтэй оролцох /Туркменистан/**

Хэрэгжих шатанд. Хүний эрхийн чиглэлээр НҮБ-ын ХЭДКГ, Европын холбоотой хамтран төсөл хэрэгжүүлж байгаа нь чухал ач холбогдолтой.

**108.41. Аливаа шалтгаанаар ялгаварлан гадуурхахтай тэмцэх шинэ хууль тогтоомжийг батлах /Уругвай/**

Хэрэгжсэн. Эрүүгийн хуулиар “ялгаварлан гадуурхах” үйлдлийг гэмт хэрэгт тооцсон нь энэ төрлийн үйлдэл, эс үйлдэхүй үйлдэхийг хориглосон хууль зүйн үндэслэл юм.<sup>13</sup>

**108.42. Ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийн эсрэг, түүний дотор хохирогчдын эрхийг хамгаалсан цогц хууль батлах /Чех/**

Хэрэгжих шатанд. Зарим мэдээллийг 108.41-ээс үзнэ үү. Хохирогч хамгааллын асуудлаар Тахарын албыг 2013 онд байгуулсан ч 2016 онд татан буулгасан нь ухралт болсон.

**108.43. Хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлээрх арга хэмжээнүүдээ үргэлжлүүлэн хэрэгжүүлэх /Япон/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.24-өөс үзнэ үү. Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийг 2016 онд тус тус баталсан ч хэрэгжилт сул, хуулиудын талаар иргэдийн ойлголт мэдлэг хангалтгүй, хүүхдийн эрхийн зөрчил тулгамдсаар байна.

Цалинтай ээж хөтөлбөр, "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах Үндэсний II Хөтөлбөр" зэргийг баталсан нь сайн хэдий ч бодит хэрэгцээ шаардлагыг хангахгүй, охид эмэгтэйчүүдийг "халамж авагч, нөхөн үржихүйн үүрэгтэн" хэмээн харсан, тэдний нийгэм, эдийн засагт оролцох, бие даасан цалин хөлс, эд хөрөнгөтэй байх эрхийг хаасан шийдвэр хэвээр байна. Эмэгтэйчүүд олноор өртөж байгаа (3 эмэгтэй тутмын 1) Ажлын байрны бэлгийн дарамт /АББД/-ын асуудлыг Эрүүгийн хуулиас хасаж гэмт хэрэгт тооцоогүй, улмаар Хөдөлмөрийн тухай хуулийн төсөлд туссан АББД-ын хариуцлагыг Зөрчлийн тухай хуульд бүдгэрүүлж, хариуцлагын механизмгүй болгох төлөвтэй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт<sup>14</sup> “хүүхэд төрүүлсэн ээжүүдэд даатгуулсан хэлбэрээс нь үл хамааран хөдөлмөрийн хөлснөөс адил хувиар тооцон тэтгэмж олгох эрх зүйн орчин бүрдүүлнэ, төрүүлж, өсгөсөн хүүхдийн тоогоор эхийн ажилласан хугацааг нэмэгдүүлэн тооцдог болно, 3 хүртэл насны хүүхэдтэй ээжүүдийн нийгмийн баталгааг сайжруулах “Цалинтай ээж” хөтөлбөр хэрэгжүүлж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа нь тасрахгүй байх эрх зүйн орчинг бүрдүүлнэ, хүүхдийн мөнгийг хүүхэд бүрд олгоно” зэрэг зорилтууд тусгагдсан. Энэ дагуу 2016 онд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт орж, 2017 онд Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд тэтгэмж олгох тухай хууль баталсан. Эдгээр бодлого, хуулинд эх болон өрх толгойлсон эцэг, эхийн нийгмийн хамгааллыг сайжруулахад чиглэсэн зохицуулалтууд тусгагдсан нь сайшаалтай ч эхчүүдийн, ялангуяа 0-3 насны хүүхэдтэй эхчүүдийн хөдөлмөр эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн зорилт орхигдсон, “хүүхэд асрах нь зөвхөн эмэгтэй хүний үүрэг” гэж үзэх хэвшмэл хандлагыг бэхжүүлсэн зарим зохицуулалт байгааг эргэн харах шаардлагатай. Тодруулбал:

1. Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль (2017)<sup>15</sup>

Жирэмсний 5 сартайгаас эхлэн хүүхэд төрүүлэх хүртэлх хугацаанд эх сар бүр тэтгэмж авах болсон (ойролцоогоор 17 ам.доллар); 4 хүртэлх насны ихэр хүүхэдтэй эх нэг удаа тэтгэмж авах эрхтэй (2 ихэр хүүхдэд тус бүрт 417 ам.доллар, гурав ба түүнээс дээш ихэр хүүхдэд хүүхэд тус бүрт 1250 ам.доллар) болсон. Хүүхэд төрүүлэх нь эмэгтэй хүний жам ёсны, биологийн шинж чанартай зайлшгүй холбоотой учраас дээрх зохицуулалт нь эхийн хамгааллыг нэмэгдүүлэх чухал алхам болсон. Түүнчлэн 0-18 хүртэлх насны гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэг улирал бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх тэтгэмж авах эрхтэй (улиралд ойролцоогоор 100 ам.доллар) болсон нь эмзэг нөхцөлд байгаа хүүхдийн хамгааллыг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ гэж харж байна.

Гэвч “төрүүлсэн, үрчлэн авсан 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхэд тэтгэмж болгон сар бүр 50 мянган төгрөг (21 орчим ам.доллар) олгох болсон нь Хөдөлмөрийн хуулин дахь хүүхдээ 3 нас хүртэл асрах чөлөөг **эх, эцэгт олгох**” тухай заалтыг зөрчсөн бөгөөд “хүүхэд асрах нь эмэгтэйчүүдийн үүрэг” гэх хэвшмэл ойлголтыг бэхжүүлж, хөдөлмөрийн уламжлалт хуваарийг гүнзгийрүүлж, залуу эмэгтэйчүүдийн хөлстэй хөдөлмөр эрхлэх, орлого олох, өмчтэй болох, мэргэжлээ дээшлүүлэх, ажил, албан тушаал ахих зэрэг боломжийг хааж байна.

2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулинд орсон өөрчлөлтүүд (2017)

Өмнөх хуулиар заавал даатгалд хамрагдсан ээж тэтгэмжийг цалин хөлснөөс 100 хувь, харин сайн дурын даатгалд хамрагдсан бол 70 хувиар авдаг байсныг өөрчилж, даатгагдсан хэлбэрээс үл хамааран 100 хувь бодуулж авдаг болсон.<sup>16</sup>

Гэвч хүүхэд асрахтай холбоотой зарим зохицуулалтыг өнгөц харахад эхийн хамгааллыг нэмэгдүүлсэн мэт боловч зөвхөн эхэд хамаарч, “эх хүүхдээ өөрөө харах ёстой” гэх уламжлалт ойлголтыг бэхжүүлсэн. Тухайлбал, тэтгэмжтэй чөлөө авч хүүхдээ асрах хугацааг “хүүхдээ гурван нас хүртэл асрах чөлөөтэй байсан хугацаа” болгон өөрчилсөн. Энэ хугацаанд ажилласан хугацаа, НДШ нь тасалдахгүй болсон. Ажил хийдэг ээж хүүхдээ 3 нас хүртэл харах бол НДШ-ийг ажил олгогч, сайн дурын даатгалд хамрагдсан ээжийн НДШ-ийг тэтгэмжийн сангаас, ажилгүй, орлогогүй ээж хүүхдээ асарч байгаа бол НДШ-ийн 50 хувийг төр хариуцаж, 50 хувийг нь өөрөө хариуцахаар зохицуулсан. Мөн улсад ажилласан жилийг төрүүлж өсгөсөн хүүхдийн тоогоор тус бүр 1.5 жилээр нэмэгдүүлэн тооцдог болсон.<sup>17</sup> Энэ мэт бодлого нь эмэгтэйчүүдийн хүний эрх, амьдралын бүх хүрээг харгалзаагүй, зөвхөн “эх хүн” гэсэн нүдээр харсан, өрөөсгөл бодлого тул нөхөн үржихүйн үүрэг хариуцлагаасаа шалтгаалан ялгаварлан гадуурхагдаж, хөдөлмөрийн зах зээл дээрээс шахагдах, улмаар эмэгтэйчүүдийн боловсролдоо оруулсан хөрөнгө оруулалт үнэгүйдэхэд хүрэхээр байна. Хүн амаа өсгөх зорилгоор төрөлтийг урамшуулж, эхэд олгож буй тэтгэмж нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 20 хувьтай тэнцэж байгаа бөгөөд энэ нь 20 хүрэхгүй ам.доллар байгаа нь урт хугацаандаа ядуурлыг гүнзгийрүүлэх нэг хүчин зүйл болохоор байна.

**108.44. Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн үүрэг, хариуцлагын талаарх нийгмийн хэвшмэл ойлголтыг өөрчлөх, ялгаварлан гадуурхах уламжлалт зан үйлийг халах арга хэмжээнийхээ үр нөлөөг сайжруулах хүчин чармайлтаа нэмэгдүүлэх /Словени/**

Хэрэгжээгүй. Төрийн зүгээс жендэрийн тэгш байдал, ялгаварлан гадуурхалтаас ангид байх тухай агуулга бүхий сургалтын хөтөлбөр боловсруулах, олон нийт, ард иргэдийг энэ чиглэлээр үхуулан таниулах, гэгээрлийн ажил огт хийхгүй байна. Одоог хүртэл эцгийн эрхт ёсны ойлголт, жендэрийн хэвшмэл ойлголттой ард иргэд, албан тушаалтан байсаар байна. Энэ нь эргээд эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурь, ажил, амьдралын карьерт сөргөөр нөлөөлж, улмаар

хүчирхийлэлд өртөх нэг эрсдэл болж байна. Мөн өсвөр насныхан, насанд хүрэгчдийн дунд үндэстний цөөнх, хөгжлийн бэрхшээл, гадаад өнгө үзэмж, амьдралын түвшингээр ялгаварлан гадуурхах үзэгдэл оршсоор байна. НҮБ-ын Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах Хороо Монгол Улсын ээлжит 8 ба 9 дүгээр илтгэлийг 2016 оны 2-р сард хэлэлцсэн. Тус Хороо нь гэр бүл, нийгэм болон хэвлэл мэдээлэлд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гүйцэтгэж буй үүрэг хариуцлагын талаар эцгийн эрх давамгайлсан чиг хандлага, ялгаварлан гадуурхсан үгшсан хэвшмэл ойлголт хэвээр байгаа нь гэр бүл, нийгэмд эмэгтэйчүүдийн дорой байдлыг гүнзгийрүүлж, улмаар мэргэжил боловсролын сонголтонд нь нөлөөлөх, төр, улс төрийн амьдралд тэдний оролцоог хязгаарлаж, хөдөлмөрийн зах зээл дээр тэгш бус оролцоог, мөн гэр бүлийн харилцаанд ч мөн тэгш бус статусыг бий болгож байгаад, түүнчлэн уламжлал болсон сөрөг чиг хандлагыг өөрчлөх, арилгах талаар тууштай арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй байгаад сэтгэл зовниж байгаагаа илэрхийлсэн.<sup>18</sup> Хороо ялгаварлан гадуурхсан хэвшмэл ойлголтыг өөгшүүлсэн төрөлтийг дэмжсэн бодлого хэрэгжүүлэхгүй байхыг зөвлөж, 2 жилийн дотор буюу 2018 онд багтаан уг зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээний талаарх мэдээллээ илгээхийг Засгийн газарт даалгасан билээ.<sup>19</sup>

**108.45. Эмэгтэйчүүдэд тэгш байдал, хамгаалалтыг олгож буй хууль тогтоомж, үр нөлөөтэй хэрэгжилтийг баталгаажуулах арга хэмжээгээ гүнзгийрүүлэх /Аргентин/**

Хэрэгжих шатанд. Жендэрийн тэгш байдлын тухай хуулийн дагуу байгуулагдсан Үндэсний хорооны Ажлын албыг нэг яамны түвшинд аваачиж сулруулсан байснаа залруулж Ерөнхий сайдын дэргэд ажиллуулах тухай ЗГ-ын шийдвэр 2018 оны 4-р сард гарсан нь энэ чиглэлээр гарсан нэг ололт юм. Жендэрийн тэгш байдлын тухай хууль болон үндэсний хөтөлбөрийг баталсан хэдий ч уг хуулийг олон нийтэд таниулах ажил сул, хуулийн хэрэгжилт хангалтгүй. Үндэсний хөтөлбөрийг шинэчлэн батлахад иргэний нийгэм, олон талын төлөөлөл оролцсон эсэх тухай мэдээлэлгүй. Мөн хөтөлбөрийн төлөвлөгөө, үйл ажиллагаа, төсвийн талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлэхгүй байна. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал нь жендэрийн тэгш байдлыг тусгаагүй, эдийн засгийн салбарууд дахь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн ялгаатай байдлыг арилгах асуудлыг огт тусгаагүй. Хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд нь эмэгтэйчүүд бага ажилладаг салбарууд байна. Ялангуяа орон нутагт энэ чиглэлийн хүний нөөц, ажиллах бүтэц хангалтгүй байна.

**108.46. Эмэгтэйчүүдийн эрхийн хамгаалалтыг сайжруулах чиглэлээрх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх /БНАСУ/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.43, 108.44, 108.45-аас үзнэ үү. Эмэгтэйчүүдийн хүний эрхийг хангах арга хэмжээг зөвхөн эхийн хамгааллын хүрээнд авч хэрэгжүүлж байгаагаас эмэгтэйчүүд албан/хөлстэй хөдөлмөрийн зах зээл дээр нөхөн үржихүйн үүрэг хариуцлагаас шалтгаалсан ялгаварлан гадуурхалтад өртөж, хүүхдээ өсгөх болон хөдөлмөр эрхэлж, орлого олох боломжийг хослуулах, өмчлөх, нийгмийн баялгаас тэгш хүртэх боломж нь хязгаарлагдаж, улам эмзэг, эрсдэлт байдалд орж байна.

**108.47. Төрийн албан дахь эмэгтэйчүүдийн оролцоо, жендэрийн тэгш байдлыг хангах ажлаа үргэлжлүүлэх /Лаос/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.45-аас үзнэ үү.

**108.48. Нийгэм, эдийн засгийн амьдрал дахь эмэгтэйчүүдийн идэвхтэй, бүрэн оролцоог цаашид дэмжих бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх /Сингапур/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.45-аас үзнэ үү.

**108.49. Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдлын асуудлаарх Аюулгүйн зөвлөлийн 1325 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөө батлах асуудлыг судлан үзэх /Португал/**

Хэрэгжих шатанд. НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1325 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөө батлах хүрээнд тогтоолыг монгол хэлээр орчуулж, “НҮБ-ын АЗ-ийн Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдлын асуудлаарх 1325 дугаар тогтоол: Хэрэгжилт, үндэсний түвшинд Үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж буй туршлага, сургамж” сэдвээр судалгаа хийлгэж, ХБНГУ-ын Фридрих Эбертийн сан, Солонгосын эмэгтэйчүүдийн хөгжлийн хүрээлэнгээс хамтран Сөүл хотноо зохион байгуулсан “Эмэгтэйчүүд, энх тайван аюулгүй байдал” сэдэвт олон улсын хуралд 2017 онд төлөөлөгч оролцуулж, Вена хотод ЕАБХАБ-ын Жендэрийн хэлтсээс зохион байгуулсан “Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдал” сэдэвт сургалтад 2018.IV.19-20-нд оролцож, мөн 2018.V.24-25-нд Бээжин хотноо НҮБ-ын Улс төрийн газраас зохион байгуулсан “Зүүн Хойд Ази дахь эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдлын асуудал” сэдэвт бүс нутгийн семинарт ГХЯ, БХЯ мөн ХЗДХЯ-ны экспертүүд оролцсон байна. Түүнчлэн 2018.V сараас Уганда Улсын Энтеббе хотод болж буй “НҮБ-ын цэргийн эмэгтэй алба хаагчдын дамжаа”-нд анх удаа Монгол Улсын Зэвсэгт хүчний офицер эмэгтэй суралцаж эхэлсэн байна.<sup>20</sup>

**108.50. Арьс үндэс, яс үндсээр ялгаварлан гадуурхахыг өдөөн хатгасан үзэн ядах үг хэлэх үйлдэлтэй болон үүнээс улбаатай хүчирхийлэлтэй тэмцэх /Хятад/**

Хэрэгжих шатанд. Шинэ Эрүүгийн хуулийн 14.1-р зүйлд “ялгаварлан гадуурхах”-ыг гэмт хэрэгт тооцсон бөгөөд 10.1-р зүйлд “...арьсны өнгө, үндэс, угсаа...үзэн ядаж алсан бол” хүндрүүлж үзэхээр зохицуулсан. Үзэн ядах үг хэлэхтэй холбоотой тодорхой зохицуулалт одоогоор байхгүй байна.

**108.51. Гэр хороололд амьдарч буй хүмүүсийн эсрэг шууд болон шууд бусаар ялгаварлан гадуурхах явдалтай тэмцэх үр нөлөөтэй арга хэмжээг авах /Швед/**

Хэрэгжээгүй. Улаанбаатар хотын нийтийн аж ахуйн үйлчилгээг сайжруулах, гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 1-р үе шат 2012 оноос хэрэгжихээр төлөвлөгдсөн бөгөөд 2017 оноос эрчимжсэн.<sup>21</sup> Уг төслийн хүрээнд УБ хотын 3 дүүргийн 6 хорооны 10,000 гаруй иргэн өртөж байна. Уг төсөл Азийн хөгжлийн банкны хамгааллын бодлогын дагуу хэрэгжихгүй байна. Үүнээс үүдэн 1. нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийгээгүй; 2. мэдээлэл хаалттай хүртээмжгүй төрөлх хэлээр биш; 3. айлган сүрдүүлсэн, дарамт учруулсан; 4. газрын эзэдтэй тохиролцоогүй; 5. өрх толгойлсон эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тусгайлан анхаараагүй; 6. Азийн хөгжлийн банкны хамгааллын бодлогод хяналт тавиагүй онц ноцтой төөрөгдөлд оруулсан; 7. албажсан баримтжуулсан харилцаа байхгүй; 8. хүйтний улирал үл харгалзан нүүлгэлт хийж байна. Нөлөөлөлд өртсөн зарим айл мэдээллийн онц ноцтой төөрөгдөлд орсны үршгаар амьдрах газаргүй болж, айлын хашаанд эсхүл түрээсийн байранд амьдарч байна. Нөлөөлөлд өртсөн нийт иргэдийн 80 орчим хувь зөвшөөрсөн гэж байгаа ч уг судалгаа баттай үгүй нь эргэлзээтэй. 2018 онд Монгол Улсад айлчилсан НҮБ-ын Ундны усны тусгай илтгэгчийн тайланд нийслэлийн гэр хорооллын иргэдийн ундны усны аюулгүй байдал, үнэ, хэмжээ нь орон сууцны хорооллын иргэдийнхээс хэт зөрүүтэй байгааг онцлон анхаарахыг зөвлөсөн байна.

**108.52. Гадаадын иргэдийг аливаа хэлбэрийн халдлагаас хамгаалах, гэмт этгээдэд хариуцлага хүлээлгэх хүчин чармайлтаа ахиулах /БНСУ/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.50-аас үзнэ үү. Англи, герман, хятад, солонгос, орос хэлээр гадаадын иргэдэд үнэгүй хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагааг зохион байгуулж байгаа нь чухал ахиц юм.<sup>22</sup>

**108.53. Бэлгийн чиг баримжаа, эсхүл хүйсийн баримжаа, илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтыг оролцуулан ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэртэй тэмцэх /Франц/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.19, 108.41-ээс үзнэ үү. Шинэ Эрүүгийн хуульд ялгаварлан гадуурхах гэмт хэргийг шинээр томъёолохын зэрэгцээ ялгаварлан гадуурхахыг хориглосон зүйлийг өргөтгөн тайлбарласан. Мөн УИХ-д өргөн бариад буй Хөдөлмөрийн тухай хуулийн төсөлд ялгаварлан гадуурхахгүй байх зарчимд “бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл” хэмээн тусгаад байна.

**108.54. ЛГБТИ хүмүүсийн хүний эрхийн үр нөлөө бүхий хамгаалалт тогтоосон хууль тогтоомжийг боловсруулж батлахаас гадна Нэн ядуурал ба хүний эрхийн асуудлаарх Тусгай илтгэгчийн илтгэлд дурдсан ЛГБТ хүмүүсийн эсрэг үйлдсэн гэх халдлагуудыг хараат бус байдлаар мөрдөн шалгах арга хэмжээ авах /Гондурас/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.41, 108.53-аас үзнэ үү. Эрүүгийн хуульд туссан ч хуулийг хэрэгжүүлэх хууль сахиулагчид шинэ хуультайгаа танилцаж амжаагүй, шинэ төрлийн гэмт хэргүүдийн талаар сургалт орж таниулаагүй. ХЭҮК-т ЛГБТ олон нийтийн гаргасан гомдлын дагуу нийслэлийн бүх цагдаагийн нэгж дээр бэлгийн цөөнхийн талаарх ойлголтыг сайжруулах сургалтыг энэ асуудлаар дагнан ажилладаг байгууллагуудаас авахыг зөвлөсний дагуу ЛГБТ төв бүх нэгж дээр мэдээлэл өгсөн нь сайшаалтай ч тогтмол сургалтын хөтөлбөрт тусаагүй байна.

**108.55. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтыг оролцуулан ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэрийг хориглох /Словени/**

Хэрэгжсэн. Холбогдох мэдээллийг 108.41-ээс үзнэ үү. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтыг оролцуулан ялгаварлан гадуурхахыг шинэ Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцсон.<sup>23</sup> Гэсэн хэдий ч энэ гэмт хэргийн тухай хуульчид, хууль сахиулагчдад сургалт хийх, хуулийг сурталчлах ажил учир дутагдалтай байна.

**108.56. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн байдал болон эрүүл мэндийн байдалд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтыг оролцуулан ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэрийг хориглох /Зүүн Тимор/**

Хэрэгжсэн. Холбогдох мэдээллийг 108.55-аас үзнэ үү.

**108.57. Өөрийн үндэсний хууль тогтоомждоо тусган оруулах замаар ЛГБТИ хүмүүс эрхээ эдлэх тэгш байдлыг хөхиүлэн дэмжих /Уругвай/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.19, 108.41, 108.54-өөс үзнэ үү.

**108.58. Үзэн ядах, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхах гэмт хэргүүдийг эрүүгийн хууль тогтоомждоо оруулах зорилгоор тухайн хууль тогтоомжийг өөрчлөх /Испани/**

Хэрэгжсэн. 2015 онд баталсан шинэ Эрүүгийн хуульд "ялгаварлан гадуурхах" гэмт хэргийг шинээр зүйлчилсэн. Гэвч хууль сахиулагчид шинэ хуулийн тухай мэдлэг мэдээлэл багатай байна. ЛГБТ төвөөс зохион байгуулсан сургалтанд оролцсон хууль сахиулагчид цагдаагийн байгууллагын албан хаагчдын давтан сургалтын хөтөлбөрт энэ сэдвийг оруулах шаардлага

байгааг онцолж байсан. Учир нь мэдээллийн зөрүүтэй байдал их байгаа бөгөөд хуучинсаг хандлагаар хандах явдал цагдаагийн алба хаагчдын дотор байгааг үгүйсгээгүй.

**108.59. ЛГБТ хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, ийм явдлыг үл тэвчих хандлагыг дэмжих зорилгоор олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх сурталчилгааны ажлыг зохион байгуулах /Бразил/**

Хэрэгжээгүй. Олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх сурталчилгааны ажил Засгийн газар болон түүний агентлагуудаас хийгдээгүй ба "ЛГБТ Төв"-өөс зохион байгуулдаг олон нийтэд үнэн, бодит мэдээллийг өгөх зорилготой үйл ажиллагааг төрийн байгууллагуудын зүгээс хязгаарлах сонирхолтой байдаг.<sup>24</sup> Энэ чиглэлийн сурталчилгаанд төсвөөс мөнгө зарцуулаагүй.

**108.60. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлтэй тэмцэх хүчин чармайлтаа сайжруулж, энэ чиглэлээрх датаг цуглуулах, мэдээлэл, статистикийг гаргах ажлыг зохион байгуулалттайгаар хийж гүйцэтгэх /Нидерланд/**

Хэрэгжих шатанд. ЦЕГ-ын Тэргүүн дэд даргын 2018 оны 3 тоот тушаалаар гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн нэгдсэн сан, тайлан мэдээний програм хангамжийг шинэчлэх Ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаа бөгөөд шинээр бүрдүүлэх мэдээллийн сангийн жагсаалтад "Ялгаварлан гадуурхах" гэмт хэргийг багтаасан байна.<sup>25</sup>

**108.61. Өмнөх удаа зөвлөмж болгож байсанчлан ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэрийг, тэр дундаа ХДХВ/ДОХ-той гэсэн үндэслэлээр ялгаварлан гадуурхахыг эрс хориглох, урьдчилан сэргийлэх, шийтгэх, болон устгах зорилготой хууль тогтоомжийг батлах зэргээр үр нөлөөтэй, шуурхай арга хэмжээ авах /Мексик/**

Хэрэгжих шатанд. Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/305 дугаар тушаалаар "БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тусламж, үйлчилгээ үзүүлэх журам" баталж, ХДХВ-ын халдвартай эхчүүдийг харьяаллын дагуу төрөх газарт төрүүлдэг болсон нь ялгаварлан гадуурхсан буруу практикийг халсан сайн талтай. 2017 онд халдвартай 7 эх бүгд харьяаллын дагуу төрөх газартаа төрсөн байна.

Гэвч ялгаварлан гадуурхалтын эсрэг цогц хууль тогтоомж гаргах талаар хууль санаачлагчдын болоод ЗГ-ын төлөвлөгөө гараагүй. ХДХВ/ДОХ-той хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхалтыг хориглох, урьдчилан сэргийлэх, устгах чиглэлээр тодорхой ахиц байхгүй. Шинэ Эрүүгийн хуульд ХДХВ/ДОХ халдаахыг гэмт хэрэгт тооцсон.<sup>26</sup> Шинээр гэрлэгсэд ХДХВ/ДОХ шинжилгээ хийлгэх үүрэгтэй. Биеэ үнэлэгч эмэгтэйчүүдийн эрхийн зөрчил маш их. Эрүүл мэндийн сайдын тушаалаар Эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөр боловсруулах баг байгуулж ажлаа эхэлсэн ч одоогоор үр дүн гараагүй. МСҮТ, коллеж, их дээд сургуулийн хөтөлбөрт эрүүл мэндийн хичээл оруулах тухай яригдаж байгаа ч алхам хийгдээгүй. Хар тамхины хууль бус хэрэглээтэй холбоотой гэмт хэргийн тоо өсөж, Хар тамхитай тэмцэх Үндэсний хөтөлбөр 2017 оны 3-р сард батлагдаж, хөтөлбөрийн хүрээнд Эрүүгийн цагдаагийн газарт Хар тамхитай тэмцэх тусгай тасаг байгуулагдаж, 30 гаруй орон тоотой ажиллаж байгаа ч гэмт хэргийн тоо өсөж, хар тамхи хэрэглэгчдийн тоо буурахгүй байгаа нь хөтөлбөрийн хэрэгжилт тодорхой үр дүнд хүрэхгүй байна.

ДОХ-ын Үндэсний Хорооны оронд "ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ" нэртэйгээр ЗГ-ын 2013 оны 425 дугаар тогтоолоор байгуулж<sup>27</sup>, Ерөнхий сайд ахалж, Эрүүл мэндийн сайд орлохоор тогтож, ажиллах журмыг баталсан ч, үр дүнтэй ажиллаагүй. Тус зөвлөлийг ЗГ-ын 2017 оны 288 тоот тогтоолоор шинэчлэн баталсан ч одоогоор хуралдаагүй байна. Хурлаа 2018 оны 6 сард хийхээр төлөвлөж байгаа юм байна.<sup>28</sup> ХДХВ, ДОХ-оос урьдчилан сэргийлэх, оношлох бүх үйлчилгээ Глобал сангийн санхүүжилтээр хийгдсэн хэвээр байна.

ХДХВ, ДОХ-ын эрсдэлд өртөх өндөр магадлалтай бүлэг болох бэлгийн цөөнх эрэгтэйчүүд, биеэ үнэлэгч эмэгтэйчүүд, хар тамхи хэрэглэгчдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тэдний хүний эрхийг хангах хамгаалах чиглэлээр эрүүл мэндийн бодлого шийдвэр гаргагчид, үйлчилгээ үзүүлэгчдийн мэдлэг ойлголт бага, харилцаа хандлага сул хэвээр байна.

**108.62. Монгол Улс соёрхон баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын Цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт II протоколд нийцүүлэн цаазаар авах ялыг халж хуульчлан баталгаажуулах /Франц/**

Хэрэгжсэн. 108.2-ыг үзнэ үү.

**108.63. Цаазаар авах ялыг бүрэн халсан хууль тогтоомж батлах /Австрали/**

Хэрэгжсэн. 108.2-ыг үзнэ үү.

**108.64. Цаазаар авах ялыг бүрэн халах зорилгоор Эрүүгийн хуулиа өөрчлөх /Итали/**

Хэрэгжсэн. 108.2-ыг үзнэ үү.

**108.65. Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд цаазаар авах ялыг эцэслэн халах /Англи/**

Хэрэгжсэн. 108.2-ыг үзнэ үү.

**108.66. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколыг соёрхон баталснаар хүлээсэн олон улсын үүргээ биелүүлэх үүднээс цаазаар авах ялыг халах хүрээнд эрүүгийн хууль тогтоомжоо шинэчлэх /Швед/**

Хэрэгжсэн. 108.2-ыг үзнэ үү.

**108.67. Цаазаар авах ялыг хуулиар халах зорилгоор шинэ Эрүүгийн хуулийг оролцуулан шаардлагатай хууль тогтоомжийг батлах /Словак/**

Хэрэгжсэн. 108.2-ыг үзнэ үү.

**108.68. Бүх төрлийн гэмт хэрэгт цаазаар авах ялыг de jure байдлаар оногдуулахгүй болгож халах /Монтенегро/**

Хэрэгжсэн. 108.2-ыг үзнэ үү.

**108.69. Цаазаар авах ялыг халж, цаазаар авхуулсан хүмүүсийн гэр бүлийг нууцаас хассан холбогдох мэдээллээр хангах /Литва/**

Хэрэгжээгүй. 2016 оны 12 дугаар сарын 1-ний өдөр Монгол Улсын Их Хурлаас баталж, 2017 оны 9 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн Төрийн болон албаны нууцын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд “2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр баталсан Төрийн болон албаны нууцын тухай хуулийг дагаж мөрдөхөөс өмнө хүчин төгөлдөр үйлчилж байсан Төрийн нууцын тухай, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд заасан цаазаар авах ялыг гүйцэтгэх журам, ажиллагаа, гүйцэтгэсэн тухай баримт бичиг нь төрийн нууцын “Маш нууц” зэрэглэлд хамаарах бөгөөд байнга нууцална” гэж заажээ. Гэвч ЗГ-ын 2016 оны 204 дүгээр тогтоолоор баталсан “НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”-нд цаазаар авах ялтай холбоотой мэдээллийг ил болгох эсэх асуудлыг шийдвэрлэхээр төлөвлөсөн тул ХЗДХЯ энэ асуудлаар эрх бүхий байгууллагуудтай зөвлөлдөж байгаа ч эцэслэн шийдээгүй байна.<sup>29</sup>



#### **108.70. Цаазаар авах ялын гүйцэтгэлийг улсын нууц мэдээллээс хасах /Португал/**

Хэрэгжээгүй. 108.69-ийг үзнэ үү.

#### **108.71. Хууль сахиулах албан хаагчид болон бусад төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр, мөн шүүгч, хуульч нарын байнгын сургалтын хөтөлбөрт эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх олон улсын зохицуулалтыг тусгах /Мексик/**

Хэрэгжих шатанд. Шүүгчдийн сургалтад 1 кредит цаг "Хүний эрх ба шүүхийн хамгаалалт" хичээлийг сонгон үзэхээр оруулсан. Прокуроруудад эрүүдэн шүүхээс ангид байх эрхээр 2016 оны 11-р сард сургалт явуулсан ч сургалтын байнгын хөтөлбөрт тусгагдаагүй. Бусад төрийн албан хаагчдад энэ чиглэлийн сургалт ордоггүй. Цагдаагийн алба хаагчдын сургалттай холбоотой мэдээллийг 108.73-аас үзнэ үү.

ХЭҮК-ын тайланд "цагдаагийн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдад энэ чиглэлийн сургалтыг тогтмол зохион байгуулж байна" гэж дурдсан ч хүртээмжтэй эсэх нь тодорхойгүй байна. Мөн сургалтыг зөвхөн цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажилтнуудаар хязгаарладаг. Прокурор, шүүгч, авлига, тагнуулын газар, хил, гаалийн ажилтнууд зэрэг бусад хууль сахиулах байгууллагууд болон төрийн байгууллагын албан хаагчдыг эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх сургалтад тогтмол, давтамжтай, хүртээмжтэй хамруулдаггүй.

#### **108.72. Эрүүдэн шүүсэн байж болзошгүй бүх хэргийг мөрдөн шалгах, хорих байрны болон шоронгийн барилга байгууламжийн нөхцөлийг сайжруулах, эрүүдэн шүүгдсэний улмаас хохирсон хохирогчдод эдлэх эрх зүйн хамгаалалтыг бэхжүүлэх /Чех/**

Хэрэгжих шатанд. 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1.4-т холбогдох байгууллагууд өөрийн алба хаагчийн үйлдсэн эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаа явуулах нөхцөлийг хязгаарлахтай холбоотой зохицуулалтыг тусгасан ба 2017 онд Улсын Ерөнхий Прокурор "Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгах, түүнд прокурор хяналт тавих харьяалал тогтоох тухай" А/67 дугаар тушаалыг шинэчлэн баталсан. Цагдаагийн газрын харьяа Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах хэлтэс эрүүдэн шүүсэн хэргийг удаа дараа хэрэгсэхгүй болгох саналыг прокурорт хүргүүлж байснаас харахад эрүүдэн шүүхээс хохирсон иргэдийг цаашид гомдлоо гаргах газаргүй болгож байна.<sup>30</sup> Тиймээс энэ төрлийн гэмт хэргийг үр нөлөөтэй мөрдөн шалгах механизм дутагдаж байгааг харуулж байна.

Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 26 цагдан хорих байрнаас 18 цагдан хорих байрыг шинээр барьж, 7 цагдан хорих байрыг шаардлагад нийцүүлэн засварласан нь хоригдогсдын нөхцөлийг сайжруулахад чухал алхам болсон. 2018 онд Өвөрхангай аймаг дахь цагдан хорих байрыг ашиглалтад оруулснаар бүх цагдан хорих байрны нөхцөлийг сайжруулах ажил хийгдэж дуусна. Үүний дүнд улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийт 26 цагдан хорих байр хоригдогч өмгөөлөгчтэйгөө ганцаарчлан уулзах стандартад нийцсэн өрөө, тасалгаагаар бүрэн хангагдана.<sup>31</sup> Шинээр баригдсан болон засвар, тохижилт хийгдсэн цагдан хорих байрууд НҮБ-аас баталсан "Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм"-ийн 9 дүгээр зүйлд заасан хорих өрөө, тасалгаанд тавигдах үндсэн шаардлагыг бүрэн хангаж байна. "Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль"-д зааснаар 1 хүнд ноогдох талбайн хэмжээ 2.5 м/кв байхаас шинээр ашиглалтад орсон хорих өрөөний талбайн хэмжээ дунджаар 3-3.5 м/кв болж нэмэгдэн, байгалийн гэрэл чөлөөтэй тусах, агаарын солилцоо бүрэн хийгдэх нөхцөлийг хангаад байна.<sup>32</sup> Түүнчлэн 3 эмнэлгийн барилгыг шинээр

барьж, 17 хорих ангийн хоригдлын байранд засвар тохижилт хийн, хорих өрөөний гэрэлтүүлэг, агааржуулалт, чийгшил, нэг хоригдолд ногдох талбайг хууль журамд нийцүүлэн, нийтийн хоол, сургалтын танхим, номын сан зэргийг тохижуулсан байна. “Сэжигтэн, яллагдагч, ялтны хоолны үйлдвэрлэл, үйлчилгээний үлгэрчилсэн загвар”-ыг батлан үйл ажиллагаандаа хэрэгжүүлснээр НҮБ-ын “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд”-ийн 20 дугаар зүйлд заасныг бүрэн биелүүлэх болсон.<sup>33</sup>

**108.73. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх цагдаагийн албан хаагчдын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлэх, мөн энэ хэрэгт ял шийтгэлгүй үлдэх явдалтай тэмцэх үүднээс мөрдөн шалгах үр нөлөө бүхий тогтолцоог бий болгох /Франц/**

Хэрэгжих шатанд. Цагдаагийн албаны тухай хуулиар цагдаагийн байгууллагын дэргэд сургалтын төвтэй байхаар заасан нь тун чухал алхам юм.<sup>34</sup> Тус сургалтын төв нь 2018 онд 119 удаагийн 5,236 цагийн сургалтад 7,648 алба хаагчийг хамруулахаар төлөвлөсөн бөгөөд хүний эрхийн чиглэлээр 36 удаагийн 114 цагийн сургалт үүнд багтсан байна.<sup>35</sup> Гэвч зохион байгуулж буй сургалтын чанар, хүртээмж хангалтгүй байна гэж үзэж байна. Сургалтын төвөөс төлөвлөсөн 119 удаагийн сургалтыг хамруулахаар төлөвлөсөн нийт алба хаагчийн тоотой харьцуулбал нэг сургалтад оногдох оролцогчийн тоо 64 байгаа нь сургалтыг оролцоонд түшиглэсэн, үр дүнтэй арга зүйгээр хөтлөн явуулах боломжгүй болохыг харуулж байна. Мөн эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилсан сэргийлэх хөтөлбөрийн сэдэв, цаг, төлөвлөлтийн талаар мэдээлэл тодорхой биш байна.

ЦЕГ нь ХЭҮК-той хамтран хүний эрхийн сургагч багш бэлтгэх сургалтыг 2017, 2018 онд зохион байгуулсан нь хүний эрхийн хичээлийн хөтөлбөр, арга зүйгээ сайжруулахад чухал ач холбогдолтой санаачилга юм.

Мөрдөн шалгах тогтолцоотой холбоотой хэсгийг 108.72-оос үзнэ үү.

**108.74. Эрүүдэн шүүх үйлдлийг гэмт хэрэг хэмээн тодорхойлсон өөрчлөлтийг Эрүүгийн хуульд оруулах асуудлыг судлан үзэх /Унгар/**

Хэрэгжих шатанд. Шинэ Эрүүгийн хуульд хувь хүмүүсийн эрүүдэн шүүсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцоогүй, мөн энэ гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн хэмжээ тухайн гэмт хэргийн ноцтой байдалтай харьцуулахад хөнгөн байгаа нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид бүрэн дүүрэн нийцээгүй байна.<sup>36</sup> Хохирогч амь насаа алдсан тохиолдолд<sup>37</sup> л хүндрүүлэхээр авч үзсэн нь учир дутагдалтай.

**108.75. Соёрхон батлаад удаагүй байгаа Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколд заасан шаардлагын дагуу эрүүдэн шүүсэн болон зүй бусаар харьцсан байж болзошгүй хэргийг мөрдөн шалгах бие даасан тогтолцоог байгуулах /Австри/**

Хэрэгжээгүй. Үндэсний урьдчилан сэргийлэх механизмын тухай мэдээллийг 108.7-оос үзнэ үү. Мөрдөн шалгах бие даасан тогтолцоотой холбоотой мэдээллийг 108.72-оос үзнэ үү.

**108.76. Эрүүдэн шүүх болон зүй бусаар харьцсан төрийн албан хаагчийн үйлдлийг үл тэвчих, эрүүдэн шүүсэн бүх этгээдийг мөрдөн шалгах нөхцөлийг бүрдүүлэх /Зүүн Тимор/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.72, 108.74-өөс үзнэ үү.

**108.77. Цагдаагийн албан хаагч эрүүдэн шүүсэн болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг нь доромжлон харьцсан байж болзошгүй үйлдлийг мөрдөн шалгах**

**бие даасан тогтолцоог бий болгож, төрийн албан хаагч ийм төрлийн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх /Швейцари/**

Хэрэгжих шатанд. Мөрдөн шалгах бие даасан тогтолцоотой холбоотой мэдээллийг 108.72-оос үзнэ үү. Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төрийн албан хаагчдын сургалттай холбоотой мэдээллийг 108.71-ээс үзнэ үү.

**108.78. Эрүүдэн шүүсэн болон зүй бусаар харьцсан байж болзошгүй талаарх бүх гомдол, мэдээллийг бие даасан агентлаг бүрэн гүйцэд мөрдөн шалгадаг байх, тухайн үйлдлийг үйлдсэн этгээд хариуцлага хүлээдэг байх, түүнчлэн мөрдөн шалгалтыг зохих эрх мэдэлтэй, хараат бус болон сэжиглэгдэж буй этгээд, тэдгээрийн ажилладаг байгууллагад хамааралгүй бие даасан этгээд хийх нөхцөлийг бүрдүүлэх /Швед/**

Хэрэгжих шатанд. Мөрдөн шалгах бие даасан тогтолцоотой холбоотой мэдээллийг 108.72-оос үзнэ үү.

**108.79. Төрийн албан хаагч эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх үүднээс үйлдсэн байж болзошгүй бүх хэргийг нэн даруй, бүрэн гүйцэд шалгах нөхцөлийг хангах арга хэмжээг эрчимжүүлэх /Итали/**

Хэрэгжих шатанд. Мөрдөн шалгах бие даасан тогтолцоотой холбоотой мэдээллийг 108.72-оос үзнэ үү.

**108.80. Эрүүдэн шүүх, зүй бусаар харьцахыг устгах арга хэмжээг үргэлжлүүлэх, түүний дотор хууль сахиулах албан тушаалтнуудыг сургах, боловсрол олгох /Коста Рика/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.71, 108.73, 108.74-өөс үзнэ үү.

**108.82. Хоригдож буй хүмүүстэй харьцах нөхцөлийг сайжруулахад чиглэсэн зохих алхмыг авч хэрэгжүүлэх /Япон/**

Хэрэгжих шатанд. Зарим мэдээллийг 108.72-оос үзнэ үү. Шинэчлэн баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хоригдож буй хүмүүстэй харьцах нөхцөлийг сайжруулах зохицуулалтыг боловсронгуй болгож, хоригдлын эрхийг өргөтгөж хуульчилсан.<sup>38</sup> Алба хаагчдын хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Хүний эрх ба хорих ял” номыг алба хаагчдын хүртээл болгосон. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/249 дүгээр тушаалаар баталсан “2018 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд зохион байгуулах мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө”-ний хүрээнд алба хаагчдад хүний эрхийн сургалт зохион байгуулж байна. “Хорих байгууллага ба хүний эрх” сэдэвт сургалтыг Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, Монголын хуульчдын холбоотой хамтран 2017 оны 11-р сард зохион байгуулж, хорих анги, байгууллагуудаас нийт 34 алба хаагч хамрагдсан. Мөн НҮБ-ын Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх дэд хорооноос өгсөн зөвлөмжийн хүрээнд 2017 оны 10 дугаар сарын 20-ны өдөр нийт хорих анги, байгууллагад ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд “Стамбулын протокол”-ыг танилцуулах сургалт зохион байгуулсан. 2018 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр ХСИС-ийн захирлын тушаалаар “Хорих байгууллагын аюулгүй байдал-Хууль сахиулах ажил” бакалаврын зэрэг олгох сургалтын хөтөлбөрийг шинэчлэн баталж, заавал судлах сургалтын хөтөлбөрт “Хүний эрх” хичээлийг 96 цаг буюу 2 кредит/цаг байхаар тусгасан зэрэг нь сайшаалтай.<sup>39</sup>

**108.83. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хууль тогтоомж батлах /Зүүн Тимор/**

Хэрэгжсэн. Нийгмийн бүх орчинд бүх төрлийн хүчирхийллийг тухайлбал Хүүхэд хамгааллын тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай, Боловсролын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Зөрчлийн тухай, Эрүүгийн хуулиар тус тус бүрэн хориглосон. Ингэснээр зөвлөмж хэрэгжсэн гэж үзэж байна. Түүнчлэн эдгээр хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, гэр бүлийн хүчирхийлэлд аюулын зэргийн үнэлгээ хийх, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод эрх зүйн туслалцаа үзүүлэх, нэг цэгийн цогц үйлчилгээ үзүүлэх, хохирогчийг хүчирхийлэгчтэй үүлзүүлэх журмууд болон нийгмийн ажлын мэргэжлийн ёс зүйн дүрэм, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэгчийг магадлан итгэмжлэх зэрэг 30 гаруй дүрэм журмыг шинээр батлан хэрэгжүүлж эхэллээ. Хүчирхийллийн хохирогчийг хамгаалах "түр хамгаалах байр"-ыг шинээр хэд хэдэн аймаг, орон нутагт байгуулаад байна.

#### **108.84. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээрх идэвхтэй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх /Беларус/**

Хэрэгжих шатанд. "Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх"-ийг шинээр гэмт хэрэгт тооцож, мөн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиа шинэчлэн баталсан. Олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх зорилгоор 2017 оны 11 дүгээр сард "Хайрла-Хамгаал" үндэсний цахим аян зохион байгуулж гэр бүлийн хүчирхийлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох агуулга бүхий видео сурталчилгааг олны танил хүмүүсийг оролцуулан бэлтгэж, 65,149 цахим сүлжээний хэрэглэгчдэд хүргэсэн, их, дээд сургуулийн оюутнуудын дунд "Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, хүүхдийг хамгаалахад оюутан залуучуудын оролцоо" сэдэвт мэтгэлцээн зохион байгуулж 48 их, дээд сургуулийн 96 мэтгэлцээний багийг оролцуулсан арга хэмжээ зохион байгуулсан нь чухал ач холбогдолтой юм.<sup>40</sup> Мөн алба хаагчдыг сургахын зэрэгцээ ХСИС-ийн Цагдаагийн сургалтын хөтөлбөрт "Гэр бүлийн хүчирхийлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох" агуулга бүхий хичээлийг заавал үзэх хичээлээр оруулсныг сайшааж байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан цагдаагийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийж, энэ чиглэлээр тусгайлсан нэгж байгуулан, ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтэст гэр бүлийн хүчирхийлэл хариуцсан 3 ажилтан ажиллаж байгаа нь шинэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулахад чухал алхам юм.

Гэвч Тахарын албыг татан буулгасан нь томоохон үхралт болсон. Гэрч хохирогч хамгаалалтгүй үлдсэнээр гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсөд хамгаалалтад орж чадахгүй, зөвхөн эрүүгийн хэрэг үүсгэсний дараа Цагдаагийн байгууллагын хамгаалалтад орох нөхцөл бүрдэж байна. Цагдаагийн алба хаагчийн дарамт хүчирхийлэлд өртөгсөд далд, нуугдмал болж байна. Тухайлбал, Н хэмээх орон нутгийн бүсгүй нөхөр нь мөрдөн байцаагч учир цагдаад хандаж чадахгүй, айж буйгаа ТББ-д илэрхийлсэн байна.

Мөн түүнчлэн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу гарсан журмууд нь хуулийн үзэл баримтлалаас давсан, практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаагаас шинэ хуулийн үр нөлөөтэй хэрэгжилтэд саад учруулж байна. Хуулийг хэрэгжүүлэх төсөв (хүний нөөц бүрдүүлээгүй, тэдгээрийг сургах, мэдээлэлжүүлэх, чадавхжуулах үйл ажиллагаа хангалтгүй) тусгайлан батлаагүй нь шинэ хууль, журмуудыг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэхгүй байгаагийн нэг шалтгаан болж байна. Тухайлбал, Нэгэн аймагт хуулиар хэсгийн төлөөлөгч 4 байх ёстой ч нэг л хүн ажиллаж байгаа бөгөөд ачаалал ихээс шалтгаалан ажлаасаа гарах тухай ярьсан байна. Энэ мэт боловсон хүчний тогтворгүй байдал хуулийг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байна.

**108.85. Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох хүчин чармайлтаа улам идэвхжүүлэх /Филиппин/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.84-өөс үзнэ үү.

**108.86. Гэр бүлийн болон жендэрт суурилсан хүчирхийлэл, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг халах чиглэлээр илүү хүчин чармайлт гаргах, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэх замаар нийгмийн бүх салбарт эмэгтэйчүүдийн төлөөллийг илүүтэй баталгаажуулах /БНСУ/**

Хэрэгжих шатанд. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээллийг 108.84-өөс, эмэгтэйчүүдийн төлөөллийг илүүтэй баталгаажуулах талаарх мэдээллийг 108.45-аас үзнэ үү.

**108.87. Гэрлэлтийн хүчин, бэлгийн дарамтыг эрүүгийн хэрэгт тооцох, хохирогчийн шүүхэд хандах, туслалцаа болон хамгаалалт авах эрхийг баталгаажуулах, ийм төрлийн хэргийг зохих ёсоор мөрдөн шалгах, гэмт этгээдэд ял шийтгэлийг хуулийн дагуу заавал хүлээлгэх замаар жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлээс урьдчилан сэргийлэх хүчин чармайлтаа бэхжүүлэх /Словени/**

Хэрэгжээгүй. Бэлгийн дарамтыг 2015.12.03-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд гэмт хэрэгт тооцсон байсан ч 2017.05.11-ний өдрийн хуулиар хүчингүй болгосон.<sup>41</sup> Гэр бүлийн хүчирхийлэл, жендэрт суурилсан хүчирхийлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа олон ажил байгаа ч хөндлөнгийн үнэлгээ хийх замаар үйл ажиллагааны үр нөлөө, цар хүрээг нэмэгдүүлэхэд анхаарах нь зүйтэй. “Гэрлэлтийн хүчин”-г шинэ Эрүүгийн хуулийн “хүчиндэх” гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд туссан “гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэх” гэдэгт хамааруулж, 2-8 жилийн хорих ял оногдуулахаар байна. Энэ нь төрсөн эцэг/хойд эцэг нь хүүхдээ хүчиндэх зэрэг ураг төрлийн хүчинтэй ижил түвшинд авч үзсэн тул “гэрлэлтийн хүчин”-гийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй зохицуулалт гэж үзэхгүй байна.<sup>42</sup>

**108.88. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх ажлыг дэмжих эмэгтэйчүүдийн эсрэг бүх төрлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд чиглэсэн үндэсний стратеги баталж, үр нөлөөтэй хэрэгжүүлэх /Турк/**

Хэрэгжээгүй. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хөтөлбөр, стратеги төлөвлөж, олон ажил зохион байгуулсан ч хэр үр нөлөөтэй болсон тухай үнэлгээ байхгүй. Нөгөө талаас хууль, түүний журмуудын талаарх ойлголт зөрүүтэй, хэрэгжүүлэх арга зам тодорхойгүй, журмууд нь хоорондоо зөрчилдөх, боловсон хүчний мэдлэг чадвар харилцан адилгүй, салбар хоорондын уялдаа холбоо хангалтгүй байгаа нь тухайн стратеги үр нөлөөтэй эсэхэд эргэлзээ төрүүлж байна. Хэвлэл мэдээлэл, соёл урлагаар дамжуулан хийгдэх урьдчилан сэргийлэх ажиллагаа хүртээмжгүй. Эрүүл мэнд, боловсролын системд хүчирхийлээс ангид байх зан үйлд сургах талаар сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай.

**108.89. Гэр бүлийн хүчирхийллийг даван туулагсдын хамгаалалтыг улам сайжруулах, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, түүний шалтгаан, үр дагаврын асуудлаар Тусгай илтгэгчийг Монгол Улсад урих /АНУ/**

Хэрэгжих шатанд. Монгол Улс Хүний эрхийн зөвлөлийн олон улсын гэрээний хэрэгжилтийг хангах механизмын үйл ажиллагааг бүх талаар дэмжиж хамтран ажиллахын төлөө байдаг бөгөөд 2004 онд Хүний эрхийн зөвлөлийн бүтцэд багтдаг байгууллагын төлөөллийг Монгол Улсад тааламжтай үедээ айлчлах нээлттэй урилга хүргүүлсэн.<sup>43</sup> Тусгай илтгэгч тааламжтай

цагтаа Монгол Улсад ажиллах бүрэн боломжтой. Тиймээс холбогдох төрийн байгууллага Тусгай илтгэгчийг урих тал дээр санаачилга гаргах шаардлагатай юм.

**108.90. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээрх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх /Латви/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.84-өөс үзнэ үү.

**108.91. Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, мөрдөн шалгах тогтолцоог бэхжүүлэх, энэ төрлийн хэргээр ажилладаг хууль сахиулагчдыг сургах /Молдав/**

Хэрэгжих шатанд. Сургалт хийгдэж байгаа нь сайшаалтай ч хангалттай хамруулаагүй, тогтмол буюу чадавх суулгах хэмжээнд хийгдэхгүй байна. Хууль зүй, дотоод хэргийн яам, Олон улсын эрх зүйн байгууллагатай хамтран “Монгол Улс дахь жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх: хууль зүйн салбарын чадавхыг бэхжүүлэх” төслийг 2016 оноос хэрэгжүүлж байна. Уг төслийн хүрээнд “Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тэмцэхэд хууль зүйн салбарын чадавх, үялдаа холбоог бэхжүүлэх сургалт”-ыг заах сургагч багшийг бэлтгэж, гарын авлага боловсруулан хэвлүүлж 10 аймгийн 500 гаруй шүүгч, прокурор, цагдаагийн алба хаагч, өмгөөлөгчийг сургасан.<sup>44</sup> Мөн НҮБ-ын Хүн амын сан, Дэлхийн зөн ОУБ-ын дэмжлэгтэйгээр төв, орон нутгийн 1,132 алба хаагчийг сургалтад хамруулсан. Мөн цагдаагийн байгууллага 2017 онд дотоодын сургалтын хүрээнд 4,856 алба хаагчийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтад хамруулсан байна.<sup>45</sup> Энэ чиглэлийн сургалт олон улсын байгууллагаас олдсон санхүү төслийн хүрээнд ихэвчлэн хийгдэж байна. Мөн төрийн албан хаагчдын халаа, солио их байгаа нь сургалтын үр дүнг бууруулж байна.

**108.92. Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг одоогийн хуулиа үр нөлөөтэй хэрэгжүүлэх, алслагдсан газруудад хамгаалалтын байр барих зэргээр хохирогчдыг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээгээ бэхжүүлэх /Швейцари/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.84, 108.88, 108.91-ээс үзнэ үү. Олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд 7 аймаг, нийслэлд нийт 10, орон нутгийн санхүүжилтээр 2 аймагт нэг цэгийн үйлчилгээний төв байгуулахаар төлөвлөжээ.<sup>46</sup> Харин алслагдсан газруудад хамгаалах байр шинээр байгуулсан тухай мэдээлэл байхгүй байна.

**108.93. Гэр бүлийн хүчирхийллийг эрүүгийн хэрэгт тооцох, хохирогчдын хамгаалалтыг сайжруулах, гэмт этгээдэд ял шийтгэл оногдуулах зорилгоор Парламентаар хэлэлцэж буй гэр бүлийн хүчирхийллийн хуулийн төслийг батлах /Австрали/**

Хэрэгжсэн. УИХ 2016 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг баталсан. Мөн шинэ Эрүүгийн хуульд “гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх”-ийг гэмт хэрэгт тооцох болсон.

**108.94. Гэр бүлийн хүчирхийллийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдлэг ойлголтыг түгээх замаар гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх /Испани/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.88-аас үзнэ үү.

**108.95. Холбогдох байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, нотлох баримтын шаардлагыг эргэж харах болон тусгаарласан шийдвэрийн хэрэгжилтийг баталгаажуулах замаар гэр бүлийн хүчирхийллийн эсрэг эрх зүйн хамгаалалтыг авахад учирч буй саад тотгорыг арилгах /Австри/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.84, 108.91-ээс үзнэ үү.

**108.96. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үр нөлөө бүхий хамгаалалт авах, эрхээ сэргээлгэх боломжийг сайжруулах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэм буруутныг яллах чадавхыг бэхжүүлэх, гэрлэлтийн хүчинг эрүүгийн хэрэгт тооцох /Чех/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.84, 108.87, 108.91-ээс үзнэ үү.

**108.97. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, тэдний эсрэг хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд чиглэсэн одоогийн хууль тогтоомжийн үр нөлөөтэй хэрэгжилтийг баталгаажуулах /Итали/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.43, 108.44, 108.45, 108.84-өөс үзнэ үү.

**108.98. Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалалт хайж буй эмэгтэйчүүд, хүүхдүүдэд зориулсан хамгаалах байрыг илүү олноор байгуулахад анхаарах /Малайз/**

Хэрэгжих шатанд. НҮБ-ын Хүн амын сан, АХБ-ны санхүүжилтээр ХЗДХЯ-ны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дэд зөвлөлийн 2018-2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 7 аймаг, нийслэлд нийт 10 нэг цэгийн үйлчилгээний төвүүд нэмж байгуулахаар төлөвлөсөн байна. Хамгаалах байрыг нэмэгдүүлэх тал дээр шийдсэн төсөв хөрөнгө одоогоор байхгүй байна.<sup>47</sup>

**108.99. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хууль тогтоомжоо улам бэхжүүлэх /ОХУ/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.84-өөс үзнэ үү.

**108.100. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэх маш тодорхой эрх зүйн орчныг бүрдүүлэх, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод зориулсан нийгмийн хамгааллын тогтолцоог бий болгох /Серби/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.84-өөс үзнэ үү. Нийгмийн халамжийн тухай хуульд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдыг түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зохицуулалт тусгагдсан. Гэвч хохирогчид үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагууд нийгмийн халамжийн сангаас үйлчилгээний зардлаа олж авах процесс ихээхэн хүндрэлтэй бөгөөд хүнд суртал, шат дамжлагаас шалтгаалаад гарсан зардлаа ихэнхдээ авч чаддаггүй. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлдэг төрийн байгууллага, төрийн бус байгууллагаас илүү нөхцөл, хангамжтай. Тухайлбал, Улаанбаатар хотод ажилладаг Цагдаагийн байгууллагын дэргэдэх 30 ортой хамгаалах байранд 24 ажилтан ажиллаж, төсвөөс цалинждаг атал, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ-ын 20 ортой хамгаалах байранд 4 ажилтан ажиллаж байна. ТББ-ын ажилтнуудын цалин, хамгаалах байрны урсгал зардал, хоол хүнс болон хохирогчийн наад захын хэрэгцээнд зориулж төрөөс нэг ч төгрөгийн санхүүжилт олгодоггүй.

**108.101. Гэр бүлийн хүчирхийллийг эрүүгийн хэрэгт тооцох өөрчлөлтийг эрүүгийн хууль тогтоомждоо оруулах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэмт этгээдэд эрх бүхий байгууллагууд хариуцлага хүлээлгэн яллах нөхцөлийг хангах, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үзүүлж буй бүх төрлийн үйлчилгээнд хангалттай санхүүжилт олгох /Словак/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.84, 108.100-аас үзнэ үү.

**108.102. Гэр бүлийн хүчирхийллийг эрүүгийн хэрэгт тооцох өөрчлөлтийг эрүүгийн хууль тогтоомждоо оруулах /Испани/**

Хэрэгжсэн. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх нь шинэ Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцогдох болсон.<sup>48</sup>

**108.103. Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, гэр бүлийн хүчирхийллийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх сурталчилгааны ажлын цар хүрээг өсгөх, хохирогчдод үзүүлэх үйлчилгээ, хамгаалалтыг өргөжүүлэх /Канад/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.84, 108.88, 108.100-аас үзнэ үү.

**108.104. Гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн дарамтыг эрүүгийн хэрэгт тооцохыг анхаарах, гэмт этгээд хуулийн дагуу хариуцлага хүлээдэг болох нөхцөлийг хангах /Унгар/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.84-өөс үзнэ үү. Бэлгийн дарамтыг гэмт хэрэгт тооцоогүй.

**108.105. Гэр бүлийн хүрээнд учирдаг бүх төрлийн хүчирхийлэл, заналхийлэл, бэлгийн дарамт, мөлжлөг зэргийг оролцуулан гэр бүлийн хүчирхийллийг эрүүгийн хэрэгт тооцох хууль тогтоомж батлах, гэмт этгээдийг яллан шийтгэдэг, хохирогчид, тэр дундаа орон нутагт буй хохирогчид халамж авдаг болох нөхцөлийг хангах /Парагвай/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.84, 108.93-аас үзнэ үү.

**108.106. Эрүү шүүлтийн эсрэг хорооноос өгсөн зөвлөмжид нийцүүлэн хүүхдийн бие махбодын шийтгэлийг эрс хориглох /Чили/**

Хэрэгжсэн. 108.83-ыг үзнэ үү.

**108.107. Гэр бүл дэх шийтгэлийг оролцуулан хүүхдийн бие махбодын бүх шийтгэлийг эрс хориглох /Швед/**

Хэрэгжсэн. 108.83-ыг үзнэ үү.

**108.108. Хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийг мөлжлөгт автах, ялангуяа хөдөлмөрийн хортой нөхцөлд ажиллуулахаас хамгаалах үр нөлөө бүхий арга хэмжээг авах /Герман/**

Хэрэгжих шатанд. Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг Хөдөлмөрийн сайд 2016 онд шинэчлэн баталсан. Энэ жагсаалтад "жил бүрийн 11 сарын 1-ээс 5 сарын 1 хүртэл хугацаанд хурдан морины уралдаанд хүүхдээр морь унуулахыг хориглосон билээ. Гэвч уг тушаалын дээрх хэсэгт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд өөрчлөлт оруулан, хассан байсныг хууль зөрчиж, хүүхдийн эрх ашиг хөндлөө гэж үзэж, Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээ хүүхдийн эрхийг хамгаалах иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргаж шийдвэрлүүлэв. Шүүхийн анхан, давах, дээд шатны хурал бүрэн өвөл, хаврын хурдан морины уралдаан зохион байгуулах тухай МУЗГ-ын шийдвэрийг хууль зүйн үндэсгүй гэж дүгнэв. Засгийн газрын өргөн барьсан Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хүүхдийн сурч боловсрох эрхтэй нь уялдуулан хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарыг 15 нас болгон дээшлүүлэх, насанд хүрээгүй хүний хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах ажил олгогчийн хариуцлагыг өндөржүүлэх зэрэг саналыг тусгажээ. Уг төслийг УИХ хэлэлцэж эхлэхэд насанд хүрээгүй хүн тухайлбал 13 настай хүн хөдөлмөрийн гэрээ байгуулах боломжтой гэж хэлэлцэж маргалдаж байна. Хүүхэд хүнд хөдөлмөр эрхлэх, мөлжлөгийн шинжтэй харилцаанд орох зэрэг үзэгдэл албан бус салбарт өргөн байна. Жишээ нь өсвөр насны, ахлах ангийн сурагчид эцэг эх, асран хамгаалагчийн хамт



БНСУ-д очиж 2-3 сараар өдөрт 12 цагийн болон шөнийн ажил хөдөлмөр эрхлэх явдал гарч эхэлсэнд иргэд санаа зовж байна.

**108.109. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах 2012-2016 оны үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах, хөтөлбөр хэрэгжсэний дараах тогтолцоог судлан үзэх /Итали/**

Хэрэгжих шатанд. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг Монгол Улсын нэгдэн орсон ОУХБ-ын "Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр"-ийн тухай 182-р конвенцид нийцүүлэн Эрүүгийн хуульд тодорхойлж, хориглосон.<sup>49</sup> Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 93.8 -д "Хүүхдийн оюун ухаан, биеийн хөгжил, амь нас, эрүүл мэндэд аюул учруулах, хүмүүжил, ёс суртахуунд сөргөөр нөлөөлөх, хууль тогтоомжоор хориглосон хөдөлмөр эрхлүүлэх, хүүхдийн хөдөлмөрийг мөлжлөгийн хэлбэрээр ашиглах, цалин хөлсийг шударга бусаар тооцож олгох, хүүхдийн нэрээр хууль бус үйл ажиллагаа явуулах зэрэг тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрийг хүүхдээр эрхлүүлэхийг хориглоно" гэж томъёолсон байна.

**108.110. Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх ажлаа өргөжүүлэх, хүүхэд хөдөлмөрийн хортой, аюултай нөхцөлд, түүний дотор бичил уурхайд хөдөлмөр эрхлэхгүй байх нөхцөлийг хангах**

Хэрэгжээгүй. Зарим мэдээллийг 108.108-аас үзнэ үү. Швейцарийн хамтын ажиллагааны "тогтвортой бичил уурхай" төсөл, ОУХБ-ын хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар дэлхийн хөтөлбөр GАР-ын дэмжлэгээр Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 2016 онд албан бус уурхай дахь хүүхдийн хөдөлмөрийг хориглох, чиглэлээр орон нутгийн чадавхыг нэмэгдүүлэх сургалт, арга хэмжээ хэрэгжүүлжээ. Энэ арга хэмжээний хүрээнд бичил уурхайн орчим хүүхдийн хөдөлмөрийн нөхцөл байдлыг судалж, олборлолт явуулж буй 11 аймагт 8-18 насны 1,498 хүүхэд хөдөлмөр эрхэлж байгааг тогтоожээ. Хүүхдүүдийн 82 хувь нь 15-18 насныхан байв. Гэвч бичил, албан бус хэвшил дэх хүүхдийн хөдөлмөрийн эсрэг үр дүнтэй, тогтвортой үйл ажиллагааны талаар нэмэлт мэдээлэл олдоогүй. Хүүхэд хөдөлмөр эрхлэх, улмаар сургууль завсардах үзэгдлийн шалтгааныг судлах, хамтран таслан зогсоох зорилго, зорилтоо холбогдох салбар, байгууллага, албан тушаалтан мэдэхгүй байна. Хариуцлагын шинэ гэхээр хэлбэр бий болоогүй.

**108.111. Хүүхдийг хөдөлмөр эрхлүүлсэн ажил олгогчдод хариуцлага хүлээлгэх зэргээр хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх ажлаа үргэлжлүүлэх, гэр бүлд болон сургуульд хүүхдэд хүлээлгэх хүчирхийллийн бус сахилга батын шинэ хэлбэрүүдийг нэвтрүүлэх /Литва/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.108, 108.109, 108.110-аас үзнэ үү. Хөдөлмөрийн тухай хуулийн 109.5-д "Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт"-ыг Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн сайд гаргахаар заасан бөгөөд Хөдөлмөрийн сайдын 2016 оны 36-р тогтоолоор тус жагсаалтыг баталсан байна. Эрүүгийн хуулийн 16.10-т "Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх"-ийг гэмт хэрэгт тооцож, дээрх жагсаалтад дурдагдсан ажил эрхлүүлсэн бол ойролцоогоор 1,130-2260 ам.доллар, 240-720 цаг нийтэд түстэй ажил хийлгэх, 6 сараас 1 жил хүртэл зорчих эрхийг хязгаарлах, 6 сараас 1 жил хүртэл хорих ялаар шийтгэхээр заасан бөгөөд энэ нь тун хөнгөн ял шийтгэл оногдуулсан заалт юм. Хуучин Эрүүгийн хуулийн 121 дүгээр зүйлд "хүүхдийг албадан болон хүчээр хөдөлмөрлүүлсэн бол" ойролцоогоор 5,000 – 25,000 ам доллараар торгох, эсхүл 4 жил хүртэл хугацаагаар хорих ялтай байсан бол шинэ хуулиар ял шийтгэлийг хөнгөрүүлсэн.<sup>50</sup> Хуулийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл одоогоор байхгүй. Хүүхэд гар дээрээс наймаа хийх, садар самуунд уруу татагдаж, баар цэнгээний газар, караокед ажиллах, цахим сүлжээнд далд хэлбэрээр биеэ үнэлэх, хөдөө орон нутагт айлд мал маллах, гадаад улс, оронд очиж урт, богино хугацаагаар

ажил хөдөлмөр эрхлэх нь тулгамдсан асуудал хэвээр байна. Хүүхдийн эрхийн тухай хуулиар хүүхэд асран хамгаалах, сурган хүмүүжүүлэх, дэмжин туслах чиг үүрэг бүхий хүн бүр хүүхдэд хүмүүжлийн эерэг арга хэрэглэх, сургууль бүр хүүхэд хамгааллын бодлого, журмыг дагаж мөрдөх үүрэг хүлээсэн. Энэ хэм хэмжээг сахиулах, хяналт тавих үүрэг бүхий хүүхдийн эрхийн улсын байцаагч шинээр бий болж, хүүхдийн эрхийн зөрчлийн хэргийг прокурорын хяналт дор шалган шийдвэрлэж эхлээд байна.

#### **108.112. Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх стратегиудыг судлан тодорхойлох /Норвеги/**

Хэрэгжээгүй. Энэ асуудлаар хариу өгөх байр сууриа илэрхийлэх албан тушаалтан, байгууллага байхгүй байна. Хүүхэд гар дээрээс наймаа хийх, садар самуунд уруу татагдаж, баар цэнгээний газар, караокед ажиллах, цахим сүлжээнд далд хэлбэрээр биеэ үнэлэх, хөдөө орон нутагт айлд мал маллах, гадаад улс, оронд очиж үрт, богино хугацаагаар ажил хөдөлмөр эрхлэх нь тулгамдсан асуудал болж байгаа тул энэ зөвлөмжийг анхаарч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага байна.

#### **108.113. Хүүхдийн хөдөлмөрийг мөлжиж буй ажил олгогчдын үйлдлийг эрүүгийн хэрэгт тооцох, тэдэнд хариуцлага хүлээлгэх зэргээр хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх /Польш/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.111-ээс үзнэ үү.

#### **108.114. Хүүхдүүд бүх төрлийн хүчирхийлэл, мөлжлөгөөс, ялангуяа хөдөлмөрийн хортой нөхцөл дэх хүүхдийн хөдөлмөрийн хэлбэрээс хамгаалагдсан байх нөхцөлийг баталгаажуулах хүчин чармайлтаа үргэлжлүүлэх /БНСУ/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.83, 108.108-аас үзнэ үзнэ үү.

#### **108.115. Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хүчин чармайлтаа үргэлжлүүлэх /Морокко/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.24-өөс үзнэ үү.

#### **108.116. Хууль сахиулах байгууллагын хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, гэмт этгээдийг яллах чадавхыг бэхжүүлэх, хохирогчдод үзүүлэх үйлчилгээг өргөжүүлэх замаар Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах /Канад/**

Хэрэгжих шатанд. Цагдаагийн байгууллага 2015 онд 6, 2016 онд 3, 2017 онд 12 хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлж, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна. Хууль сахиулах байгууллага, шүүх эрх мэдлийн байгууллагын алба хаагчдыг мэргэшүүлэх хэрэгцээ шаардлага их байна. Учир нь хүн худалдаалах гэмт хэргийн шинэ төрөл, хэлбэрүүдийг танин мэдэх, бусад үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй хэрхэн холбогдож байгаа талаар ялангуяа хар тамхи, мөнгө угаах гэмт хэргийн хамаарлын талаар чадавхжуулах ажлыг шат дараатай авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх, сайжруулах шаардлагатай байна. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд ямар нэг тусгайлсан төсөв санхүүжилт байхгүй байна. Тус хуулийн 15-р зүйлд хохирогчийн мөнгөн болон мөнгөн бус хохиролд нөхөн олговор олгох тухай зааж, хохирлын хэмжээг шүүхээс тогтоохоор тусгасан. 2006 оны Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21-р зүйлд Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зохицуулалт байдаг бөгөөд 21.3-т хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогч, гэрчид нөхөн олговор олгох, энэ төрлийн гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, түүнчлэн хүнд гэмтэл учирсан хохирогчдод шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт заасан эмчилгээний зардал, оршуулгын зардал, хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг гаргуулах боломжтой байсан ч 2015 оны хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хасагдсан. Хохирогчид

туслалцаа үзүүлэх цогц үйл ажиллагаа өнөөг хүртэл байхгүй. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа зөвхөн Улаанбаатар хотод, зөвхөн төсөл хэрэгжүүлэх байдлаар буюу гал унтраах чиглэлээр ажилладаг. Үндэсний хэмжээнд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, хууль сахиулах байгууллага, прокурор, шүүх эрх мэдлийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах замаар хэргийн шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх, ял завших боломжийг олгохгүй байхад анхаарах шаардлагатай. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага (MNS 6343:2013)-ыг ХНХЯ, Стандартчилал, хэмжил зүйн газраас баталсан боловч хэрэгждэггүй.

**108.117. Хүн худалдаалахтай тэмцэх тухай 2012 оны хуулийг хэрэгжүүлж, гэмт этгээдийг мөрдөн шалгах, яллах ажиллагааны үр нөлөөтэй байдлыг хангах, хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх үүднээс хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагыг бэхжүүлэх /Бразил/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.116-аас үзнэ үү. Хууль сахиулах байгууллагын алба хаагчдыг мэргэшүүлэх сургалтыг төрийн бус болон олон улсын байгууллагын дэмжлэгтэй зохион байгуулж байна. Хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр яллах ажиллагааны үр нөлөөтэй байдлыг хангах чиглэлээр прокурор, шүүх эрх мэдлийн байгууллагыг мэргэшүүлэх ажил хийгдэхгүй байна. Түүнчлэн Цагдаагийн байгууллагад бүртгэгдэж буй гэмт хэрэг, шүүхээр шийдвэрлэгдэж буй хэргийн тоо байнгын зөрүүтэй байгаа нь шүүгч нарыг мэргэшүүлэх шаардлагатай байгааг харуулж байна. 2016, 2017 онд шүүхээр хүн худалдаалах 1 ч гэмт хэрэг шийдвэрлэгдээгүй байна.

**108.118. Хүн худалдаалахын эсрэг маш хатуу хууль батлах замаар хүүхдийг худалдаалах бүх хэлбэрийг эрүүгийн хэрэгт тооцох /Сиерра Леон/**

Хэрэгжих шатанд. Хүн худалдаалах гэмт хэргийг ЭХ-ийн 13.1 дүгээр зүйлээр шийдвэрлэхээр заасан ч бусад зүйлүүдэд, тухайлбал, 12.3 Бэлгийн мөлжлөг, 13.1 Хүн худалдаалах, 13.13 Албадан хөдөлмөрлүүлэх, 15.3 Хүний цус, эд эрхтнийг хууль бусаар авах, 16.4 Хүүхдээр гүйлгэ гүйлгэх, 16.6 Хүүхэд худалдах, 16.9 Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах, 16.10 Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх зэрэг хүний наймааны бусад хэлбэрүүдийг задалж оруулсан нь хуулийн шийдвэрлэлтийн нэгдмэл чанарт сөргөөр нөлөөлнө гэж үзэж байна. Тухайлбал, хохирогчийг 16 настайгаас нь эхлэн 14.7 жилийн түрш хүчээр биеийг нь үнэлүүлж байсан хэрэгт шүүхээс бэлгийн мөлжлөг гэж үзэн 3.6 жилийн ял оногдуулсан бөгөөд Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс ялыг зөв оногдуулсан гэж үзэж хэвээр баталсан.<sup>51</sup> Шинэ Эрүүгийн хуулийн 16.6-р зүйлд /Хүүхэд худалдах/ төрүүлсэн, үрчлэн авсан, асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа хүүхдээ бусдад худалдсан нь 13.1-р зүйлд заасан гэмт хэргийн шинжгүй бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй (4.150-16.700 ам.доллар) тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан. Энэ нь хүн худалдаалах гэмт хэргээс хэрхэн ялгагдах нь тодорхойгүй, өнөөг хүртэл энэ зүйл ангиар эрүүгийн хэрэг үүсгэгдээгүй, шүүхээр хэрэг шийдвэрлэгдээгүй байна.

**108.119. Хүн худалдаалах бүх хэрэгт шаардлагатай мөрдөн шалгах, яллах ажиллагаа явуулах замаар хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдийг худалдаалахтай тэмцэх арга хэмжээгээ өргөжүүлэх /Малайз/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.116, 108.117-оос үзнэ үү.

**108.120. Хүн худалдаалахтай тэмцэхэд шаардлагатай боловсон хүчний болон материаллаг бүх нөөцийг хуваарилан олгох /Гондурас/**

Хэрэгжих шатанд. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 6-р зүйлийн 6.1-т хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, мэргэжлийн удирдлагаар хангах, энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Дэд зөвлөл байна. Энэ нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэд ажиллахаар хуульчилсан бөгөөд энэ зөвлөлд хүн худалдаалахтай тэмцэх чиг үүргийг нэг мэргэжилтэн л хариуцаж байна. Үйл ажиллагаа нь зөвхөн хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах Үндэсний хөтөлбөрт хяналт тавих төдийгөөр хязгаарлагдаж байна. Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албанд “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасаг”-ийг 2015 онд 2 эрүүгийн төлөөлөгчтэй байхаар баталсан бол, 2017 онд 1 дарга, 4 эрүүгийн төлөөлөгчийн орон тоотойгоор баталсан. Гэвч үндэсний хэмжээний нэгдсэн бодлого, зохион байгуулалт, бүтэц, тогтолцоо өнөөг хүртэл бүрдэж чадаагүй, тусгайлсан төсөвгүй.

**108.121. Хүн худалдаалах хэргийн хохирогч, гэрч эрх зүйн туслалцаа, хамгаалалт, нөхөн сэргээх үйлчилгээ авах боломжоор баталгаатай хангагдах нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай төсвийн, захиргааны болон эрх зүйн арга хэмжээнүүдийг авах /Мексик/**

Хэрэгжих шатанд. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 16-р зүйлийн 16.3-т “...хөрөнгийг дараах үйл ажиллагаанд зарцуулна. Уг зардал хамгаалах байрны үйл ажиллагааг санхүүжүүлэх, эрдэм шинжилгээний байгууллагаар судалгаа хийлгэх, сургалт, сурталчилгаа явуулах, хүн худалдаалахын эсрэг үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагад дэмжлэг үзүүлэх” зэргийг хуульчилсан.<sup>52</sup> Гэтэл энэ хуулийн заалт өнөөг хүртэл хэрэгжээгүй. Өнөөг хүртэл хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх, нийгэмшүүлэх нийгмийн ажлын цогц үйлчилгээг төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын санхүүгийн дэмжлэгээр хэрэгжүүлж байна. Төрийн байгууллагаас хохирогчийг хамгаалах чиглэлээр тусгайлсан төсөв, санхүүжилт зарцуулдаггүй. Гэрч, хохирогчийг хамгаалдаг дагнасан төрийн байгууллага болох Тахарын ерөнхий газрыг татан буулгасан нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн хохирогч, гэрчийг хамгаалах ажилд үхралт болсон. Хохирогчид үйлчилгээ үзүүлэх байгууллагад ажилтнуудын зардал өгөх боломжгүй гэдэг.

**108.122. Хүн худалдаалахын эсрэг хөтөлбөрт шаардлагатай боловсон хүчний болон бусад нөөцийг хангалттай байдлаар үргэлжлүүлэн олгох /Филиппин/**

Хэрэгжих шатанд. 2017 оны Засгийн газрын тогтоолоор “Хүн худалдаалахтай тэмцэх тухай үндэсний хөтөлбөр”-ийг 4 жилийн хугацаатай баталсан. 2018 онд төс хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 709 сая төгрөг (300,000 орчим ам.доллар) баталснаас энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 8 ТББ-д 97 сая төгрөгийн санхүүжилт олгоно.<sup>53</sup> Зөвхөн энэ хүрээнд хэрэгжүүлэх ажил, үг ажлыг хариуцах байгууллагыг тодорхойлсон бодлогын баримт бичиг болсон. Улсын хэмжээнд тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах үндэсний зөвлөлийн дэргэдэх Урьдчилан сэргийлэх дэд зөвлөл хариуцаж байгаа бөгөөд төр, төрийн бус, олон улсын байгууллагын 25 төлөөлөлтэй, ХЗДХ-ийн Дэд сайд удирдаж, 2 НБД-тай ажиллаж байна. ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн газарт “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасаг”-ийг 2015 онд 2 эрүүгийн төлөөлөгчтэй байхаар баталсан бол, 2017 онд 1 дарга, 4 эрүүгийн төлөөлөгчтэй байхаар өргөтгөсөн бөгөөд орон нутагт салбаргүй. Тус албыг 2017 онд Зохион байгуулалттай гэмт бүлэг, хүн худалдаалахтай тэмцэх хэлтэс болгож, 23 орон тоотой болгосон.<sup>54</sup>

Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр Гадаад харилцааны яамнаас санаачлан зохион байгуулж байгаа “Хүн худалдаалах гэмт хэрэг, консулын асуудлаар” сэдэвт сургалт, холбогдох олон улсын гэрээ, протоколыг монгол хэл рүү хөрвүүлэх, улмаар “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтлэх, хоёр талт уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж байгаа нь чухал ач холбогдолтой.<sup>55</sup>

**108.123. Эрх зүйн шинэ орчин буюу Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд заасны дагуу хүн худалдаалах үйлдэлд ял оногдуулах, хууль сахиулах албан хаагчдын үйлдсэн хэргийг оролцуулан хүн худалдаалах хэрэг үйлдсэн байж болзошгүй бүх үйлдлийг мөрдөн шалгах, хохирогчдод нөхөн төлбөр олгох, нөхөн сэргээх зохицуулалтыг хэрэгжүүлэх зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй бүх талд зориулсан сургалт зохион байгуулах /Мексик/**

Хэрэгжээгүй. Зарим мэдээллийг 108.117-оос үзнэ үү. 2014-2017 онд статистик мэдээгээр хүн худалдаалах (ЭХ-ийн 113-р зүйл) 29 гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгдэн шалгагдсан. Харин мөн хугацаанд хүн худалдаалах (ЭХ-ийн 113-р зүйл) хэрэгт 3 хүн шүүхээр ял шийтгүүлсэн байна. Шинэ Эрүүгийн хуулийн 13.1-р зүйлд хүн худалдаалах гэмт хэргийн бүх хэлбэрийг тусгахын зэрэгцээ, 2-8 жилийн хорих ялтай, хүндрүүлсэн нөхцөлөөр хугацааг 2 дахин нэмэгдүүлэхээр зохицуулсан. Гэтэл мөн хуулийн 12.3-т бэлгийн мөлжлөг гэсэн зүйл оруулсан нь хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, хянан шалгах, шийдвэрлэхэд хүндрэл бий болгосон. Хуулийг хэрэгжүүлэгчдэд шинэ Эрүүгийн хуулийн 12.3, 13.1-ийг ялгах асуудлаар нэг мөр ойлголт өгөх зайлшгүй хэрэгцээ бий болсон. Учир нь Эрүүгийн хуулийн 12.3-р зүйл буюу бэлгийн мөлжлөгт дотоодод үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэргийг хамааруулан шийдвэрлэх ёстой гэсэн хандлага шүүгчдийн дунд түгээмэл байна. Энэ нь хүн худалдаалах гэмт хэргийг зөвхөн гадаад улсад үйлдэгддэг гэсэн ойлголтыг бий болгож байгаа юм. Хүйсийн тэгш эрхийн төвийн 2017 оны тоон мэдээллээс харахад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын 62 хувийг дотоодоо бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогчид эзэлж байна. Иймээс хуулийн хийдлийг арилгах шаардлага тулгарч байна.

**108.124. Шүүх эрх мэдлийн тогтолцоог Монгол Улсын олон улсын үүрэг амлалтад нийцүүлэн шинэчлэх ажлаа үргэлжлүүлэх /ОХУ/**

Хэрэгжих шатанд. Шүүх эрх мэдлийн тогтолцооны шинэчлэлийн хүрээнд 2012 онд багц хуулиудыг баталсан. Энэ хүрээнд шүүхийн төсвийг шүүд УИХ-д оруулж баталдаг болгож, шүүхийн төсөв, шүүгчийн цалинг нэмсэн. Төрөлжсөн шүүхүүд бий болж, мерит зарчимд суурилсан шүүгчийн сонгон шалгаруулалт, шүүхийн бие даасан захиргаа, шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг тодорхойлж, шүүхийн ачааллыг тэнцвэржүүлэх, шүүхийн шийдвэр ил тод болгоход чухал алхмыг хийсэн билээ. Гэсэн хэдий ч шүүхийн тогтолцоог тойргийн зохион байгуулалтад оруулахдаа хууль зүйн тогтолцоог бүхэлд нь авч үзээгүй, иргэдийн саналыг харгалзаагүйн улмаас Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр буцсан. Мөн шүүхийн захиргааны бие даасан хувилбарыг сонгосон нь ахиц байсан ч ШЕЗ-ийн гишүүдийг хэт цөөрүүлж, эрх мэдлийн тэнцвэр алдагдуулсан, шүүгчийн томилгоо тойрсон шүүмж өрнөсөөр байгаа зэрэг нь цаашид шинэчлэлийг гүнзгийрүүлэх хэрэгцээ байсаар байгааг харуулж байна.

**108.125. Бүх аймагт байгуулагдсан Хууль зүйн туслалцааны төвүүдийг шаардлагатай санхүүжилт, шалгуур хангасан боловсон хүчнээр хангах замаар эрх зүйн туслалцаа авах боломжийг нэмэгдүүлэх /Литва/**

Хэрэгжих шатанд. Хууль зүйн туслалцааны төвийн төсөв 2016 онд 846 сая, 2017 онд 891 сая, 2018 онд 907 сая төгрөгөөр баталж байснаас үзэхэд төсвийг бууруулаагүй байна. Улсын өмгөөлөгчийн тоог ачааллаас харгалзан нэмэх байр суурь баримталж байна.<sup>56</sup>

**108.126. Ял шийтгэлгүй үлдэх явдалтай тэмцэх, эрүүдэн шүүгдсэний улмаас хохирсон хохирогчид хангалттай хэмжээний нөхөн олговор болон нөхөн сэргээх үйлчилгээ авах нөхцөлийг хангах үүднээс эрүүдэн шүүсэн болон зүй бусаар харьцсан байж болзошгүй хэрэгт бие даасан, үр нөлөө бүхий мөрдөн шалгах ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх /Герман/**

Хэрэгжих шатанд. Мөрдөн шалгах тогтолцоотой холбоотой мэдээллийг 108.72-оос үзнэ үү.

**108.127. Бүх гэмт этгээдэд ял оногдуулах, хохирогчид цаг алдалгүй эрхээ сэргээлгэх, хамгаалалт авах нөхцөлийг бүрдүүлэх /Литва/**

Хэрэгжих шатанд. Шинэ Эрүүгийн хууль 2017.07.01-ээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Хохирлоо барагдуулах нь хөнгөн гэмт хэрэгт ялаас чөлөөлөгдөх, хүнд гэмт хэрэгт ялаа хөнгөрүүлэх нөхцөл болохоор хуульд туссан ч хуулийн хэрэгжилттэй холбоотой тодорхой мэдээлэл дутмаг байна. Хохирогч хамгаалах тогтолцоо болох Тахарын албыг 2013 онд байгуулж, 2016 онд татан буулгасан нь энэ чиглэлээр үхралт болсон.

**108.128. Насанд хүрээгүй хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх цогц тогтолцоог олон улсын стандартад нийцүүлэн бий болгох /Сиерра Леон/**

Хэрэгжих шатанд. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын 18-р бүлэгт өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг заасан. Тухайлбал 18.2.2-т "өсвөр насны шүүгдэгчтэй харилцахдаа түүний нэр төрийг хүндэтгэн харьцах, насны онцлогийг харгалзан хүмүүжих, алдаагаа засах боломжийг олгохыг анхаарч ажиллана гэжээ. Хүүхэд хамгааллын тухай хуулийн дагуу аймаг, дүүргийн түвшинд хүүхдийн эрхийн хууль зүйн хороо гэх шинэ бүтэц бий болж, гэр бүл, хүүхэд залуучуудын байгууллагын дэргэд ажиллах болов. Хууль зүйн хороо ажиллах бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг ХЗДХ, ХНХ-ийн сайд нар баталснаар хорооны бүрэлдэхүүнд мөрдөгч, прокурор, шүүгч, өмгөөлөгч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, хүүхэд гэр бүл, нийгмийн халамж эрүүл мэнд боловсрол, ТББ-уудын төлөөлөл хамтран ажиллаж гэмт хэргийн гэрч, хохирогч, сэжигтэн хүүхдийн эрхийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед болон уг ажиллагааны дараа нь хамгаалж ажиллах эрх зүйн орчин шинээр бүрдсэн. Шинэ болон шинэчлэгдсэн хуулиуд бүгд хэрэгжиж эхэлсэн 2017 оны 7 сарын 1-ээс 10 дугаар сард улсын хэмжээнд ЦЕГ-ын мэдээллээр насанд хүрээгүй хүн оролцсон нийт 231 хэрэг гарсны 55 хувь нь хөнгөн хэрэг байна. Тэдний 67,5 хувь нь хулгай, дээрэм, залилан, 18 хувь нь эрүүл мэнд, бусдын халдашгүй байдлын эсрэг шинжтэй хэрэг байна. Дээрх хугацаанд насанд хүрээгүй 199 сэжигтэн шалгагдаж, тэдний 73 хувь нь 16-17 насныхан байна. Хүүхдүүдийн 38 хувь бүлэглэж хэрэг өдүүлжээ. Энэ хугацаанд гэмт халдлагад өртсөн 691 хүүхдийн 38 хувь нь эмэгтэй, 8 хувь нь нас барсан, 26 хувь нь 8-13 насныхан байна. Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан насанд хүрээгүй 34 хүний ялыг дүйцүүлэн хасаж чөлөөлсөн гэж ШЕЗ-ийн гаргасан шүүн таслах ажиллагааны 2017 оны 3 дугаар улирлын тайланд тэмдэглэсэн байна. Мөн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн дагуу гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх үүргийг бүх шатны засаг дарга, ТББ үзүүлэхээр үүрэг хүлээсэн. Мөн ХЗДХЯ-аас энэ оны 7-р сард "Насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах стандарт"-ын төсөл боловсруулж стандартын байгууллагад хүргүүлсэн байна. Хүүхдийг эрүүдэн шүүх, ёс бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, насанд хүрээгүй хүний эрхийг хангах зорилгоор насанд хүрээгүй

хүнээс тайлбар, мэдүүлэг авах, таньж олох ажиллагаа явуулах 58 өрөөг үйл ажиллагаандаа ашиглаж байгааг ЦЕГ мэдээлж байна. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий алба хаагчид насанд хүрээгүй хүнийг эрүүдэн шүүх, зүй бус хандсан тохиолдлыг шалган шийдвэрлэх үүрэг бүхий Тусгай субъектийн хэргийг мөрдөх нэгж Мөрдөн байцаах албаны бүтцэд ажиллаж байна. Уг хэлтэст сүүлийн 2 жилд дээрх шалтгааны улмаас гарсан хэрэг, зөрчил бүртгэгдээгүй байна. Эрх зүйн орчны энэ удаагийн багц хуулиудын шинэчлэл насанд хүрээгүй хүний хэргийг хянан шийдвэрлэх тогтолцоог олон улсын стандартад нийцүүлж ойртуулахад дөхөм болохуйц суурийг тавилаа. Харин тэдгээрийг хэрэгжүүлэх, сурталчлах, хэрэглэх нөхцөл байдал анхаарал татсан хэвээр байна. Жишээ нь 2017 оны эцэс гэхэд хууль сахиулах, шүүх эрх мэдлийн салбарын ажилтны мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт насанд хүрээгүй хүний эрхийг хамгаалах тогтолцооны шинэчлэлийн сэдэв, агуулга бүрэн тусаагүй, түүнчлэн аймаг, дүүрэг шинээр ажиллаж эхэлсэн хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээний талаарх мэдээ, тоо баримт хангалтгүй байна. Мөн эцэг эх, асран хамгаалагч ялангуяа өсвөр үеийнхэн хуулийн дагуу өөрт нь зориулж бий болгосон давуу тал, боломжийг сонсоогүй, мэдэхгүй, ашиглахгүй байгаа нь харамсалтай.

**108.129. Иргэддээ тогтвортой хөгжил, тэгш байдлыг бүрдүүлэх үүднээс авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх арга хэмжээгээ үргэлжлүүлэн авах /Сингапур/**

Хэрэгжих шатанд. Авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр УИХ-аас Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр баталсан, ЗГ-аас Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Үйл ажиллагааны төлөвлөгөө баталсан зэрэг алхмуудыг авч хэрэгжүүлсэн. Эрүүгийн хуульд “Авлигын гэмт хэрэг” гэсэн тусдаа бүлэг оруулж, 22.5 дугаар зүйл буюу “Хахууль өгөх” гэмт хэрэгт хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд орж, хахууль өгч төрийн үйлчилгээ авснаа сайн дураар илчлэн ирсэн хүнийг ялаас чөлөөлж, төрийн үйлчилгээг хэвээр үлдээхээр тусгасан нь ахиц гаргах эрх зүйн зохицуулалт болсон. Гэсэн хэдий ч авлигаас үүдэлтэй нийгмийн сөрөг үзэгдэл бодитоор оршин байсаар байгаа тул энэ чиглэлээр эрчимтэй ажиллах шаардлага байсаар байна.

**108.130. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тогтолцоон дахь авлигын бүх хэргийг мөрдөн шалгах /Литва/**

Хэрэгжих шатанд. Зарим мэдээллийг 108.129-өөс үзнэ үү. Энэ асуудлаар бодитой мэдээлэл олж авч чадаагүй бөгөөд шинээр илэрч буй хэргүүд улс төрөөс хараат бусаар шийдэгдэж байгаа эсэх нь эргэлзээтэй. Монгол Улс өршөөлийн хуулийг ойр ойр гаргах замаар, энэ төрлийн хэрэг үйлдсэн этгээдэд ял завших, хууль бусаар олж авсан мөнгөө хууль ёсны болгох боломж олгосоор байгааг залруулах шаардлагатай.

**108.131. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй холбогдох үндэсний хууль тогтоомжийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад нийцүүлэх, Харилцаа, холбооны зохицуулах хорооны хараат бус байдлыг хангах /Швейцари/**

Хэрэгжээгүй. Глоб интернэшнл төвөөс дотоодын хууль тогтоомжид судалгаа хийж, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдад зориулсан Эрх зүйн гарын авлага боловсруулан УИХ, ХЗДХЯ-нд хүргүүлсэн болно. Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал бэлэн болсон байна. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 2-р сарын 20-ны өдрийн 47 дугаар тогтоолоор “Төрөөс мэдээлэл, харилцаа, холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого” баталсан бөгөөд уг бодлогын баримт бичгийн 3.2.1-д “Мэдээлэл харилцаа холбооны салбарын эрх зүйн актыг боловсронгуй болгож, Монгол Улсын хууль болон олон улсын гэрээнд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдүүлнэ” гэжээ. Гэсэн хэдий ч, Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ)-ны удирдлага, гишүүдийн томилгоог хараат бус

болгох тухай дурдаагүй байна. Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд олон нийтээс санал авахаар Засгийн газрын цахим хуудаст байршуулжээ.<sup>57</sup>

**108.132. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй холбогдох хууль тогтоомж, захиргааны шийдвэрийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактаар хүлээсэн Монгол Улсын үүрэгт бүрэн дүүрэн нийцүүлэх, нэр төр гутаахыг эрүүгийн гэмт хэрэгт тооцохгүй байх асуудлыг судлан үзэх /АНУ/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.131-ээс харна уу. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 1.4 дүгээр зүйлийн 4-р заалтын дагуу “Хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй” хэмээн заасан. Мөн хуулийн шинэчилсэн найруулгаас “нэр төр гутаах, гүтгэх, доромжлох”-той холбоотой заалтыг халж, Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэх болсон.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 11.2 дугаар зүйлд хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, нэр төр, алдар хүндийг нь гутаан доромжилсны улмаас хохирогч болсон иргэнийг хамгаалсан шинэ заалт орсон байна.

Глоб интернэшнл төвийн судалгаагаар 2016-2017 онд нэр төр гутаасантай холбоотой нийт 110 иргэний, эрүүгийн хэрэг шүүхээр шийдвэрлэгджээ. Үүнээс 14 нь эрүүгийн хэрэг байна. Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн эсрэг иргэний хэрэг 2016 онд 12, 2017 онд 12 шийдвэрлэсэн бол 2016 онд эрүүгийн нэг хэрэг байна. Харин сэтгүүлч, хэвлэл мэдээллийн эсрэг эрүүгийн хэрэг 2017 онд алга байгаа нь Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой гэх үндэслэлтэй.

Зөрчлийн тухай хуулийн “Гүтгэх” хэмээх 6.21 дүгээр зүйлээр “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх (2,000,000 төгрөг буюу 840 орчим ам.доллар) хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй (20,000,000 төгрөг буюу 8400 орчим ам.доллар) тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” хэмээн заажээ.

Практикт Зөрчлийн тухай хууль нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн эсрэг эдийн засгийн цензур болон ашиглагдах эрсдэл өндөр байна. Энэ зүйл заалттай холбоотой зөрчил маргааныг мөрдөн шалгах үүргийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар цагдаагийн ажилтанд ногдуулсан байна. Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн 2017 оны 7-р сарын 1-ээс 2018 оны 3-р сарын 20-ныг хүртэл цагдаагийн байгууллага 230 гомдол хүлээн авчээ.<sup>58</sup> Үүнээс сэтгүүлч, хэвлэлийн мэдээллийн эсрэг 95 гомдол байна. Цагдаагийн байгууллага нийт 49 иргэний гомдлыг барагдуулж, 98 сая төгрөгийн торгууль ногдуулжээ.

**108.133. Интернет орчинг оролцуулан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулах /Франц/**

Хэрэгжих шатанд. ХХЗХ-ны дүрэм журмыг ХЗДХЯ-ны нэгдсэн бүртгэлд албан ёсоор бүртгэх чиглэлээр нааштай алхам хийж байна. Өнөөгийн байдлаар өргөн нэвтрүүлгийн техникийн асуудлыг зохицуулсан таван журам нэгдсэн бүртгэлд оржээ.<sup>59</sup> Харин Засгийн газрын 2013 оны 1-р тогтоолоор баталсан “Цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн систем”-ийн тухай тогтоолыг хүчингүй болгоогүй. Мэдээ, мэдээллийн сайтад сэтгэгдэл бичсэн иргэдийн IP хаяг нийтэд ил байх, үгийн шүүлтүүр хэрэглэх тухай ХХЗХ-ны журам хэвээр байна.

**108.134. Интернетийн зохицуулалтын бүх хүрээнд хүний халдашгүй байх эрх болон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг оролцуулан хүний эрхэд бүрэн хүндэтгэлтэй хандах, тэдгээр**



**эрхийг аливаа байдлаар хязгаарлахдаа “хуульд нийцсэн байх”, “зайлшгүй байх” болон “proportionality” байх зарчмыг баримтлах /Герман/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.131, 108.132-оос харна уу.

**108.135. Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд болон иргэний нийгмийн зүтгэлтнүүд шийтгүүлнэ гэх аливаа айдасгүйгээр өөрсдийн үйл ажиллагаагаа чөлөөтэй эрхлэх бололцоог олон улсын стандартын дагуу хангах /Эстони/**

Хэрэгжих шатанд. Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнууд, иргэний нийгмийн зүтгэлтнүүдийг хамгаалсан тусгайлсан хууль эрх зүйн орчин шинээр бий болоогүй хэвээр байгаа. Хүний эрхийг хамгаалагчдын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг ХЭҮК, иргэний нийгмийн байгууллагын оролцоотой боловсруулж, УИХ-д өргөн бариулахаар зарим гишүүд санаачлан ажиллаж байна. Мөн эрх зүйн болон төрийн бодлогод зарим нааштай алхам хийгдсэн.

Эрүүгийн хуулийн “Мэдээлэл хайх, хүлээн авахад саад учруулах” хэмээх 14.2 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах иргэний эрхийг хэрэгжүүлэхэд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж саад учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ” гэжээ.

УИХ-аас 2016 оны 11-р сарын 3-ний өдөр баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.8.2-т “Эрэн сурвалжлах замаар авлига, албан тушаалын гэмт хэргийн талаар мэдээлсэн сэтгүүлчийг аливаа дарамт, шахалтаас хамгаалах эрх зүйн зохицуулалт бий болгох, сэтгүүлчийг мэргэжлийн үйл ажиллагааных нь улмаас эрүүгийн хариуцлагад татах явдлыг өөрчилж, аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг бий болгох”-оор заажээ. Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2017 оны 4-р сарын 12-ны Засгийн газрын 114 тоот тогтоолоор баталсан.

**108.136. Нэр төр гутаах үйлдлийг эрүүгийн гэмт хэрэгт тооцохгүй байх, төрийн болон орон нутгийн эрх бүхий байгууллагын үйл ажиллагааг сурвалжилсан, эсхүл шүүмжилсний үлмаас мөрдөн хавчигдах, эсхүл дарамт шахалтанд орохгүй байхаас хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх /Чех/**

Хэрэгжээгүй. Нэр төр гутаахтай холбоотой мэдээллийг 108.132-оос үзнэ үү. 2017-2018 онд Глоб интернэшл төв нь “UPR-ийн зөвлөмж хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний хүрээнд ЮНЕСКО-гийн Үндэсний Комисстой хамтран сэтгүүл зүй, эрэн сурвалжлах сэтгүүл зүй, сэтгүүлчдийн мэргэжлийн эрх, аюулгүй байдлын чиглэлээр шүүгч, прокурорын ажилтнуудын чадавх бэхжүүлэх сургалт хийхээр ШЕЗ, УПЕГ, МХХ-той Санамж бичиг байгуулж, 2018 оны 4-р сард Сургагч багш нарын сургалт зохион байгуулсан. Глоб интернэшл төвийн Хэвлэлийн эрх чөлөөний тайланд 2017 онд сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийн нийт 182 зөрчил гарсан тухай дурджээ. Үүний 61 хувь нь шүүх, хууль сахиулах байгууллагын дарамт, 14 хувь мэдээлэл өгөхөөс татгалзсан, 11 хувь нь сүрдүүлсэн, заналхийлсэн, 6 хувь нь нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан, 4 хувь нь цензур, 4 хувь нь ажлын багаж хэрэгсэлд нь халдсан тохиолдол бүртгэгджээ.

**108.137. Нэр төр гутаах үйлдлийг эрүүгийн гэмт хэргээс хасах, олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэн иргэний журмаар шийдвэрлэх /Ирланд/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.132-оос үзнэ үү.

**108.138. Эрүүгийн хуулийн гүтгэлэг, доромжлолтой холбоотой зүйл заалтыг шүүмжлэлийг таслан зогсоох зорилгоор ашиглахгүй байх, сэтгүүлчдийн мэдээллийн эх сурвалж болон “шүгэлдэгч”-ийг хамгаалах /Австри/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.132, 108.135-аас үзнэ үү. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.5.6-д “Мэдээлэл өгч байгаа иргэн сэтгүүлчийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх”-ээр заасан.

**108.139. Эмэгтэйчүүдийн оролцоог улс төрийн шийдвэр гаргах түвшинд бэхжүүлэх зорилго бүхий үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх /Серби/**

Хэрэгжээгүй. Уг зорилго бүхий бие даасан хөтөлбөр байхгүй

**108.140. Эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах ажиллагаанд оролцуулах, өндөр түвшний албан тушаал эрхлүүлэх чиглэлээрх хүчин чармайлтаа бэхжүүлэх, боловсролын болон хөдөлмөрийн салбарт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулах нөхцөлийг хангах /Норвеги/**

Хэрэгжээгүй. Бодит нөхцөлд эмэгтэйчүүд сонгуульд нэр дэвших нь хүндрэлтэй хэвээр байна. Мөн энэ чиглэлийн хууль, хөтөлбөр, бүтэц, хүний нөөц, үйл ажиллагаа нь үр дүн муутай. Тухайлбал, жендэрийн тэгш байдлыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй орон нутгийн төрийн байгууллагын хандлага, хүний нөөц мэдлэг, чадвар, чадавхгүй байна. Үндэсний хэмжээнд болон орон нутагт улс төрийн намууд квотынхоо дагуу жендэрийн эрх тэгш байдлыг хангаж сонгуульд оролцдоггүй. УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн дараа шинээр байгуулсан Засгийн газрын сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга, агентлаг, салбар нэгжийн даргын албан тушаалын дийлэнх олонх эрэгтэйчүүд байгаа төдийгүй орон нутгийн төлөөлөгчдийн дунд эзлэх хувь хэмжээ нь эмэгтэйчүүдэд огт ээлгүй байсаар байна. Боловсролын салбарт тэгш хамруулах үзэл санаанаас илүүтэйгээр тусгаарлах байдлаар буюу тусгай боловсрол олгох нь чухал гэсэн хандлага, эмнэлгийн загвараар ХБХ-ийг хардаг стереотип бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, сургуулийн удирдлагын түвшинд хэвээр байсаар байна.

**108.141. Шийдвэр гаргах түвшний албан тушаал эрхлэх эмэгтэйчүүдийн төлөөллийг өсгөн нэмэгдүүлэх чиглэлээрх хүчин чармайлтаа эрчимжүүлэх /Рванда/**

Хэрэгжээгүй. Холбогдох мэдээллийг 108.140-өөс үзнэ үү.

**108.142. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог баталгаажуулахад чиглэсэн квотын шаардлага зэрэг түр тусгай хэмжээг авах /Коста Рика/**

Хэрэгжээгүй. Холбогдох мэдээллийг 108.140-өөс үзнэ үү.

**108.143. Нийт хүн ам, ялангуяа нийгмийн эмзэг бүлгийн амьдралын чанарыг сайжруулах амжилттай нийгмийн хөтөлбөрүүдээ цаашид улам бэхжүүлэх /Венесуэл/**

Хэрэгжээгүй. Нийгмийн эмзэг бүлэгт хэрэгжүүлж байгаа нийгмийн хөтөлбөрүүд нь амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглээгүй, бодит эзэндээ хүрэхгүй байх нь түгээмэл байна. Үүнийг халамж хүртэгсдийн 60 хувь нь эзнээ олоогүй гэсэн Дэлхийн банкны судалгаа нотлон харуулж байна.<sup>60</sup>

Засгийн газрын дунд хугацааны тайлангаас харахад “Өрхийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн үнэлгээ хийсэн эсэх нь тодорхой бус байгаа бөгөөд тоон мэдээнээс дүгнэхэд хүний эрхэд суурилсан хандлагаар үнэлсэн гэж харагдахгүй байна. Үнэлгээ хийсний үндсэн дээр 2016 оны 1-р сард “Үнэлгээний аргачлал”-ыг шинэчлэн баталжээ. Хэрэгжилтийг жил бүр үнэлж

тайлагнахаар тусгасан ч тайлан нь нээлттэй биш байна. Хэрэв хэрэгжилтийн тайлан гарахгүй байгаа бол хөтөлбөр хэрэгжиж эхлээгүй гэж үзэхээр байна. Ядуурлыг тогтоох “Орлогыг орлуулан тооцох” аргачлалыг олон нийтээр хэлэлцүүлсэн эсэх, судалгааг жил бүр хөндлөнгийн хараат бус этгээдээр үнэлүүлсэн тухай мэдээлэл байхгүй байна. Зөвхөн орлогыг орлуулан тооцох аргачлалаар амьжиргааны түвшинг тогтоосон байна. Нэгдсэн сан байгуулсан ч эдгээр нь хэр үр нөлөөтэй, хэр хэмжээний зардлаар, ямар хугацаанд хийсэн, одоо хаана хэрхэн ашиглаж байгаа, нээлттэй эсэх талаар мэдээлэл огт байхгүй байна.

Хөдөлмөрийн гэрээ нь албан бус хөдөлмөрийн салбарт ялангуяа, нийтийн хоолны салбар, худалдаа үйлчилгээ, газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг байгууллагад ихэнхдээ хэрэгжихгүй байна. Нэг цагийн хөдөлмөрийн үнэлгээг салбар тус бүрээр ялгавартай тогтоож байгаа ч бүх салбарыг хамруулаагүй. Нэг цагийн хөлс бага байгаагаас гэр бүлийн 2 хүн өдрийн арван цаг ажиллаад ч амьдралын чанар дээрдэхгүй байна. Мөн тухайн салбар дотроо гадаад, дотоод ажилтан, эрэгтэй эмэгтэй ажилтны ижил албан тушаалд нэг цагийн хөлсний үнэлгээ ялгаатай хэвээр байна. Энэ нь ОУ-ын Хөдөлмөрийн байгууллагын 100, 122-р конвенцийг зөрчиж байна. ЗГ энэ бүх асуудалд өөрийн санаачилгаар бус ҮЭ болон зарим нэг ТББ-уудын шахалтаар ажиллаж байна. Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд МХЕГ тогтмол хяналт тавихгүй, хүртээмжтэй бус, хяналт тавьсан ч тайлан нь ил тод биш, шалгалтын мөрөөр арга хэмжээ авахгүй байна. Мөн ЗГ-ын дэргэдэх Хөдөлмөр нийгмийн зөвшлийн үндэсний хороо түүний орон нутгийн салбар хороодууд тогтмол үр дүнтэй ажиллах санхүү, арга зүйн дэмжлэггүй байна.

Гэр хорооллын үндны усны хангамж, ариутгах татуурга шинээр бий болгох ажил хийгдэхгүй байна. Гэр хороолол, орон сууцны иргэдийн үндны усны хэрэглээ, хүртээмж, үнэ хэт их зөрүүтэй, ариун цэврийн нөхцөл ч ихээхэн ялгаатай, шударга бус байна.

Засгийн газрын 2016 оны 16 дугаар тогтоолоор баталсан “Өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр” нь 2016-2020 онд хэрэгжих бөгөөд ядуу хэсгийн 25 хувийг хамруулахаар заасан ч хэрэгжилт хангалтгүй байна. Өрхийн судалгаа хийгдэж, 28,470 хүн хамарсан ч үүнийг тогтоосон арга буруугаас хамрах хүмүүс орхигдсон гэсэн шүүмжлэл байна. Тиймээс аргачлалыг өөрчлөх шаардлагатай.

**108.144. Хотын төвүүдэд нийгмийн хамгийн эмзэг бүлгийн хүмүүс, түүний дотор орон нутгаас шилжин ирсэн хүмүүс нийтийн суурь үйлчилгээ авах боломжтой байх нөхцөлийг хангах замаар хотын төвүүдэд тогтвортой хөгжлийг бий болгоход чиглэсэн шаардлагатай арга хэмжээнүүдийг авах /Испани/**

Хэрэгжээгүй. Засгийн газрын тогтоолоор орон нутгаас нийслэлд ирэх шилжилт хөдөлгөөнийг зогсоосон нь хүний эрхийн зөрчлийг, ялангуяа эмзэг бүлгийн иргэдийн эрхийн зөрчлийг улам далд хэлбэрт орууллаа. Алслагдсан дүүрэг, хороо, Цагаандаваа зэрэг хогийн цэг дээр төрийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, хаана ч бүртгэл, харьяалалгүй "хэн ч биш" болсон иргэд амьдарч байна.<sup>61</sup> Уул уурхайн салбарт өртөж буй иргэдээ хамгаалах төрийн цогц бодлого байхгүй, энэ чиглэлээр гарсан зарим хууль тогтоомж нь хэрэгждэггүй, байгаль орчинд учруулсан хохирлыг арилгах, нөхөн сэргээх чиглэлээр хариуцлагын сул тогтолцоотойн улмаас нутаг дэвсгэрийн ихэнх хэсэг хуурайшилт, цөлжилт, хөрс усны доройтолд өртөж, бэлчээрийн даац муудсан зэрэг биомассын өгөөж буурсан нь шилжилт хөдөлгөөний гол хүчин зүйл болж байна. Хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг арилгаж чадахгүй ч, зөрүүг бууруулах үр нөлөөтэй арга хэмжээ авахгүй, улсын төсвөөс энэ чиглэлд хөрөнгө мөнгө гаргахгүй, зөвхөн ОУ-ын зээл тусламжийн хүрээнд л ажил хийгдэж байна. Шилжин ирэгсдийн хувьд өөр орчинд дасан зохицох, амьжиргааны наад захын нөхцөлөө бүрдүүлэхэд нь туслах, боловсрол, эрүүл мэндийн

үйлчилгээнд хамруулах зэрэг нийгэм, эдийн засгийн чиглэлээр тэдэнд зориулсан ямар нэгэн төлөвлөгөө, зохион байгуулалтын ажил хийгдэхгүй байна. Шилжин суурьшигсдад ээлтэй бодлогын баримт бичиг байхгүй байна. Шилжин суурьшигсад хаягийн бүртгэл хийлгээгүйгээс эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байх, хүүхдээ сургууль, цэцэрлэгт хамруулахгүй байх, ажил хөдөлмөр хийх үедээ эрх нь зөрчигдөх, оюутны дотуур байр, түрээсийн байр, хамаатан садныхаа гэрт амьдрах үедээ хүчирхийлэл, дарамтад өртөхийн зэрэгцээ соёлын ялгаатай байдлаас шалтгаалж хүүхэд, залуучууд үе тэнгийнхний ялгаварлан гадуурхалтад өртөж байна. Хот суурин газраас хөдөө орон нутагт шилжих тохиолдолд урамшууллын бодлого байхгүй. Уул уурхайг дагасан шилжилт хөдөлгөөний бодлогогүйн улмаас хүн амын механик өсөлтөд зохицсон боловсрол, эрүүл мэнд, нийгмийн бодлогод зарцуулах уян хатан төсвийн хуваарилалт хийдэггүй тул орон нутгийн төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулж байна.

Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбооноос 2017 онд хийсэн “Хогийн цэг дээр ажиллагсдын ажлын байрны аюулгүй орчны нөхцөл байдал” судалгаагаар хогийн цэг дээр хог ангилан амьдарч байгаа иргэдийн 90% эмзэг ядуу, тэдний 60 гаруй хувь нь нийгмийн халамж, тэтгэмжид хамрагдаагүй, өрхийн амьжиргааны судалгаанд ороогүй, хүүхдийн мөнгөө авч чадаагүй байна. Гүнж төвөөс 2017 онд хийсэн судалгаанаас үзэхэд нийслэлд шилжин суурьшигсдын 60 хувь нь эрүүл мэндийн үйлчилгээ авч чадахгүй байна. Тэдний 70 хувь нь УБ хотыг шилжин ирсэн охид, эмэгтэйчүүдэд ээлгүй, аюултай хот гэж үзжээ.

**108.145. Эрүүл мэндийн суурь үйлчилгээг үндэсний болон бүсийн хэмжээнд үзүүлэх тогтолцоог бэхжүүлэх, үйлчилгээний хамрах хүрээ болон хүртээмжийг өсгөн нэмэгдүүлэх, эрүүл мэндийн тогтолцоонд буй хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэхэд анхаарал хандуулах /Бутан/**

Хэрэгжээгүй. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж орон зайнаас үл хамааран хүртээмжгүй байна. 1. Эрүүл мэндийн суурь үйлчилгээг үндэсний болон бүсийн хэмжээнд бэхжүүлэх талаар суурь судалгаа хийсэн ч энэ нь зөвхөн үйлчилгээ үзүүлэх ЭМ-ийн байгууллагын боловсон хүчний хүртээмжийн талаар л судлагдсан байна. Харин судалгааны дүнд үндэслэсэн ажлын төлөвлөгөө гаргаж ажил хэрэг болгож хэрэгжүүлсэн мэдээлэл ЗГ-ын тайланд мэдээлэл байхгүй байна. Иймд асуудал, алдаа дутагдал хэвээр байна. Зөвхөн хүний нөөцийн судалгаа л хийсэн. 2. Иргэдэд, ялангуяа эрх мэдэл багатай бүлэгт хамгийн ойр үйлчилгээ үзүүлдэг Өрхийн эмнэлгийн ачаалал их, хүний нөөц хүрэлцээгүй. Өрхийн эмнэлэг нь ЗГ-ын 20 гаруй хөтөлбөрийн хэрэгжилт гаргадаг тул бичиг цаасны ажил их, тоног төхөөрөмж дутагдалтай, ихэвчлэн зориулалтын бус байранд үйлчилгээ үзүүлж байна. Өрхийн эмнэлэг шилжин суурьшиж байгаа хүмүүс, явуулын хүмүүст үйлчилгээ үзүүлсний зардлаа авч чаддаггүй тул, тухайн эмнэлгийн төсөв үргэлж дутагдалтай байдаг. 3. Бүсийн эмнэлэг, оношилгооны төвийн тоног төхөөрөмж хэтэрхий хуучирсан тухайлбал, Ховд аймгийн хувьд ариутгалын тоног төхөөрөмж хуучирсан шинэчлэгдээгүйгээс эмнэлгийн орчноос халдварт өвчин тархах эрсдэлийг нэмэгдүүлж байна.<sup>62</sup> 4. Эрүүл мэндийн суурь үзүүлэлттэй холбоотой 5 хүртэлх насны хүүхдийн тураал, хоол тэжээлийн мэдээлэл, жирэмсэн болон хөхүүл эхийн цус багадалтын мэдээлэл ил тод нээлттэй биш. 5. Хөдөө орон нутагт эрүүл мэндийн байгууллага эмийн эргэлтийн төсөвгүйгээс наад захын эмийн үйлчилгээ тогтмол тасалддаг бол тусгай зөвшөөрөлгүй, мэргэжлийн бус хүн хувиараа гар дээрээс эм зарж байгаа нь дэлгүүрээс талх худалдан авахтай адил байгаа нь эрсдэл дагуулахаар байна.

**108.146. Эмэгтэйчүүд, хүүхдүүдийн эрхийг хөхиүлэн дэмжих хүчин чармайлтаа үргэлжлүүлэх, одоог хүртэл өндөр түвшинд байгаа эхийн эндэгдлийг бууруулах чиглэлээр ажиллах /Непал/**

Хэрэгжих шатанд. Эхийн эндэгдэл 2016 онд 32, 2017 онд 15 гарч буурах хандлага байна. Холбогдох мэргэжилтнүүдийн оролцоотой 2016 оны эхийн эндэгдлийн бүх тохиолдолд дүн шинжилгээ хийж, зөвлөмж гаргах, “Эх яагаад эндэв 2012-2015” судалгааг тус тус хийжээ. Эх барих, эмэгтэйчүүдийн эмчийг гадаад, дотоодод сургах, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, эхийн эндэгдлийн зонхилох шалтгааны нэг болох эх барихын үжил, халдвараар нийслэлийн эмнэлгүүдэд үнэлгээ хийх ажлыг гүйцэтгэжээ. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн үндэсний хөтөлбөр”, эх баригчдын ажлын байрны тодорхойлолт шинэчлэх ажлыг хийсэн байна. 2025 он хүртэл хэрэгжих “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого” (2016)-доо өсвөр насны охидыг хүсээгүй жирэмслэлт, эрт төрөлтөөс сэргийлэх зорилт дэвшүүлсэн. Мөн “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр (2017)-т өсвөр насны охидын төрөлтийг 2020 он гэхэд 1000 амьд төрөлтөд 30 болгох зорилт дэвшүүлжээ. Өсвөр насны охидыг хүсээгүй жирэмслэлтээс урьдчилан сэргийлж, охидын төрөлтийг бууруулах асуудлыг төрийн бодлогын түвшинд авч үзэж байгаа нь нэн сайшаалтай. Гэвч охидын төрөлт буурах хандлага ажиглагдахгүй байгаа нь харамсалтай. 2016 онд нийт 79.9 мянган хүүхэд мэндэлснээс 4.8% нь 15-19 насны охидоос төржээ. Өмнөх 2015 онтой харьцуулахад өсвөр насны охидын төрөлт 244 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна. Охидын төрөлтийг 15-19 насны эмэгтэй хүн амын тоотой харьцуулахад 3.3% нь хүүхэд төрүүлж байна. Улаанбаатар хотын өсвөр үеийнхний нөхцөл байдлын судалгаанд хамрагдсан хүүхдүүд (549 хүүхэд)-ийн 12.4% нь охидын төрөлтийг өсвөр насны хүүхдүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тулгамдсан асуудлуудын нэг хэмээн үзсэн нь анхаарал татаж байна.

#### **108.147. Эхийн эндэгдлийг бууруулах чиглэлээрх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх /БНАСУ/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.146-аас үзнэ үү.

#### **108.148. Эхийн эндэгдлийн хувь хэмжээг, ялангуяа орон нутагт улам бууруулахад чиглэсэн практик алхмаа үргэлжлүүлэх /Сингапур/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.146-аас үзнэ үү.

#### **108.149. Орон нутаг болон хот суурин газар дахь хүүхдийн эндэгдлийн хувь хэмжээний зөрүүг бууруулах чиглэлээр хүчин чармайлт гарган ажиллах /Гондурас/**

Хэрэгжих шатанд. ЭМЯ-ны Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс гаргасан эрүүл мэндийн үзүүлэлтийн 2016 оны тайланд нялхсын эндэгдэл 1000 амьд төрөлтөд 2,5; үүнээс хөдөө орон нутагт 2,3; нийслэлд 2,6; 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн улсын дундаж 20,8. Эдгээр үзүүлэлтүүд 2012 оноос хойш жил бүр 0,2-3,5 пунктээр өссөн байна. Хот хөдөөгийн зөрүү нь сүүлийн 2 жилд 0.2-3,8 пункт байна. Эх нярайн тусламжийн зайн оношилгооны төсөл хэрэгжүүлж, эх барих, хүүхдийн тусламж, үйлчилгээний тулгамдсан асуудлаар шуурхай цахим хурлыг аймаг бүрээр зохион байгуулж, мэргэжил аргагүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор томуу, томуу төст өвчнөөр өвдсөн 5 хүртэлх насны хүүхдээ эмнэлэгт, эсвэл гэрээрээ асарч байгаа ажил, хөдөлмөр эрхэлдэг эх, эцэг, асран хамгаалагчид 3 хүртэлх хоногийн цалинтай чөлөө олгох асуудлыг шийдвэрлүүлсэн. Сурфактант эмчилгээний зааврыг 2017 оны А/102 дугаар тушаалаар батлуулж, санхүүжилтийг жил бүрийн төсөвтөө суулгаж, хэрэгжилтэд анхаарч ажиллахыг эмнэлгүүдэд үүрэг болгожээ. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 1-р тогтоолоор 5 хүртэлх насны хүүхдийн 10 нэрийн 30 төрлийн эмийг эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувь хөнгөлөлттэй үнээр олгох шийдвэр гаргаж, 29,440 хүүхдэд 457 сая төгрөгийн эмийг олгожээ.

Эх, хүүхдийн эндэгдэл өндөртэй аймгуудад туршлагатай эмчийг солилцуулан ажиллуулж, ажлын байрны сургалт зохион байгуулсан. Иргэдэд “Хүсээгүй жирэмслэлтээс урьдчилан

сэргийлэх”, “Гэр бүл төлөвлөлт”, “Жирэмсний аюултай шинж”, “Жирэмсний хяналтын ач холбогдол”, “Жирэмсэн эмэгтэйд зонхилон тохиолддог эмгэгүүд” олон нийтийн сүлжээг ашиглан мэдээлэл сурталчилгаа хийжээ. ЭМЯ, НҮБ-ын Хүн амын сангаас хэрэгжүүлж буй “Эх, нярайн тусламжид зайн оношилгооны төсөл”-ийн санхүүжилтээр эх, нярайн тусламжид шаардлагатай 1,2 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн байна.

**108.150. “Нэг Монгол” нээлттэй боловсролын үндэсний хөтөлбөрөө сайжруулан ажиллах /Латви/**

Хэрэгжээгүй. Засгийн газрын 2014 оны 105 дугаар тогтоолоор батлагдсан нээлттэй боловсролын "НЭГ МОНГОЛ" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар мэдээлэл байхгүй байна.

**108.151. Хүүхэд бүр сурч боловсрох эрхээ эдлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн хүчин чармайлтаа үргэлжлүүлэх /Румын/**

Хэрэгжих шатанд. Сургууль дахь хүчирхийллийг бууруулах, урьдчилан сэргийлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох хүрээнд “Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх”, “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах” журам, “Боловсролын байгууллагад мөрдөх хүүхэд хамгааллын бодлого”-ын төслүүдийг тус тус боловсруулан, “ЕБС-ийн дотуур байрын орчны стандарт” гаргасан. Өсвөр үеийнхэнд учирч буй цахим гадуурхал, дарамтын шалтгаан, орчин нөхцөлийг тодорхойлох судалгаа хийсэн байна. Нийслэлийн хэмжээнд 3 ээлжээр хичээллэдэг ерөнхий боловсролын 20 сургууль байна. Улсын хэмжээнд 2018 онд 55 сургууль, 38 сургуулийн өргөтгөл нийт 93 сургуулийг барихаар төлөвлөж байна.

Манай улсын сургуулиуд гол төлөв 1960-1980 онд баригдсан тул хуучирч, одоогийн стандартыг тэр бүр хангахгүй сургалтын болон дотуур байртай. Гэтэл хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөн, суурьшлын бүсийг тооцоолж, боловсролын байгууллагыг шинээр байгуулахгүй байна. Сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллыг баталгаажуулах үүднээс холбогдох хууль тогтоомжийн дагуу дүрэм журмыг яамдын түвшинд боловсруулсан ч анхан, дунд шатанд зохицуулалтын талаар үүрэг хүлээгч багш, нийгмийн ажилтан, сургуулийн менежер, захирал мэдэхгүй, хэрхэн дагаж мөрдөх талаар сургалт хийгээгүй, зарим тохиолдолд гагцхүү нийгмийн ажилтны үүрэг мэт сөрөг хандлага түгээмэл гарч байгааг Бүх нийт боловсролын төлөө үндэсний эвслийн 2018 онд хийсэн кейс судалгаанд дурджээ. НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр 2017 онд улсын цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн ус, ариун цэврийн байгууламжийн өнөөгийн байдлыг тодорхойлсон судалгаагаар төрийн өмчийн 639, төрийн бус өмчийн 131 сургуулиас 54 хувь нь төвийн шугамд холбогдсон байна. Үндэсний хэмжээнд нийт сургуулийн 11 хувь нь найдвартай ундны эх үүсвэр ашиглахгүй байна. Төвийн шугамд холбогдоогүй 138 сургууль усаа багадаа хагас цаг зарцуулан зөөж, уламжлалт нүхэн жорлон ашиглаж байна. Орон нутгийн нийт сургуулийн тал нь төвийн шугамд холбогдоогүй, худгаас усаа зөөдөг төдийгүй MNS5924:2015 стандартын дагуу жорлонг 15-20 метр зайд байгуулах ёстой ч 151 сургуульд 70 дээш метрийн зайд жорлонтой байна. Үүнээс шалтгаалан хүүхэд даарах, осгох, халдлагад өртөх эрсдэл нэмэгдэж байна.

**108.152. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангаж, хамгаалах, ялангуяа тэдний оролцоог хангах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, сурч боловсрох эрхийн хэрэгжилтийг өргөжүүлэх Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай хуулийн төслийг эцэслэн батлах хүчин чармайлтаа хоёр дахин нэмэгдүүлэх /Индонез/**

Хэрэгжих шатанд. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай хуулийг баталсан нь сайшаалтай зүйл болсон. Гэвч хууль батлаад 27 сар өнгөрч байгаа ч хэрэгжилтийг хангах чиглэлээр дагалдан гарах тогтоол, дүрэм журам нэгээс бусад нь гараагүй нь хүчин чармайлт хангалтгүй байгааг харуулж байна. Бодит амьдралд хууль хараахан хэрэгжиж эхлээгүй, хүлээлтийн байдалд байна. Холбогдох яамд дүрэм журмаа боловсруулж байна гэсэн мэдээлэл л өгч байна. Сурч боловсрох эрхийн хэрэгжилтэд ахиц гаргахын тулд тусгаарласан буюу тусгай боловсролын тогтолцооноос татгалзаж, тэгш хамруулах боловсролын тогтолцоог бүрдүүлэх хэрэгцээтэй байгаа ч энэ чиглэлээр бодит ахиц гарсангүй. Өмнө нь хэрэгжиж байсан хууль, дүрэм журмаар л ажил явж байна. Сурч боловсрох эрхийн бодит хэрэгжилтэд тодорхой ахиц гарсангүй.

**108.153. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлээрх нааштай хүчин чармайлтаа үргэлжлүүлэх /Аргентин/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.152-оос үзнэ үү.

**108.154. Бүх төрлийн ялгаварлан гадуурхалт, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настай хүмүүсийн эрхийг хамгаалах тодорхой хууль батлах /Турк/**

Хэрэгжих шатанд. Ялгаварлан гадуурхалтыг хориглох хууль батлах тухай мэдээллийг 108.19-өөс үзнэ үү. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай хуулийг 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр, Ахмад настны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр баталсан. Гэвч хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр хүчин чармайлт тавихгүй, хуучин арга барилаараа ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 6-р зүйлд ялгаварлан гадуурхалтын асуудлыг цогцоор тусгаж оруулсан ч, ялгаварлан гадуурхсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг орхигдуулсан нь сул зохицуулалт болсон. Зөрчлийн тухай хуулиар зөвхөн хүүхдийг хөгжлийн бэрхшээлээр ялгаварласан тохиолдолд 300000 (125 ам.доллар) төгрөгөөр торгохоор хуульчилсан.

**108.155. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл хөгжлийг баталгаажуулсан хамран сургалтанд ач холбогдол өгсөн, боловсролын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх /БНХАУ/**

Хэрэгжих шатанд. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тогтоох эрүүл мэнд, халамжийн загвараас нийгмийн загварт шилжих үйл явц өрнөж байна. Засгийн газрын 2016 оны 200 дугаар тогтоолын дагуу бүх орон нутагт байгаа "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс" хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоож, улмаар хүүхдийг шаардлагатай гэж үзвэл боловсрол, эрүүл мэнд, халамжийн үйлчилгээнд хамруулах чиг үүрэгтэй. 2017 онд уг үйлчилгээнд 2185 хүүхэд хамрагдан дээрх комиссын 200 гаруй гишүүд чадавхжуулах сургалт, арга хэмжээнд хамрагджээ. Мөн БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн 60,0 тэрбум төгрөгөөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн үндэсний төв баригдаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн үндэсний төв нь 250 ортой амбулаторийн нөхөн сэргээх төв, хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг илрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт сэргээн засах эмчилгээнд хамруулах, тэдэнд зориулсан энгийн ортопедийн туслах хэрэгсэл хийж өгөх, эцэг эхчүүд, гэр бүлийнхэнд зориулсан сургалтыг зохион байгуулах зэрэг үйлчилгээ үзүүлнэ.

Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын чиглэлээр хэрэгжүүлж байгаа бодлого нь тэгш хамран сургах бодлоготой нийцэхгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэгш хамран сургах чиглэлээр Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дагуу дүрэм, журам батлах ёстой ч өнөөдрийг хүртэл баталсангүй. Тэгш хамран сургах боловсролын чиглэлээр

Үндэсний хөтөлбөр гаргах тухай сүүлийн 4 жил ярьж байна. Хийж буй ажил нь тусгай сургуулийг дэмжих, хөгжүүлэхэд чиглэж байгаа нь “тэгш хамран сургах” үзэл баримтлалтай зөрсөөр байна.

**108.156. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тухай олон нийтийн ойлголтыг сайжруулах замаар тэдний боловсрол эзэмших тэгш боломжийг хангах /Турк/**

Хэрэгжих шатанд. Холбогдох мэдээллийг 108.155-аас үзнэ үү. Хөгжлийн бэрхшээлтэй найзаа дэмжих сэтгэл зүйг хүүхэд, өсвөр үеийнхэнд бий болгох зорилгоор ном бэлтгэж, дунд сургуулийн бүх бага ангийн сурагчдад, "ярьдаг гар" дохионы хэлний сурах бичгийг, дагалдах материалын хамт эцэг эх, асран хамгаалагчдад түгээсэн нь нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлах хандлагыг бүүруулах, харилцааг хөгжүүлэхэд хийсэн дэвшилттэй ажил болжээ. Гэвч хүний эрхэд суурилсан дэвшилттэй ажлууд ихэвчлэн олон улсын төсөл, хөтөлбөрөөр хийгдэж байна.

Нөгөө талаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар УИХ-ын гишүүд, БСШУСЯ, орон нутгийн засаг дарга, ИТХ-ын дарга, сургуулийн захирлууд, эцэг эхчүүдийн хандлага өөрчлөгдөхгүй байна. Тухайлбал, БСШУС-ын сайдын 2017 оны А/195-р тушаалд зөвхөн тусгай цэцэрлэг, сургуулийн зардлыг улсын төсөвт тусгуулахаар заасан нь тэгш хамран сургах зарчимтай зөрчилдөж байна. Хандлага өөрчлөх ажил ч хийгдэхгүй байна.

**108.157. Боловсролын тогтолцоогоо улам бэхжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсрол эзэмших тэгш боломжийг хангах /Лаос/**

Хэрэгжээгүй. Монгол Улсын Засгийн Газар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуусын боловсролыг тусгай сургуулиар шийдэх гэсэн хандлагаа барьсаар байна. Тухайлбал, тусгай сургууль, цэцэрлэгийг хөгжүүлэхэд илүүтэй анхаардаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай шинэ хуульд “боловсролд тэгш хамран сургах” үзэл баримтлалыг олон улсын зарчимд нийцүүлэн тусгасан хэдий ч хэрэгжилтэд хуучин хандлагаа барьсаар байна. Тухайлбал, багш нарыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга барилд сургах ажил хийгдэхгүй, сургуулиудад налуу зам, тэмдэг, тэмдэглэгээ, ариун цэврийн өрөө зэрэг нь хүртээмжгүй хэвээр байна.<sup>63</sup> БСШУСЯ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролыг хариуцсан хэлтэстэй болсон ч орон нутгийн боловсролын газрууд хариуцсан хүнгүй байна. Цаашид тэгш хамран сургах боловсролыг Монгол Улсад хөгжүүлэхийн тулд тогтвортой ажиллах Үндэсний хөтөлбөр шаардлагатай.

**108.158. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидын эрх, түүний дотор нөхөн үржихүй, хүчирхийлээс ангид байх, хөдөлмөрлөх, боловсрол эзэмших болон шийдвэр гаргах түвшинд оролцох эрхүүдэд онцгой анхаарал хандуулах /Тайланд/**

Хэрэгжээгүй. ХНХЯ, БСШУСЯ, ЭМЯ хамтран "хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил, оролцоог дэмжих үндэсний хөтөлбөр боловсруулан Засгийн газрын 2017 оны 11 сарын 29-ний өдрийн хурлаар батлуулжээ. Ерөнхий сайдын шууд удирдлагад зөвлөл, яамдад дэд зөвлөл, засаг даргын дэргэд дэд зөвлөл бий болгох замаар төлөвлөгөөнд санал оруулах боломжтой болсон ч ажил нь жигдрээгүй, үр дүн нь гарч эхлээгүй байна. Гэвч хөгжлийн бэрхшээлтэй хүн, тэр дундаа эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшинд оролцуулах талаар хийж байгаа ажил байхгүй байна.

Хэдийгээр Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоог дэмжих үндэсний хөтөлбөр баталсан нь сайшаалтай ч хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн асуудлыг эмнэлэг, эрүүл мэнд талаас нь хамгаалсан заалт илүүтэй тусгагдаж, эрх мэдэлжүүлэх, хөгжүүлэх, бие даасан байх эрхийг нь дэмжсэн зүйл заалт огт тусгагдаагүй. Гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлаар хөгжлийн бэрхшээлтэй



эмэгтэйчүүдийн мэдлэг, мэдээлэл муу. Тэргэнцэртэй эмэгтэйчүүдийн хувьд эмнэлэг рүү орох ч боломжгүйн зэрэгцээ, төрөх тохиолдолд тусгай ор нь ч байдаггүй. Мөн эмч, эмнэлгийн ажилтны харилцаа, хандлага таагүй. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй жирэмсэн эмэгтэйд “өөрийгөө яаая гэж байж гаргаж чадах уу, өсгөж чадах уу” гэх зэрэг таагүй асуулт тавьдаг. Мөн үрийн сувгийг боох, хараагүй эмэгтэйчүүдийг гэр бүлийнх нь авч яваад аборт хийлгэх гэх мэт зөрчил гардаг.

Үндэсний хөтөлбөрт хамгаалах байранд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тохирох хэрэглэгдэхүүнийг бий болгох тухай тусгагдсан ч хэрэгжээгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд бүх хэлбэрийн хүчирхийлэлд их өртөж байна. Биеэ хамгаалах чадваргүйг нь ашиглан хүчиндэх тохиолдол ч гардаг. Гэсэн хэдий ч цагдаа, нийгмийн ажилтнууд хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллах ойлголт хангалтгүй байна.

**108.160. Орогнол хүсэгчид буцаахгүй байх зарчмын дагуух эрх болон бусад эрхээ эдлэх бололцоог нь хангах чиглэлээр Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Дээд комиссарын газартай хамтран ажиллах /Уругвай/**

Хэрэгжсэн. Монгол Улс НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газартай 2007 онд “Хамтын ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулсан.Тиймээс энэ чиглэлээр холбогдох хууль журмын дагуу хамтран ажиллаж байна. Тухайлбал, 2018 оны 01 дүгээр сарын байдлаар 2017 онд гадаадын 5 дүрвэгсдийн асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн.<sup>64</sup> Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газраас 2017 оны 11 дүгээр сард зохион байгуулсан олон улсын дүрвэгсдийн хамгаалалтын асуудлаарх сургалтад ГХЯ, ХЗДХЯ, ХЭҮК, ХХЕГ, ГИХАЭА болон төрийн бус байгууллагууд хамрагдсанаас гадна 2018 оны IV улиралд онцгой байдлын үед дүрвэгсдийн асуудлаар авах арга хэмжээний талаар дотоодын холбогдох байгууллагуудад зориулж ДАЭДКГ-тай хамтран сургалт зохион байгуулахаар төлөвлөж байгаа юм байна.<sup>65</sup>

**108.161. Миниматагийн конвенцийг соёрхон батлах асуудлыг судлан үзэж, бичил уурхай эрхлэгчдийн олборлох эрхийг хангах, тэдгээрийн үйл ажиллагааг аль болох хурдан хугацаанд албажуулах зорилгоор Ашигт малтмалын тухай хуулийн бичил уурхайн талаарх 4 дүгээр зүйлийн 4.1.23 дахь заалтыг шинэчлэх /Унгар/**

Хэрэгжих шатанд. Монгол Улс мөнгөн усны хэрэглээг бууруулах, ард түмний эрүүл мэндийг сахин хамгаалах, хүрээлэн буй байгаль орчин, хөрсийг бохирдуулахгүй байх үүднээс Монгол Улс 2015 оны 9 сарын 18-ны өдөр Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцийг соёрхон баталсан.

Тус конвенцийн хэрэгжилтийн хүрээнд "Алтны бичил уурхайгаас үүдэлтэй бохирдлыг бууруулах үйл ажиллагааны Үндэсний хөтөлбөр" боловсруулах төслийг БОАЖЯ болон НҮББОХ-өөс хамтран хэрэгжүүлж байгаа. Даян дэлхийн байгаль орчны сангаас төслийн санхүүжилтэд 500,000\$ зарцуулж байгаа. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 9-р сарын 12-ны өдрийн А/268 дугаар тушаалаар Минаматагийн конвенцийн хавсралт “с” хэсэгт заасны дагуу “Алтны бичил уурхайгаас үүдэлтэй бохирдлыг бууруулах үндэсний төлөвлөгөө”-ний төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.<sup>66</sup> Гэвч бичил уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөг дорвитой бууруулж чадаагүй байна. Сэлэнгэ аймгийн бичил уурхай эрхлэгч иргэдийн дунд мөнгөн усны хэрэглээ их байгаа бол Увс аймагт сургуулийн дотуур байр, цэцэрлэг дээр насанд хүрээгүй хүүхэд мөнгөн ус асгасан, тараасан үйл явдал гарсан нь мөнгөн усны импорт, хэрэглээнд төрөөс үр нөлөөтэй хяналт, арга хэмжээ авч чадахгүй байгааг харуулж байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.23 дахь заалтыг шинэчлэн боловсруулах ажил хийгдээгүй боловч Засгийн газрын 2010 оны 308 дугаар тогтоолоор баталсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг боловсронгуй болгож Засгийн газрын 2017 оны 153 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан байна. Аюулгүй байдал, хүний эрхийн санаачилгын талаарх Сайн дурын зарчимд нэгдэн орох боломжийг судлан, тодорхой шийдвэр гаргахаар төлөвлөсөн ч одоогоор дорвитой ажил хийгээгүй. Тиймээс 3 арга хэмжээний 2 нь хэрэгжсэн гэж болохоор байна. Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцийг УИХ соёрхон баталсан ч хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөр, төсвийг батлаагүй. Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааг албажуулах зорилгоор Ашигт малтмалын тухай хуулийн бичил уурхайн талаарх 4 дүгээр зүйлийн 4.1.23 дахь заалтыг шинэчлэн ЗГ-ын 2017 оны 151-р тогтоолоор журам шинэчлэн боловсруулж мөрдөж байна. Энэ журмыг хэрэгжүүлэхдээ аймгийн ЗД нар өөрийн карманы бичил уурхайн нөхөрлөл байгуулж байгаа нь зорилтот бүлэг дээр хэрэгжихгүй байна.

**108.162. НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн Удирдах зарчмуудыг хэрэгжүүлэх үүднээс нүүдэлчин малчдын нөхцөл байдал, эрхээ сэргээлгэх боломжийг сайжруулахад онцгой ач холбогдол өгсөн Үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөг боловсруулах /Нидерланд/**

Хэрэгжээгүй. Энэ зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар ИНБ-ууд удаа дараа шаардаж ирсэн ба ЭЗНСЭ-ийн хорооны 6-р илтгэлийн дагуу өгсөн зөвлөмжид мөн энэ зөвлөмжтэй холбоотой байх тул хамтад нь хэрэгжилтийг тогтмол ажиглаж ТББ-ууд хамтран ажиллахаа илэрхийлж байгаа. Гэсэн хэдий ч НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн Удирдах зарчмуудыг судлах, нүүдэлчин малчдын өрхийн бизнес, амьжиргааны эх үүсвэр, малын бэлчээрийг хамгаалах үндэсний хөтөлбөр гаргах талаар судалгаа ч хийгдээгүй байна. Харин ЗГ-ын тайланд судалгаа хийж байгаа гэж тайлагнасан нь үндэслэл муутай. Мөн ИНБ-ууд Аархусын конвенцэд нэгдэх асуудлаар 2014 оноос эхлэн нөлөөллийн ажлууд хийсэн ч ЗГ-аас дэмжээгүй, ГХЯ одоог хүртэл судалж байгаа гэх тайлбараас өөр зүйл хийгдэхгүй байна. Иймд бизнесийн үйл ажиллагаанаас тогтвортой хөгжилд үзүүлэх сөрөг нөлөөлөл их, эрх чөлөө зөрчигдсэн тохиолдолд эрхээ сэргээлгэхээр шүүхэд хандах эрх Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар баталгаажсан ч шүүгчдийн нийтийн эрх ашгийн асуудалд хандах мэдлэг хандлага хуучин хэвээр, аж ахуйн нэгжид илт давуу байдлаар үйлчилж нэхэмжлэлийг хүлээж авахгүй байх, хэргийг хэрэгсэхгүй болгох, төрийн байгууллагууд шүүхэд нөлөөлөх байдал түгээмэл гарч байгаа тул бизнесийн үйл ажиллагаанаас төр иргэнээ хамгаалж чадахгүй хэвээр байна.

**108.163. Олборлох үйлдвэрлэлийн салбарт аюулгүй байдлыг тогтоохдоо хүний эрхийг хангах зорилгоор Аюулгүй байдал, хүний эрхийн санаачилгын талаарх Сайн дурын зарчимд нэгдэх /АНУ/**

Хэрэгжээгүй. Энэ зөвлөмжийг ЗГ хүлээж авсан. Энэ нь хэрэгжүүлэх үүрэгтэй гэдгээ ухамсарласан үйлдэл хэдий ч Зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөндөө ямар ч ажил төлөвлөгөөгүй болно. "Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах тухай хууль"-ийн төсөл боловсрогдож, ажлын хэсэг байгуулагдсан.

**108.164. Гар аргаар ашигт малтмал олборлож буй иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, байгаль орчныг хамгаалах зорилгоор тус салбар дахь мөнгөн усны хэрэглээг зохицуулсан үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх /Швейцари/**

Хэрэгжээгүй. “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг боловсронгуй болгож Засгийн газрын 2017 оны 153 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан. Харин Ашигт малтмалын тухай хууль болон Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмаар зохицуулах боломжгүй асуудлыг Уул уурхайн тухай хуулийн төсөлд тусгасан байгаа ч энэ нь хүний эрхэд суурилсан

хандлагаар хандаагүй, зөвхөн олборлосон алтыг Монгол банканд тушаах харилцааг илүү зохицуулсан байна. Бичил уурхай эрхлэгчдийн олборлосон алтнаас бусад жонш, нүүрс, өнгөт чулуу, давс зэргийг хэрхэн хянах, тэдэнд хэрхэн төрийн үйлчилгээг хүргэх, өөр ажлын байранд шилжүүлэх талаар ямар ч бодлого, арга хэмжээ байхгүй байна. Мөн бичил уурхай эрхлэгчдийн нэрээр ченжүүд ихээхэн ашиг олж байгаад хяналт бүртгэл хийж чадахгүй байгаа бөгөөд хил гаалиар ченжүүдийн экспортолж байгаа баялгийн гарал үүслийг тодорхойлох, татвараа бүрэн авах асуудлыг зохицуулж чадахгүй байна. Өөрийн орлогогүй, амьжиргааны эх үүсвэргүй, малаа алдсан зэрэг иргэд бага хөлстэй, хүнд хөдөлмөр эрхэлсээр байна.

<sup>1</sup> ХЭФ, “UPR зөвлөмжийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт, стратеги”, ХЭФ, UPR-Info ОУБ-тай хамтарсан семинар, 2015 оны 5-р сарын 27-29-ний өдөр

<sup>2</sup> Иргэний улс төрийн эрхийн баг ахлагч Б.Баттогтох ([battogtokh1371@yahoo.com](mailto:battogtokh1371@yahoo.com)), Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн багийн ахлагч Н.Баярсайхан ([swb\\_bayar@yahoo.com](mailto:swb_bayar@yahoo.com)), Хүүхдийн эрхийн багийн ахлагч П.Цэвээн ([tzeveen@yahoo.com](mailto:tzeveen@yahoo.com)), Эмэгтэйчүүдийн эрхийн багийн ахлагч Ш.Ариунаа ([ariunaa.shag@gmail.com](mailto:ariunaa.shag@gmail.com)), Ялгаварлан гадуурхалтын эсрэг багийн ахлагч Д.Мөнхтуяа ([munkhtuya@lgbtcentre.mn](mailto:munkhtuya@lgbtcentre.mn)) нар ажилласан.

<sup>3</sup> ГХЯ-аас ХЭФ-д ирүүлсэн тайлбар, 108.17-р зөвлөмж

<sup>4</sup> ГХЯ-аас ХЭФ-д ирүүлсэн тайлбар, 108.18-р зөвлөмж

<sup>5</sup> ХЭФ-д хандан ХЗДХЯ-наас ирүүлсэн тайлбар бичиг, 108.41, 108.55, 108.56-р зөвлөмж

<sup>6</sup> ХЭФ-д хандан ХЗДХЯ-наас ирүүлсэн тайлбар бичиг, 108.23-р зөвлөмж

<sup>7</sup> Хуулийн шүүмж, цуврал №21, 22, 23, 24, 2018 оны 6-р сар, [www.forum.mn](http://www.forum.mn)

<sup>8</sup> ХЭФ, ХЭҮК-той хамтарсан орон нутгийн хэлэлцүүлэг, ХЭФ, UPR-Info байгууллагатай хамтран зохион байгуулсан бүсийн хэлэлцүүлэг, үндэсний хэлэлцүүлгийн тэмдэглэлээс

<sup>9</sup> ХЭФ-д хандан ХЗДХЯ-наас ирүүлсэн тайлбар бичиг, 108.30-р зөвлөмж

<sup>10</sup> Монгол Улсын Засгийн газар, 2009 оны 362, 2017 оны 193 дугаар тогтоол, [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)

<sup>11</sup> ГХЯ-аас ХЭФ-д ирүүлсэн тайлбар, 108.37-р зөвлөмж

<sup>12</sup> ГХЯ-аас ХЭФ-д ирүүлсэн тайлбар, 108.39-р зөвлөмж

<sup>13</sup> ХЭФ-д хандан ХЗДХЯ-наас ирүүлсэн тайлбар бичиг, 108.41, 108.55, 108.56-р зөвлөмж

<sup>14</sup> Хөтөлбөрийн 3.3.14 дэх заалт: 3 хүртэл насны хүүхэдтэй ээжүүдийн нийгмийн баталгааг сайжруулах “Цалинтай ээж” хөтөлбөр хэрэгжүүлж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа нь тасрахгүй байх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

<sup>15</sup> Энэ хуулийн зорилт нь жирэмсэн эх, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх, дөрөв хүртэлх насны ихэр хүүхэдтэй эх, эцэг, гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

<sup>16</sup> Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, УИХ, 1994 он, 19<sup>2</sup> дугаар зүйл.

<sup>17</sup> 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулж, 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр болсон. (Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3.3 дахь заалт).

<sup>18</sup> Concluding observations on the eight and ninth periodic reports of Mongolia, CEDAW, CEDAW/C/MNG/CO/8-9, para 16

<sup>19</sup> Зүүлт vi үзнэ үү. Para 45

<sup>20</sup> ГХЯ-аас ХЭФ-д ирүүлсэн тайлбар, 108.49-р зөвлөмж

<sup>21</sup> “Монгол улсын нийгмийн халамжийн хөтөлбөрүүд үр шим хүртэгчдийн байдалд хийсэн дүн шинжилгээ”, 2017 он. Дэлхийн банк, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам

<sup>22</sup> ГХЯ-аас ХЭФ-д ирүүлсэн тайлбар, 108.52-р зөвлөмж

<sup>23</sup> Эрүүгийн хууль УИХ, 2015.12.03, [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn), 14 дүгээр бүлгийн 14.1 дүгээр зүйл

<sup>24</sup> ЛГБТ төвийн НҮБ-ын Хүний эрхийн хороонд илгээсэн мэдээлэл, [http://tbinternet.ohchr.org/\\_layouts/treatybodyexternal/Download.aspx?symbolno=INT%2fCCPR%2fCO%2fMNG%2f24697&Lang=en](http://tbinternet.ohchr.org/_layouts/treatybodyexternal/Download.aspx?symbolno=INT%2fCCPR%2fCO%2fMNG%2f24697&Lang=en), Зүйл 21, 22

<sup>25</sup> ХЭФ-д хандан ХЗДХЯ-наас ирүүлсэн тайлбар бичиг, 108.60-р зөвлөмж  
<sup>26</sup> Эрүүгийн хууль УИХ, 2015.12.03, [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn), 15 дугаар бүлгийн 15.6 дугаар зүйл  
<sup>27</sup> Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <http://www.legalinfo.mn/law/details/9617>  
<sup>28</sup> ЭМЯ-ны асуудал хариуцсан мэргэжилтэнтэй ярилцсан ярилцлага, 2018 оны 5-р сарын 22.  
<sup>29</sup> **ХЗДХЯ-ны** 2018 оны 6-р сарын 21-ний өдөр ХЭФ-д ирүүлсэн 1-3/3141 тоот албан бичиг  
<sup>30</sup> Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл, ХЭҮК, 2017 он, 144-р тал  
<sup>31</sup> ШШГЕГ-ын харуул хамгаалалтын дарга, дэд хурандаа Мөнх-Эрдэнэтэй хийсэн ярилцлагаас.  
<sup>32</sup> ШШГЕГ-ын харуул хамгаалалтын дарга, дэд хурандаа Мөнх-Эрдэнэтэй хийсэн ярилцлагаас.  
<sup>33</sup> ХЭФ-д хандан ХЗДХЯ-наас ирүүлсэн тайлбар бичиг, 108.82-р зөвлөмж  
<sup>34</sup> Цагдаагийн албаны тухай хууль, УИХ, 2017.02.09, [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn), 17 дугаар зүйл  
<sup>35</sup> ХЭФ-д хандан ХЗДХЯ-наас ирүүлсэн тайлбар бичиг, 108.73-р зөвлөмж  
<sup>36</sup> Дүгнэлт зөвлөмж, НҮБ-ын Хүний эрхийн хороо, [file:///C:/Users/khishgee.OSFORUM/Downloads/G1724345%20\(1\).pdf](file:///C:/Users/khishgee.OSFORUM/Downloads/G1724345%20(1).pdf), фара 21  
<sup>37</sup> Эрүүгийн хууль, УИХ, 2015.12.03, [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn), 10 дугаар бүлгийн 10.1.2.12 дугаар зүйл  
<sup>38</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, УИХ, 2017.06.09, [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn), 210 дугаар зүйл, [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)  
<sup>39</sup> ХЭФ-д хандан ХЗДХЯ-наас ирүүлсэн тайлбар бичиг, 108.82-р зөвлөмж  
<sup>40</sup> ХЭФ-д хандан ХЗДХЯ-наас ирүүлсэн тайлбар бичиг, 108.84-р зөвлөмж  
<sup>41</sup> Эрүүгийн хууль, УИХ, 2015.12.03, [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn), 11 дүгээр бүлгийн 12.4 дүгээр зүйл  
<sup>42</sup> Эрүүгийн хууль, УИХ, 2015.12.03, [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn), 11 дүгээр бүлгийн 12.1 дүгээр зүйл, 12.1.2.3  
<sup>43</sup> ГХЯ-аас ХЭФ-д ирүүлсэн тайлбар, 108.89-р зөвлөмж  
<sup>44</sup> ХЭФ-д хандан ХЗДХЯ-наас ирүүлсэн тайлбар бичиг, 108.91-р зөвлөмж  
<sup>45</sup> ХЭФ-д хандан ХЗДХЯ-наас ирүүлсэн тайлбар бичиг, 108.98-р зөвлөмж  
<sup>46</sup> ХЭФ-д хандан ХЗДХЯ-наас ирүүлсэн тайлбар бичиг, 108.92-р зөвлөмж  
<sup>47</sup> ХЭФ-д хандан ХЗДХЯ-наас ирүүлсэн тайлбар бичиг, 108.98-р зөвлөмж  
<sup>48</sup> Эрүүгийн хууль, УИХ, 2015.12.03, [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn), 11 дүгээр бүлгийн 11.7 дугаар зүйл  
<sup>49</sup> Эрүүгийн хууль, УИХ, 2015.12.03, [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn), 16 дугаар бүлгийн 16.2, 16.6, 16.8, 16.9, 16.10 дугаар зүйл  
<sup>50</sup> Хуучин Эрүүгийн хууль, УИХ, 2002.01.03, [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn), 121 дүгээр зүйл  
<sup>51</sup> [www.shuukh.mn](http://www.shuukh.mn), 2018 оны 01 сарын 12-ны Баянзүрх дүүргийн шүүхийн 95 дугаар шийтгэх тогтоол, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 04 сарын 05 336 Дугаар тогтоолоос  
<sup>52</sup> Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, УИХ, 2012.01.19, [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn), 16.3 дугаар зүйл  
<sup>53</sup> ХЭФ-д хандан ХЗДХЯ-наас ирүүлсэн тайлбар бичиг, 108.122-р зөвлөмж  
<sup>54</sup> ХЭФ-д хандан ХЗДХЯ-наас ирүүлсэн тайлбар бичиг, 108.122-р зөвлөмж  
<sup>55</sup> ГХЯ-аас ХЭФ-д ирүүлсэн тайлбар, 108.123-р зөвлөмж  
<sup>56</sup> ХЭФ-д хандан ХЗДХЯ-наас ирүүлсэн тайлбар бичиг, 108.125-р зөвлөмж  
<sup>57</sup> Монгол Улсын Засгийн газар, <http://cabinet.gov.mn/news.php?n=503>  
<sup>58</sup> Цагдаагийн ерөнхий газрын мэдээллээс.  
<sup>59</sup> Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, [www.legalinfo.mn/law/?subcat=185&cat=35](http://www.legalinfo.mn/law/?subcat=185&cat=35)  
<sup>60</sup> “Монгол Улсын нийгмийн халамжийн хөтөлбөрүүд үр шим хүртэгчдийн байдалд хийсэн дүн шинжилгээ”, 2017 он, Дэлхийн банк, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам  
<sup>61</sup> “Хогийн цэг дээр ажиллагсдын ажлын байрны аюулгүй орчны нөхцөл байдал” судалгаа, 2017 он, Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо ТББ  
<sup>62</sup> Ховд аймагт болсон хэлэлцүүлгийн тэмдэглэлээс  
<sup>63</sup> “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба боловсрол судалгаа”, ЖАЙКА институт, МУ, 2014  
<sup>64</sup> ХЭФ-д хандан ХЗДХЯ-наас ирүүлсэн тайлбар бичиг, 108.160-р зөвлөмж  
<sup>65</sup> ГХЯ-аас ХЭФ-д ирүүлсэн тайлбар, 108.160-р зөвлөмж  
<sup>66</sup> БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаас ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад илгээсэн 03/3584 тоот албан бичгээс эх сурвалж болгов.